



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОН 04 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр, Баасан гараг**

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-10
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	11-61
<hr/>	
<i>1.Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /УИХ-ын гишүүн Б.Энхбаяр нарын 3 гишүүн 2022.09.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/</i>	11
<i>2.“Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	11-22
<i>3.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.12.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	12-29
<i>4.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /Монгол Улсыг гадаадад сурталчлах бодлого, стратеги, хамтын ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээний талаар/</i>	29-52
<i>5.Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонсох</i>	54
<i>6.Засгийн газрын гишүүдийн тангараг өргөх ёслолын ажиллагаа</i>	54-61

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
04 дүгээр сарын 07-ны өдөр /Баасан гараг/-ийн  
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 73 гишүүнээс 42 гишүүн хүрэлцэн ирж, 57.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 08 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Анандбазар, С.Ганбаатар;

Чөлөөтэй: Ж.Ганбаатар, Ч.Ундрэм;

Эмнэлгийн чөлөөтэй: Д.Батлут, Н.Наранбаатар, Ш.Раднаасэд, Д.Цогтбаатар;

Тасалсан: Х.Нямбаатар, Ж.Сүхбаатар, Ц.Туваан;

Хоцорсон: Т.Аубакир-17 минут, С.Батболд-1 цаг 09 минут, Э.Батшугар-2 цаг 25 минут, Д.Ганбат-20 минут, Л.Мөнхбаатар-21 минут, С.Одонтуяа-1 цаг 09 минут, Ц.Сэргэлэн-11 минут, Б.Чойжилсүрэн-1 цаг 26 минут, Б.Энх-Амгалан-23 минут, Т.Энхтүвшин-2 цаг 36 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Ардчилсан намын гишүүдэд Ардчилсан нам байгуулагдсаны 33 жилийн ойн баярын мэндийг дэвшүүлэв.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт буцаах талаар Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан горимын саналыг уламжлав.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 14

Бүгд: 43

67.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт дахин хэлэлцүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв./10:12/

***Нэг.Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /УИХ-ын гишүүн Б.Энхбаяр нарын 3 гишүүн 2022.09.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан “Азтай савар” Төрийн бус байгууллагын тэргүүн Ц.Зориглон, мөн Төрийн бус байгууллагын зохицуулагч Э.Бүжинлхам, удирдах зөвлөлийн гишүүн З.Золзаяа, Ц.Болормаа, Д.Оюун-Эрдэнэ, мөн Төрийн бус байгууллагын хуульч Б.Алтаншагай, “Өмгөөллийн легал гайд” ХХК-ийн хуульч Э.Анударь, мөн ХХК-ийн эрх зүйч Н.Баясгалан, “Эм-Ди-Эс Хаан Лекс” хуулийн фирмийн хуульч М.Ариунзул нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар нар байлцав.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	31
Татгалзсан:	14
Бүгд:	45

68.9 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 10 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр. “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Занданшатар:** “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг бүхэлд нь батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 32  
Татгалзсан: 17  
Бүгд: 49  
65.3 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./10:17/*

*Уг асуудлыг 10 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.12.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн газрын ахлах мэргэжилтэн Б.Уранчимэг, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Хөдөө аж ахуйг дэмжих сангийн гүйцэтгэх захирал Б.Цогтсаран нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, Төсвийн байнгын хороо хариуцсан референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа, Б.Баттөмөр, Х.Булгантуяа, М.Оюунчимэг, Ц.Идэрбат, Т.Аубакир нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн, Улсын Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Хөдөө аж ахуйг дэмжих сангийн гүйцэтгэх захирал Б.Цогтсаран нар хариулж, тайлбар хийв.

*Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

### **Нэг.Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22  
Татгалзсан: 21  
Бүгд: 43  
51.2 хувийн саналаар дэмжигдлээ.

*Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

### **Хоёр.Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26  
Татгалзсан: 16  
Бүгд: 42  
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Хуулийн төсөл буцаах тухай” тогтоол баталсанд тооцов.

**Г.Занданшатар:** 2.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5-д заасныг үндэслэн “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооноос санаачлан боловсруулж, хэлэлцүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 17  
Бүгд: 42  
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 11 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.*

*Үдээс өмнөх хуралдаан 1 цаг 09 минут үргэлжилж, 11 цаг 17 минутад завсарлав.*

*Үдээс хойших хуралдаан 14 цаг 05 минутад эхлэв.*

**Дөрөв.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /Монгол Улсыг гадаадад сурталчлах бодлого, стратеги, хамтын ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээний талаар/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Соёлын дэд сайд М.Батбаяр, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр, мөн яамны Консулын газрын захирал Б.Болд, Гадаад сурталчилгаа, соёлын харилцааны захирал Д.Булган, Бодлого төлөвлөлтийн газрын захирал Г.Бямбасүрэн, Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын дэд захирал З.Баттүшиг, Хилийн хэлтсийн дарга Б.Гарьд, Санхүү, эдийн засгийн хэлтсийн ахлах нягтлан бодогч Ч.Цэнд-Аюуш нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн, Гадаад харилцааны хэлтсийн дарга Ц.Жамбалдорж, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг, мөн хэлтсийн референт Ж.Монголжингоо, Хяналт шинжилгээ, үнэлгээний албаны референт Г.Чингүүнжав нар байлцав.

Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг Монгол Улсыг гадаадад сурталчлах бодлого, стратеги, хамтын ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан цөөнхийн бүлгийг төлөөлж, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл үг хэлэв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, С.Одонтуяа, Н.Ганибал нарын асуусан асуултад Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Соёлын дэд сайд М.Батбаяр нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.13-т заасны дагуу Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяшаа нарын тавьсан асуултад Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Соёлын дэд сайд М.Батбаяр, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсыг гадаадад сурталчлах бодлого, стратеги, хамтын ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээний талаар Гадаад харилцааны сайд Б.Батцэцэгийн мэдээллийг сонслоо.

*Уг асуудлыг 15 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.*

*Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Хуулийн төсөл буцаах тухай” /Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай/ Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:42/*

*Үдээс хойших хуралдаан 15 цаг 42 минутад түр завсарлаж, 17 цаг 46 минутад эхлэв.*

**Тав.Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонсох**



Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, мөн газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Хууль, эрх зүйн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Дондогмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга С.Батбаатар, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газрын дарга А.Энхзул, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, Гадаад харилцааны хэлтсийн дарга Ц.Жамбалдорж, Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн нар байлцав.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад нэр дэвшигч Хүрэлбаатарын Булгантуяа, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны даргад нэр дэвшигч Буяагийн Тулга нарыг сайдаар томилох тухай саналыг Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ танилцуулав.

Ерөнхий сайдын танилцуулга болон нэр дэвшигчээс Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, С.Одонтуяа, Ц.Идэрбат нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, нэр дэвшигч, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонслоо.

*Уг асуудлыг 18 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.*

*Хуралдаан 18 цаг 12 минутад түр завсарлаж, 18 цаг 20 минутаас үргэлжлүүлэн хуралдав.*

### ***Зургаа.Засгийн газрын гишүүдийн тангараг өргөх ёслолын ажиллагаа***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, мөн газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Хууль, эрх зүйн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Дондогмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга С.Батбаатар, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газрын дарга А.Энхзул, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, Гадаад харилцааны хэлтсийн дарга Ц.Жамбалдорж, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн нар байлцав.

Ёслолын ажиллагааг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Төрийн ёслол, хамтын ажиллагааны газрын дарга Э.Одмөнх, мөн газрын шинжээч Б.Мөнхбилгүүн нар зохион байгуулав.

Танхимын зүүн хойд дэлгэцэн дээр “Монгол Улсын Засгийн газрын гишүүн би улсынхаа ашиг сонирхлыг эрхэмлэн, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг хүндэтгэж,



*Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, төрийн хууль биелүүлэх ажлыг төр, ард түмэн, Монгол Улсын Ерөнхий сайдын өмнө биечлэн хариуцаж, Засгийн газрын гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая. Миний бие энэ тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ.”* гэсэн Засгийн газрын гишүүний тангаргийн үг гарч байв.

“Их хуралдай” танхимын индрийн баруун талд Төрийн далбаа, танхимын голд Үндсэн хууль, тангаргийн бичиг, үзэг тавьж тусгайлан бэлтгэсэн ширээг сандлын хамт, түүний урд Засгийн газрын гишүүний тангараг өргөх ёслолд зориулан бэлтгэсэн индрийг байрлуулж, Төрийн сүлдний баруун талд хүндэт харуул зогссон байлаа.

Монгол Улсын Засгийн газрын гишүүний тангараг өргөх журмын дагуу тангараг өргөх ёслолын ажиллагаа эхлэв.

“Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг томилох тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжийг Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ танилцуулав.

*Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын 2020 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын гишүүний тангараг өргөх журмын 10-т заасны дагуу шинээр томилогдож буй Засгийн газрын гишүүдийн нэрийг дуудав.*

1.Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Хүрэлбаатарын Булгантуяа;

2.Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Буяагийн Тулга.

Нэр дуудагдсан Засгийн газрын гишүүд суудлаасаа босож индрээс *“Монгол Улсын Засгийн газрын гишүүн би улсынхаа ашиг сонирхлыг эрхэмлэн, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг хүндэтгэж, Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, төрийн хууль биелүүлэх ажлыг төр, ард түмэн, Монгол Улсын Ерөнхий сайдын өмнө биечлэн хариуцаж, Засгийн газрын гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая. Миний бие энэ тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ.”* хэмээн тангараг өргөв.

Тангараг өргөсний дараа Засгийн газрын гишүүд Төрийн сүлдэнд мэхийн ёсолж, Төрийн далбааны өмнө баруун өвдөг мэхийн сууж адис аван, “Их хуралдай” танхимын голд байрлуулсан ширээнд сууж, тангаргийн бичигт гарын үсэг зурж, Улсын Их Хурлын даргад тангаргийн бичгээ гардуулсны дараа Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын гишүүний үнэмлэх, энгэрийн тэмдгийг гардуулав.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Засгийн газрын 2 гишүүнд үнэмлэх, энгэрийн тэмдгийг гардуулж дууссаны дараа Монгол Улсын Төрийн дууллыг “Их хуралдай” танхимд эгшиглүүлэхэд хуралдаанд оролцогсад суудлаасаа босож хүндэтгэл үзүүлэв.

Төрийн дуулал эгшиглэж дуусмагц Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд баяр хүргэж, үг хэлэв.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Улсын Их Хурлын дарга болон Улсын Их Хурлын гишүүдэд хандан мэхийн ёслов.

Тангараг өргөх ёслолын ажиллагаа 18 цаг 27 минутад өндөрлөв.

***Өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг танилцуулах***

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 4 гишүүнээс 2023.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 2 гишүүнээс 2023.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Төрийн байгуулалтын байнгын хороонд хуваарилсныг танилцуулав./15:42/

***Бусад.*** Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатарын урилгаар Увс аймгийн Баруунтуруун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2002 оны төгсөгчид, Гадаадын иргэн, харьяатын газрын Агаарын замын боомт хариуцсан газрын алба хаагчдын төлөөлөл Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 6 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 3 цаг 19 минут үргэлжилж, 73 гишүүнээс 62 гишүүн хүрэлцэн ирж, 84.9 хувийн ирцтэйгээр 18 цаг 27 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр,  
Баасан гараг  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
10 цаг 08 минут.

### НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Ирц бүрдсэн байна. Ингээд Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сарын 7-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Гэрийн тэжээвэр амьтны хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Зарим байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудал, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл.

Үдээс хойших хуралдаанаар Ерөнхий сайдын мэдээлэл Монгол Улсыг гадаадад сурталчлах бодлого, стратеги, хамтын ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцэнэ.

Юуны өмнө өнөөдөр бас Монголын Ардчилсан нам үүсгэн байгуулагдсан өдөр тохиож байна. Ардчилсан намын гишүүддээ Ардчилсан нам байгуулагдсаны 33 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлье. Баярын хурал, үйл ажиллагаанд нь амжилт хүсье.

Түр байж байгаарай. Хэлэлцэх асуудалдаа орно.

**Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.**

Гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, хариулт авч дууссан. Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж хойшлуулах санал гаргасан. Хойшлуулж ирэх 7 хоногт хэлэлцье. Зарим заалтууд дээр Байнгын хорооны анхны хэлэлцүүлэгт нь буцаая гэсэн ийм горимын санал гаргасан. Энэ талаар Эдийн засгийн байнгын хороо, Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсье. Цэрэндамбын Цэрэнпунцаг гишүүн.

**Ц.Цэрэнпунцаг:** Гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе. Өчигдөр Пүрэвдорж гишүүн Байнгын хороон дээр анхны хэлэлцүүлэгт нь буцаая гэсэн санал гаргасан. Тэгээд бид нар бас ажлын хэсэгтэйгээ, Зам, тээврийн яамныхантайгаа ярилаа. Дараагийн 7 хоногт бас Байнгын хорооны хуваарь дээр тийм олон асуудал байхгүй, бололцоотой байгаа учраас Байнгын хороон дээрээ буцааж ярилцах нь зүйтэй гэж бодож байна. Тэгээд Пүрэвдорж гишүүний Байнгын хорооны анхны хэлэлцүүлэгт нь буцаая гэсэн саналаар санал хураалт явуулж өгөөч гэж Улсын Их Хурлын даргаас хүсье.

**Г.Занданшатар:** Бат-Эрдэнэ гишүүн хойшлуулчихъя тийм ээ? Хойшлуулчихъя гэж тохирсон тээ? Ажлын хэсгийн ахлагч хойшлуулъя гэсэн. Заавал санал хураалт явуулах ёстой юу? Энэ Ардчилсан намын бүлгийнхэн санал гаргачхаад өөрсдөө хаачив? Аюулгүй байдлын асуудал байна л гээд байсан. Санал хураалт явуулна. Горимын саналыг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя.

29 гишүүн дэмжиж, Эдийн засгийн байнгын хороонд Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын

төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт буцаалаа.

16.3-аар хуралдаанаар 1 асуудлыг хэлэлцэж эхэлсэн боловч түүний хэлэлцүүлгийг горимын саналаар хойшлуулсан тохиолдолд хуралдаан даргалагч дараагийн асуудлыг хэлэлцүүлнэ гэсэн. Ингээд Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

Энэ гишүүдээ Дэлгэрсайхан гишүүн, Төмөртоогоогийн Энхтүвшин гишүүд тэр нөгөө хөндөгдөөгүй заалт дээр гүйцээн боловсруулах чиглэл өгч болохгүй гээд Тамгын газар тэгж байгаа юм. Тэгэхээр бүхэлд нь анхны хэлэлцүүлэг явуулахаас өөр замгүй л байна. Дараагийн асуудалд орно.

**Нэг.Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.**

Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан байгаа. Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна.

Байнгын хорооны саналаар Гэрийн тэжээвэр амьтны хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Мал амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Статистикийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэрийн тэжээвэр амьтны хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалтад бэлдээрэй гишүүд.

Пүрэвдорж гишүүнээ таны гаргасан горимын санал дэмжигдсэн болохыг мэдэгдье. Та өөрөө байсангүй, эсрэг гарсан ч гэсэн. Төмөр замын тээврийн тухай хуулийг таны саналыг дэмжиж хойшлууллаа.

Одоо санал хураалт явуулна. Дэлгэрсайхан гишүүн, Оюунчимэг гишүүн суудалдаа сууя, санал хураалт явуулна. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн суудалдаа сууя, санал хураалт. Карт уншуулаарай. Таны гаргасан горимын саналаар санал хураалт явуулаад дэмжигдсэн та байсангүй, эсрэг дарчихсан учраас. Та 2 байхгүй байсан учраас би Ардчилсан намын ойн баярын мэнд дэвшүүллээ. Та хоёр байдаггүй хоцроод ингээд болдоггүй. Чинбүрэн гишүүн суудалдаа сууя. Адьшаа гишүүн эхлээд саналаа өгчхөөд та танхимаа тойр л доо Танхим тойрдгийг чинь ойлгож байна.

Санал хураалт явуулъя. Санал хураалт. Энэ огт байхгүй харилцааг, ер нь энэ харилцааг зохицуулаагүй үлдчихсэн цоорхой юм байна лээ л дээ.

68.9 хувийн саналаар санал дэмжигдлээ. Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлж байна. Ажлын хэсгийн залуучуудад баярлалаа. Дараагийн асуудалд оръё.

10.16 цаг

**Хоёр.Зарим байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэнэ.**

Улсын Их Хурдын тогтоолыг уншиж танилцуулъя. Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай.

1.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Төмөрбаатарын Аюурсайханыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны, Жамбалын Ганбаатарыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны, Тогмидын Доржхандыг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны бүрэлдэхүүнээс Монгол Ардын намын бүлгийн саналыг үндэслэн тус тус чөлөөлсүгэй.

2.Монгол Улсын Их Хурлын гишүүн Тогмидын Доржхандыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны, Төмөртоогоогийн Энхтүвшинг Эдийн засгийн байнгын хорооны, Нямаагийн Энхболдыг Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

Энэ тогтоолыг 2023 оны 4 дүгээр сарын 7-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Санал хураалт явуулъя. Зарим байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

Хөөе Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн суудалдаа сууя. Дамдинням, Цэрэнпунцаг гишүүн хоёр хөөе. Хөөе Цэрэнпунцаг гишүүн суудалдаа суу. Санал хураалт явуулах гэж байна. Саранчимэг гишүүн суудалдаа сууя. Санал хураалт, санал хураалт. Энд Адьшаа гишүүн байсан байна.

65.3 хувийн саналаар санал дэмжигдэж, тогтоолын төсөл батлагдлаа. Тогтоолыг уншиж

танилцуулсан. Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Ардчилсан намын бүлэг саналаа ирүүлбэл Адьшаа гишүүн. Бүлэг өөрийнхөө авсан суудлын тоогоор Байнгын хороонуудад хуваарилагддаг байхгүй юу. Тэгээд бүлэг өөрийнхөө тэр квот дотроо л хүнээ хасаад, нэмж оруулах саналаа бүлгийн дарга ирүүлбэл би уншиж танилцуулна. Ингээд Монгол Ардын намын бүлгээс санал ирээд л уншиж танилцуулсан. Дараагийн асуудалд оръё.

10.17 цаг

**Гурав.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.**

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Жигжидийн Батжаргал танилцуулна. Батжаргал гишүүнийг индэрт урьж байна.

**Ж.Батжаргал:** Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хийж анхны



хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2023 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн хуулийн хэрэгжих хугацааг ердийн журмаар тооцох, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал хуулийн төслийг төслийн хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг төсөл санаачлагчид нь буцаах, үүнтэй холбоотойгоор Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5-д заасныг үндэслэн Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооноос санаачлан боловсруулж, хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналуудыг тус тус гаргасан болно.

Байнгын хорооны зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг нэг бүрчлэн хэлэлцэж, дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол, анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын

хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүгдээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Батжаргал гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Хаянгаагийн Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Цэндгомбын Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Даваасүрэнгийн Есөн-Эрдэнэ, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Энхбаатарын Цолмонжаргал, Хөдөө аж ахуйг дэмжих сангийн гүйцэтгэх захирал Батжаргалын Цогтсаран, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Базаррагчаагийн Уранчимэг.

Байнгын хорооны санал дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Цагаанхүүгийн Идэрбат гишүүнээр тасаллаа. Бадарчийн Жаргалмаа гишүүн асуулт асууна.

**Б.Жаргалмаа:** Та бүхнийхээ өглөөний амгаланг айлтгая. Хэд хэдэн асуулт асууя. Засгийн газрын тусгай сан буюу Хөдөө аж ахуйг дэмжих санг корпорац болгосноороо ер нь юу өөрчлөгдөх юм бэ? Энэ мэдээллээс харах юм бол 72 хүн өнөөдөр ажиллаж байгаа. 43 хүнийг цомхотгочих замаар тариалангийн үйлдвэрлэлийг өсөн нэмэгдэж буй хэрэгцээ болон алслагдсан бүсийн үр тарианы үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх боломж нээгдэнэ гэсэн байна л даа. Ажилгүйчүүдийнхээ энийг нэмээд байх шиг байх юм.

Яг өнөөдрийн байдлаар тусгай сан хэчнээн хэмжээний хөрөнгөтэй байдаг

юм? Хөрөнгийн хэмжээг харах юм бол бас л бөөн зээл байгаад байгаа. 31.3 тэрбум төгрөг нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газрын зээл, 5.7 тэрбум төгрөг нь Монгол Улсыг хөгжүүлэх сангийн зээл, 0.2 тэрбум төгрөг нь Бүгд Найрамдах Беларус улсын зээлийн хөрөнгө гээд. Өөрийн үүсгэсэн хөрөнгө гэж байдаг юм уу Хөдөө аж ахуйн санд?

Өнөөдөр Монголчууд хүнсний хувьсгалаа хийх гээд Ерөнхийлөгч маань уриалга гаргаад хөдөө аж ахуйгаа дэмжье, тариаланчдаа дэмжье гээд ийм ажил, ажиллагаа явуулж байгаа. Корпорац болсноороо үнэхээр тариаланчдаа үр дүнгээ өгсөн үйл явдал болох уу, үгүй юү гэдэг дээр тариаланчдын саналыг сонсоход тэд өөрсдөө энэ сангаа нээлттэй хувьцаат компани болгон үйл ажиллагааг нь идэвхжүүлэх, өөрсдийн оролцоотой байлгах, хэн нэгнээс хараат бус байх тийм сонирхол бол маш өндөр байдаг юм билээ. Би тариалангийн бүс нутгийн хүн биш л дээ.

Гэхдээ бол тариаланчидтай олон удаа ярилцаж байсан учраас. Тэд ажиллах боломж маш ихээр эрэлхийлдэг. Хөнгөлөлттэй зээл авах, бусад зээлд хамрагдахад асуудалтай байдаг гэдэг зүйлийг бас тэд ярьдаг. Тэгвэл санг корпорац болсноор ер нь юу өөрчлөгдөх юм? Бидэнд өөр хувилбар байгаа юу? Магадгүй төслийн танилцуулга дээр КОВИД-ын цар тахлын хүнд үед хүн амын хүнсний хэрэгцээнд зориулан махны болон улаан буудайн нөөц бүрдүүлэх замаар хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнийн тогтвортой байдлыг хангах арга хэмжээ авах зайлшгүй шаардлага тулгарч байгаа гэсэн байна.

Бид КОВИД-ынхоо нөхцөл байдлыг даваад ногоон бүсдээ шилжчихсэн байгаа. Хамгийн зөв гаргалгаа мөн үү, үгүй юү гэдэг дээр Засгийн газар ямар байр суурьтай байгаа юм бол?

Ер нь тариалан эрхлэгчдийнхээ саналыг ер нь сонсоно уу? Корпорац болсноор яг юу өөрчлөгдөх юм бэ гэдэг дээр бас мэдээллийг өгөөч гэж хүсэж байна.

**Г.Занданшатар:** Хаянгаагийн Болорчулуун сайд хариулна.

**Х.Болорчулуун:** Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Хөдөө аж ахуйг дэмжих сан корпорац болсноороо юу өөрчлөгдөх юм бэ гэж байна. Олон зүйл өөрчлөгдөнө. Одоо бол Хөдөө аж ахуйг дэмжих сан төр төсвөөс цалинжаад ийм үрэлгэн байдалтай ажиллаж байна. Энэ байдлаараа цаашаа яваад байж болохгүй боллоо. Авлага, өглөг нь 200 тэрбумд аль аль нь эргэлдэж байна. Аж ахуйн тооцоон дээр ажиллаж чадахгүй байна, банк санхүүтэй бие даан харьцаж үйл ажиллагаа явуулж чадахгүй ийм болсон.

Тийм учраас бас өөрийн чинь сая асуудаг цаашидаа нээлттэй компани хувьцаат компани болгохыг бол тариаланчид одоо дэмждэг юм байна гэж хэлж байна. Яг компани корпорац болгож байж олон улс нийтийн, public компани болох ийм зорилготойгоор одоо санг өөрчилж байгаа юм.

Цаашидаа бол тариаланчдаа чиглэсэн дэмжлэгийг үзүүлнэ. Үр бордоо ч юм уу, бордооны дэмжлэг үзүүлэх, хөнгөлөлттэй дэмжлэг үзүүлэх. Мөн одоо Тариалан дэмжих санд 175000 тонны агуулах байдаг. Үүнийгээ ашиглан газар тариалан эрхлэгчдээ дэмжих, тэдний үр тариаг хадгалах, улсын нөөцийг бүрдүүлэх энэ бүх үйл ажиллагаа явуулахаас биш одоо байгаа шигээ үрэлгэн бүх юм руу ороод хувийн хэвшлийнхэнтэйгээ уралдаж ажиллаад, янз бүрийн техникийг гаднаас оруулж ирээд шахах байдлаар хөнгөлөлттэй зээл улс төрийн байдлаар тараадаг, өр үүсгэдэг энэ байдлыг таслан зогсоох үүднээс корпорац болж байгаа юм гэдгийг хэлье.



**Г.Занданшатар:** Бадарчийн Жаргалмаа. Хэн хариулах юм? Батжаргалын Цогтсаран, 82.

**Б.Цогтсаран:** Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Хөдөө аж ахуйг дэмжих сангийн 22 оны 12 сарын 31-ний байдлаар жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийсэн байгаа. Аудитын дүнгээс үндэслээд баталгаажсан дүнгээс хөрөнгийн эх үүсвэр нь нийт 384 тэрбумын хөрөнгөтэй. Үүнээс эргэлтийн хөрөнгө нь 301 тэрбум, харилцахад 3.5, бараа материал 77.7 тэрбумын бараа материалтай байна. Үндсэн хөрөнгө нь бол нийт 83 тэрбумын үндсэн хөрөнгөтэй гэсэн балансад туссан байдлаар байгаа юм байна.

**Г.Занданшатар:** Бадарчийн Жаргалмаа гишүүн тодруулж асууна.

**Б.Жаргалмаа:** Баярлалаа. Ерөнхийдөө бас хөрөнгөтэй юм байна. Ер нь өмнөх үйл ажиллагаанд ямарваа нэгэн аудитын дүгнэлт хийж байгаад үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх бас ийм шаардлага үүссэн байгаа байх гэж бодож байна. Ямар зөрчлүүд үүссэн юм бэ? Эцсийн эцэст иргэдийн гар дээр очиж байгаа гурил, будааны үнэ тогтвортой байх хамгийн эцсийн зорилго бол энэ байх гэж би бодож байна.

Тэгэхлээр өнөөдөр тариаланчид маань хураасан буудайгаа хадгалах элеватор байхгүй хөгжүүлээд хаячихлаа ч гэдэг юм уу тийм гомдол маш ихээр гардаг. Заавал гаднаас нөөц бүрдүүлэх шаардлагагүй гэдэг ийм зүйлийг маш ихээр ярьдаг шүү дээ тийм ээ? Тэгэхлээр энэ нөөцийн асуудал, хадгалалт хамгаалалтын асуудал ер нь ямар хэмжээнд байгаа юм? Ямар зөрчил үүссэн учраас бид энэхүү үйл ажиллагааг нь өөрчлөх болов? Баярлалаа.

**Г.Занданшатар:** Цэндгомбын Болорчулуун, 83. Бодлого, төлөвлөлт хэрэгжилтийн газрын дарга.

**Х.Болорчулуун:** Жаргалмаа гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Тэр сан бол анх 2005 онд одоо Буудай сан хэлбэрээр байгуулагдсан. Тариалан эрэлтийг дэмжих сан байж байгаад Мал хамгаалах сан хоёулаа нэгдэж Хөдөө аж ахуйг дэмжих сан болж үйл ажиллагаа явуулж ирсэн. Тэгэхдээ сангийн үйл ажиллагаанд бол жилийн турш л хяналт шалгалтын байгууллагын шалгалт доор явж ирсэн. Жилдээ Үндэсний аудитын газраас одоо 2 ч удаа санхүүгийн болон гүйцэтгэлийн аудит ордог байсан. Бусад Эрүүгийн цагдаа, Авлигатай тэмцэх газрын шалгалтууд бол удаа дараа орж байсан. Санхүүгийн үйл ажиллагаанд нь бол хяналт байнгын тавьж ирсэн.

Сүүлд 19-20 оны Сангийн санхүүгийн үйл ажиллагаанд Хүнс, хөдөө аж ахуйн яам Сангийн яамны хамтарсан шалгалт орсон. Ажлын хэсэг. Энэ шалгалтын дүнгээр бол ер нь үйл ажиллагааныхаа чиглэлийг өөрчлөх нь зүйтэй гэсэн ийм дүгнэлт гарсан.

**Г.Занданшатар:** Одоо Баагаагийн Баттөмөр гишүүн асуулт асууна.

**Б.Баттөмөр:** Монгол Улсын хэтийн хөгжлийн “Алсын хараа-2050” гээд тийм хөгжлийн баримт бичгийг бид нар баталсан. Энд хөдөө аж ахуйтай холбоотой 50 гаруй заалт байгаа юм л даа. Эрчимжсэн хөдөө аж ахуйг хөгжүүлэх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд нөөцийг бүрэн ашиглах, ногоон эдийн засаг, ухаалаг хөдөө аж ахуйг хөгжүүлэх гээд энэ чиглэлээр заасан заалтууд бас энэ хөтөлбөр, төлөвлөгөө маань батлагдаад бас хэдэн жил болчихлоо. 3, 4 жил болчихлоо. Энэ чиглэлд одоо ямархуу ажил хийгдэж байна? Бид ер нь энэ “Алсын хараа-2050” гэдэг энэ одоо хөгжлийн загвар энэ материалаа ер нь их муу ашиглахгүй л байгаад байх санагдаад байна. Хөдөө аж ахуйд ямар ажил

хийгдэж байна гэж. Энийг нэгдүгээрт асуух гэж байгаа юм.

Хоёрдугаарт нь энэ хөдөө аж ахуйд энэ Монгол Улсын өөрийн хөгжлийн зардал бол асар их өндөр байдаг. Энэ дотор хөдөө аж ахуйн хөгжлийн зардал, бүтээмж бол их муу. Одоо 1 га-аас 8 центнер ургац авдаг. Тэгээд 1 хониноос 10-15 килограмм мах авдаг. Тэгээд энэ бүтээмжийг нэмэгдүүлэх, энэ хөгжлийн зардлыг багасгах чиглэлд одоо ер нь ямар ажлууд хийгдэж байна гэсэн 2 дахь асуудал байгаа юм.

Гурав дахь асуулт бол юу гэхээр энэ хөдөө аж ахуйд бол энэ даатгалын системийг нэвтрүүлэх асуудал бол их чухал байгаа. Энэ чиглэлд яг бодитой ямар ажлууд хийгдэж байна гэсэн 1 ийм асуулт байгаа.

Дараагийн асуудал энэ хөдөө аж ахуйн корпорац 86 орчим тэрбум төгрөгийн өр байх ёстой. 90-ээд тэрбум байна уу. Одоо энэ өрийн барагдалт барагдуулах ажил. Ер нь цаашидаа өр барагдуулах чиглэлд ямар ажлууд хийгдэж байна, ямар эрсдэлүүд байна? Энийг хэлж өгөөч.

Төгсгөлд нь энэ элеваторууд одоо социализмын үед одоо байгуулчихсан элеваторуудыг одоо сэргээж засварлах асуудлууд ямар байна? Нэлээн олон газрууд элеваторууд байх шиг байгаа юм. Энэ Баруунхараа энэ тэрд олон жил ашиглалтгүй болсон сая ашиглалтад ороод ингээд явж байх шиг байна. Дарханд 3000 тонны 1 элеватор гээд засна барина гээд л ингээд л яваад байдаг л байсан. Тэгээд энэ ажлыг одоо эхлүүлэх энэ жилээс эхлүүлнэ гэж байсан. Энэ ажил ер нь ямархуу байдалтай, ямар түвшинд байна вэ? Ийм асуултуудад хариулт авъя.

**Г.Занданшатар:** Хаянгаагийн Болорчулуун сайд хариулъя.

**Х.Болорчулуун:** Баттөмөр гишүүн хөдөө аж ахуйд ямар ажил хийж байна гэж асууж байна. “Алсын хараа-2050” хөтөлбөртэй холбоотой.

Ер нь 2023 оноос одоо газар тариалангийн сэргэлтийн жил гэж Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас зарлаж байна. Мөн одоо Хүнсний хангамж, аюулгүй байдлын тухай 36 дугаар тогтоол гарсныг мэдэж байгаа. Хөдөө аж ахуйн хүнсний чиглэлээр 1.7 тэрбум төгрөгийг 4 жилийн хугацаанд зарцуулна. Зөвхөн энэ жил гэхэд хөдөө аж ахуйн хүнсний компаниудад 135 тэрбумын зээлийн хүүгийн зөрөөг олгоно. Энэ нь бол 982 тэрбумыг энэ 2023 онд хөдөө аж ахуй, хүнсний чиглэлийн компаниудад одоо зээл олгохоор арилжааны 10 банкттай, Монголбанкттай гарын үсэг зураад ажил эхлээд түрүүчээс нь зээлээ аваад эхэлж байна. 23 оноос үндсэндээ хөдөө аж ахуйгаа сэргээх цогц бодлого эхэллээ гэж ойлгож болно.

Хөдөө аж ахуйн сангийн өр барагдуулахаар юу хийж байна вэ гэнэ гэж асуулаа. Хөдөө аж ахуйн сан би хэлсэн түрүүнд өглөг, авлага нь 200 тэрбум болсон. Аль аль нь. Энэ байдлаар сан гээд яваад байж болохгүй байна. Болохгүй боллоо. Тийм учраас корпорац болох ийм хуулийн төсөл орж байна. Санд өртэй компаниудыг, иргэдийг Монголбанкны одоо мэдээллийн санд тусгаж өөрөөр хэлбэл зээлийн хар дэвтэрт бүртгэх ажлыг хийж байна.

Ингэснээр бас нэлээн өр сүүлийн үед барагдлаа, барагдаж эхэллээ. Түүнээс гадна энэ 7 хоногоос шилэн болгож өртэй иргэд, аж ахуй нэгжүүдийг шилэн болгох үйл ажиллагаа эхэллээ гэдгийг бас хэлье.

Элеваторын хувьд бол одоо Угтаал, Сэлэнгэ, Дархан, Хөтөл гээд 4-5 газар нийт 175000 тонны одоо элеватортой, зарим нь, ер нь ихэнх нь социализмын үеэс уламжилж ирсэн элеваторууд байдаг. Энэ дээр бол засвар

үйлчилгээг жил болгон урсгал засварын зардал гарч хийж явдаг гэдгийг бас хэлье.

**Г.Занданшатар:** Цэндгомбын Болорчулуун 83, Бодлого төлөвлөлтийн газрын дарга.

**Х.Болорчулуун:** Баттөмөр гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Тэгэхээр хөдөө аж ахуйн салбарын бүтээмжийн чиглэлд бол энэ хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгах зорилгоор үйлдвэр технологийн паркуудыг барих энэ ажлууд бол “Алсын хараа-2050”-д тусгагдсан. Энэ хүрээнд бид нар баруун, зүүн бүсийнхээ үйлдвэр технологийн паркийг Ховд, Дорнод аймгуудад, Төвийн бүсийнхийг Дархан-Уул аймагт хийхээр ингээд төлөвлөөд тодорхой хэмжээний ажлуудыг хийж байна.

Мөн түүнчлэн газар тариалангийн үйлдвэрлэлд га-аас гарах нэгж ургацын хэмжээг нэмэгдүүлэх чиглэл дээр олон арга хэмжээнүүдийг зохион авч хэрэгжүүлэх. Тухайлах юм бол техникийн шинэчлэлийг зохих түвшинд хэрэгжүүлэх, үрийн шинэчлэлийг хийх, дотооддоо үр үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх гээд олон үйл ажиллагаанууд байгаа. Энэ ажлууд дээр тодорхой хэмжээний ахиц дэвшилүүд гарч байна. Бид нар бол.

Дарханы элеваторын 36000 тонны элеватор байгаа манай сангийн мэдэлд. Үүний үйл ажиллагаа нь ерөнхийдөө бид нар хүлээж авснаас хойш төдийлөн ажиллаагүй. Одоо тодорхой хэмжээний засвар үйлчилгээ хийгээд өнгөрсөн жилээс бас бид нар будаа авах, хадгалах энэ ажлуудыг эхэлж байгаа. Тэгэхээр бол цаашидаа одоо хэвийн ажиллах нөхцөл нь бүрдэнэ гэж харж байгаа. 3000 тонн биш, 36000 тонны элеватор байгаа Дархан дээр. Энэ тэгээд засвар үйлчилгээ нь явж байгаа.

Даатгалтай холбоотой гэх юм бол Тариалангийн даатгалын тухай хуулийг боловсруулаад явж байгаа. Энэ хуулийг

энэ хаврын чуулганаар чадвал өргөн барихаар ингээд ажиллаж байгаа. Ингэснээр бид нар бол тариалангийн үйлдвэрлэлийг эрсдэлээс хамгаалах бас томоохон хүчин зүйл болно гэж ингэж харж байгаа юм.

**Г.Занданшатар:** Баагаагийн Баттөмөр гишүүн.

**Б.Баттөмөр:** Энэ Хөдөө аж ахуйн даатгалын хуулиа одоо яаралтай оруулж ирнэ биз дээ? Энэ бол маш их чухал хууль байгаа юм шүү. Энэ дээр их онцгой анхаарах ёстой.

Энэ Дархан-Уул аймагт энэ Малын удмын сан гээд нэг байгууллага байгаа. Энэ одоо хөдөө аж ахуйг эрчимжүүлэх, ялангуяа эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэхэд маш их үүрэг рольтой. Тэгээд энэ дээр одоо тэр өргөтгөл энэ тэр гээд юмнууд нь хийгдэх ёстой. Ямар бодлого барьж байна? Цаашидаа энийг одоо бэхжүүлэх энэ чиглэлд юу хийх вэ гэж.

Дараагийн асуудал одоо энэ Монголд хамгийн тулгамдсан асуудлын нэг бол энэ мал эрүүлжүүлэх асуудал. Тэгээд энэ бол эд нарыг яагаад яриад байна гэхээр энэ корпорацын үйл ажиллагаатай холбогдоод л ингээд л цаашиа явна л даа. Энэ чиглэлд одоо ямар бодлого байна? Энэ ер нь энэ хөдөө аж ахуйн хөгжил бол ер нь уул уурхайтай дүйхүйц, аялал жуулчлал энэ 3 л одоо бодлого байгаа шүү дээ. Монголын хөгжлийн гол одоо гарц бол. Тэгэхээр энэ дээр энэ шинжлэх ухаан, технологийн энэ ололтыг нэвтрүүлэх.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Цэндгомбын Болорчулуун Бодлого, төлөвлөлтийн газрын дарга.

**Ц.Болорчулуун:** Малын удмын сангийн үндэсний төв гэж Дархан-Уул аймагт байгаа, Хонгор сумд. Энэ бол үйл ажиллагаа нь бас ерөнхийдөө анхнаасаа төлөвлөхдөө бас нэлээд өргөн хүрээтэй

төлөвлөсөн. Тэгэхдээ бид нар ямар ч байсан төлөвлөсөн хийх үндсэн бүтээн байгуулалтынхаа 80 орчим хувийн бүтээн байгуулалтыг нь хийчихсэн байгаа. Одоо бол өнгөрсөн жилийн төсөв дээр арга хэмжээнүүд явсан боловч шинээр хөрөнгө оруулалтын асуудлууд байхгүй гэдгээр хасагдсан. Цаашдаа бид нар бас гүйцээж барих тодорхой хэмжээний асуудлууд барилгын асуудлууд байгаа.

*Ер нь Удмын сангаар дамжуулаад бид нар энэ малын үржил угсаа үүлдэр угсааг сайжруулах тал дээр.../үг тасрав./*

**Г.Занданшатар:** Энх-Амгалан сайд, Дамдинням гишүүн суудалдаа суугаарай.

**Ц.Болорчулуун:** ...сайжруулах тал дээр олон арга хэмжээнүүдийг авч байгаа. Тухайлах юм бол энэ сайн чанарын малын хөлдөөсөн үрийг хадгалж зохиомол хээлтүүлэг хийх ажилд энэ хувийн үржлийн аж ахуй нэгжүүдтэйгээ хамтраад малын удмын сангийн үйл ажиллагаа бас тодорхой түвшинд ахицтай байгаа. Өнгөрсөн жилийн түвшинд гэхэд бид газар тариалангийн бүс нутагт байгаа малынхаа.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Цэндгомбын Болорчулуун дарга гүйцээгээд хариулъя. 83.

**Ц.Болорчулуун:** Мал эрүүлжүүлэх тал дээр гэх юм бол энэ Хүнсний хангамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай 36 дугаар тогтоолд тодорхой хэмжээний бас заалтууд орсон. Үүнийг хэрэгжүүлэх хүрээнд тодорхой санхүүжилтүүд туссан. Энэ хүрээндээ бид нар энэ жилийн түвшинд Мал эмнэлгийн ерөнхий газраар дамжуулж малын энэ вакцинжуулалтын ажлыг урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тодорхой хэмжээний төсвийн хүрээнд худалдан авалтуудаа хийгээд вакциныхаа технологитой ажлуудыг цаг хугацаанд нь хийхээр төлөвлөж ажиллаж байна.

Цаашдаа энэ малын эрүүлжүүлэх чиглэлд бид нар дотооддоо вакцины тодорхой хэмжээний үйлдвэр шугамыг оруулж ирэх, үйлдвэрлэж болох вакцины хувь хэмжээг нэмэгдүүлэх, Биокомбинатынхаа шинэчлэлийн тал дээр бас тодорхой хэмжээний төслүүдийг олон улсын байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлж байгаа. Энэ хүрээнд бас тодорхой ажлууд явж байгаа гэж хэлье.

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Гадаадын иргэн, харьяатын Агаарын замын болон боомт хариуцсан газрын албан хаагчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд ажлын амжилт хүсье.

Асуулт, хариултын цаг 4 гишүүний асуулт хариултын дараа дуусаж, санал хураалт эхлэх учраас 4 гишүүний дараа гишүүд чуулганы танхимд цуглахыг хүсье. Одоо Хүрэлбаатарын Булгантуяа сайд.

**Х.Булгантуяа:** Хөдөө аж ахуйг дэмжих санг татан буулгаад төрийн өмчит хязгаарлагдмал компани байгуулж байна гэж би ойлгож байгаа. Сан байснаар нэг хэцүү нь гэх юм бол тусгай сангийн өр, авлага, тайлан тооцоо ганцхан Сангийн яаманд л хүргэгддэг. Тэгээд өнөөдрийг болтол ялангуяа энэ чинь Хөдөө аж ахуйг дэмжих сангаас өмнө Хөдөө аж ахуйг дэмжих сан, Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Мал аж ахуйг дэмжих сан билүү тээ Болорчулуун сайд? Мааш олон Мал хамгаалах сан гээд мааш олон сан байгаад төлбөр тооцоо, өглөг, авлагын асуудал үүсээд, тэгээд заримыг нь татан буулгаж нэгтгэсэн.

Тэгэхээр одоо корпорац болсноор тайлангаа гаргаж ашигийн төлөө ажиллахыг ингээд эрмэлзэнэ гэж би ойлгож байгаа. Тэгээд нэг ийм асуултуудыг асуух гэсэн юм.



Нэгдүгээрт энэ өмнөх нөгөө сангуудын тайлан тооцоо, өглөг, авлага юу болсон бэ? Зээл олголттой холбоотой маш олон зөрчлүүд байсан. 2017-18 онд Сангийн яамнаас шалгалт орсон. Түүний эргэн төлөлт сан тус бүрээр ерөнхийдөө хэр болсон бэ? Тариалан эрхлэлтийг дэмжих сан дээр би бүгдээрэнг нь нэгтгэж авсан гэж ойлгосон. Үүнтэй холбоотойгоор ер нь тэгээд хуулийн хариуцлага энэ тэр хүн амьтан ер нь хүлээсэн үү? Эргэн төлөлт юу болсон бэ гэдэг нэгдүгээрт ийм асуулт. Ийм гоё нэртэй сан уг нь бид нар дандаа л зөв юм бодож л байгуулдаг нөгөө Цэвэр агаар гэдэг сангаар нь дамжуулаад бохир үйл ажиллагаа явуулчихсан шиг ингээд зөв зүйл санаачлаад зөв юм хийхээр нөгөөдхийг нь буруу нэг хэсэг хүмүүс ашиглаад, зарим нь авсан хүмүүс нь өгөхгүй шүү дээ угаасаа, өгөхгүй шүү дээ ойлгомжтой энэ тэр гээд ийм юм яриад байх юм. Тэгээд үүний өглөг, авлага үүнтэй холбоотой хариуцлага тооцох нэгдүгээрт юу болсон бэ?

Хоёрдугаарт энэ Тусгай сангийн тухай хуулиар 25 сан байгаад байгаа юм манайд. Тэгээд эмэгтэйчүүд бид нараас ялангуяа энэ хүүхдийн төлөө сан, үүнд орсон орлого юу болсон бэ гэж маш их асуух юм? Тэгээд зарим нэг сангуудын асуудлаар ер нь Улсын Их Хурал дээр нээлттэй сонсгол байдаг юм уу хийх энэ асуудлыг ер нь зохион.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Энэ нэгдүгээрт Засгийн газар танхимын зарчмаар ажилладаг. Засгийн газрын гишүүд энд орж ирээд бие биеэсээ асуулт асуугаад баймааргүй байна.

Хоёрдугаарт энэ хэлэлцэх эсэх асуудал биш, Байнгын хорооноос асуулт асуух ёстой. Нийт Засгийн газрын тусгай сангийн асуудал биш, энэ Хөдөө аж ахуйн сангийн асуудал яригдаж байгаа шүү дээ. Нийт Засгийн газрын тусгай сангийн асуудал бас энд яригдахгүй.

Гуравдугаарт, энэ ер нь Байнгын хороо хариулбал энэ засаг төр чинь шилэн болгоно гээд байдаг. Энэ Засгийн газрын сангууд чинь шилэн болох ёстой гэж байгаа. Энэ Боловсролын зээлийн сан энэ тэр шилэн болно гээд байгаа. Энэ зээлийн тусгай сангууд шилэн болно гээд байгаа. Тэгээд энэ дээр чинь шилэн болгож байгаа тэр удирдах зөвлөл энэ тэр нь тухайн хувийн хэвшил нь ордог тэр тариаланчдын холбоо юун дээр нь хяналт тавьдаг тэр тогтолцоо юмных нь юм яаж бүрдэж байгаа юм бэ? Тариаланчдын хяналтад, олон нийтийн хяналтад шилэн байлгах юм энд яаж хуульчлагдаж байгаа юм? Тэр асуудал л бидэнд гол нь байна. Ам, ажлын зөрүү байж болохгүй. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууя.

**М.Оюунчимэг:** Энэ Засгийн газрын сая хэлж байна 25 сан байдаг гээд. Ер нь ихэнх энэ сангууд нэг талаасаа яг халамжийн сан шиг бүүр ингээд хамаагүй зарцуулалт нь явчихсан, эсвэл нөгөө талаас цөөн хэсэг хүний бизнесийг дэмжиж, түрийвчийг зузаатгаж ирсэн ийм л бас түүх байгаа гэдэг нь үнэн л дээ.

Одоо жишээ нь Хөдөө аж ахуйг дэмжих ,Тариалан эрхлэлтийг дэмжих сангуудыг харахад 2007-2020 оны хугацаа буюу 13 жилийн хугацаанд гэхэд 90 орчим тэрбум төгрөгийг 30-аад аж ахуй нэгжид өгсөн гэж байгаа юм. Тэгвэл энэ аж ахуй нэгжүүд энэ их хөнгөлөлттэй зээлийг аваад өнөөдөр үр дүн манай улсын хөдөө аж ахуйн салбар яаж хөгжив? Энэ хөгжлийн үр дүн нь энэ тухайн иргэн гурил, гурилан бүтээгдэхүүн, мах хөдөө аж ахуйн салбарын энэ иргэнийг Монгол Улсын хөгжилд ямар нөлөө үзүүлэв гэдэг асуудал өөрөө чухал байгаа л даа.

Гэтэл сая Болорчулуун сайд ярьж байна л даа өглөг, авлага нь 200 гаруй тэрбум төгрөг болчихсон. Тэгээд энэ нь төлөгдөх, төлөгдөхгүй нь мэдэгдэхгүй учраас хар данс гээд Монголбанканд өгч байгаа. Эхнээсээ төлөгдөх явж байгаа. Тийм учраас корпорац болгож байгаа гээд

ярьж байна. Энийг жишээлбэл, нэг яам, нэг сайдын хараа хяналтаас гаргаад корпорац болгож байгаа нь өөрөө энэ саяын Тариалан эрхлэлтийг дэмжих юм уу, Хөдөө аж ахуйн сан гэдгээс өөр бүтэц зохион байгуулалт, зорилго, зориулалт, үр дүн нь огт өөр болох юм, шилэн болох юм гэдэг баталгаа өгч чадах уу? Энийг хэн яаж хянах юм жишээлбэл? Жишээ нь сан байхад яамны түвшинд Жижиг, дундын эрхлэлтийг дэмжих сан гээд л, Тариалан эрхлэлтийг дэмжих сан гээд бид нар түүхийн байдаг юм шүү дээ. Тариалан эрхлэлтийг дэмжих сан гэхэд. Нэг, хоёрхон компанийг л дэмжсэн.

Гэтэл энд Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас зээл авах гээд нөгөө жижиг, дунд өсөж өндийж яваа газар тариалан эрхлэлтийн бизнес эрхэлдэг хүмүүс бас тэр болгон энийг хүртэж чадаагүй гэдэг гомдол байдаг. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн зээлээс жишээ нь манай Чингэлтэй дүүрэг л гэхэд яг энэ жижиг, дунд бизнес эрхэлдэг хүмүүс энэ зээлд хамрагдах гэхэд шалгуур босгыг нь хангаж чаддаггүй. Тэгээд хэдэн томхон компани л энийг аваад явдаг гээд ийм шүүмжлэл, ийм гомдол тасрахгүй явж ирсэн.

Тийм ч учраас бид нар өмнө нь нөгөө Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих хууль гаргахдаа ядахдаа босгыг нь хүртэл ийм болгоё гээд өөрчилж байсан. Өнөөдөр энэ бас үр дүнгээ тэр болгон өгч чадахгүй яваад байна л даа.

Тэгэхээр магадгүй энэ өөрөө өгч чадахгүй байгаа учраас Болорчулуун сайд энэ Мэндсайхан сайд л тухайн үед 2021 онд үүрэг чиглэл өгч байсан. Энэ бүтэц зохион байгуулалтыг өөрчлөөд корпорац хэлбэрт оруулах. Энэ нь өөрөө хөдөө аж ахуй тэр дундаа гурил, махны үнийг тогтвортой байлгах, нөөцийг бүрдүүлэх, энэ салбараа хөгжүүлэх гэдэг зорилготойгоор энэ ажлыг хий гэсэн Засгийн газрын тогтоол гарч байсан л даа. Тэгээд энэ тогтоол маань хэрэгжихгүй явж байгаад энийг

хэрэгжүүлэхээр ингэж Улсын Их Хуралд оруулж ирж байгаа юм байна гэж би харж байна. Тэгээд энэ ингээд хэрэгжих үү? Та нар маань 21 онд өгсөн үүрэг, даалгавар энийг өнөөдөр ингэж оруулж ирж байгаа юм байна. Тэгээд сан болох, корпорац болох хоёрын ялгаа, тэр нөгөө шилэн болох, яг хүнд хүртээмжтэй байх, хүссэн хүмүүс нь л шалгуураа хангаад авч чаддаг байх энэ л чухал шүү дээ.

Ер нь өмнөх түүх нь ихэвчлэн танил талаараа юм уу, хэн яамны сайд, Төрийн нарийн ч юм уу ойрхон байсан хүмүүс тэрбум тэрбумаар нь авч байсан тохиолдол баримттайгаа байгаа шүү дээ. Та бүхэн маань ч өөрсдөө ярьж байсан. Энэ 4, 5 жилийн өмнө бөөн л асуудал болж байсан. Өнөөдөр тэгээд үр дүн байхгүй, эргэн төлөлт байхгүй. Тэгээд сая хэлж байна 200 гаруй тэрбумын өглөг, авлагаа өнөөдөр яах вэ гэдэг асуудал яригдаж байна гэж байна. Бараг хар данстайгаа энэ сан корпорац болоод хувирч байгаа тохиолдол байна шүү дээ. Сая бол өглөг, авлага болсон энэ өрийг корпорац болгож байгаа гээд Болорчулуун сайд ярьж байх шиг байна л даа. Өртэйгөө корпорац болбол өөдлөхгүй л гэсэн үг шүү дээ. Тэгэхээр яах вэ, яаж энэ шилэн болох юм? Яаж энэ өөр ажиллах бэ, бүтэц зохион байгуулалт энэ тал дээр эхлээд би хариулт авъя гэж бодож байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Ганзоригийн Тэмүүлэн ажлын хэсэг тээ? Байнгын хороо хариулна. Төсвийн байнгын хороон дарга асуултад хариулна

**Г.Тэмүүлэн:** Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр энэ Тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулаад, Хөдөө аж ахуйн санг татан буулгах энэ асуудал тэр дундаа төрийн өмчит аж ахуй нэгжийн хэлбэрт шилжүүлж байгаа энэ асуудал бол бас яг өмнөх хэлэлцэх эсэх асуудал дээр бол маш олон гишүүд асуудлыг тавьж, гаргаж тавьсан.

Үүн дотроо зүгээр энэ бий болгож байгаа компани маань төрийн өмчийн 100 хувийн өмчтэй. Нөгөө олон зуун компаниудын нэг битгий болоосой. Үр ашиггүй, алдагдалтай ажилладаг, дээрээс нь ямар ч хяналт оролцоо, засаглалын тогтолцоо нь өөрөө эрүүл бус ийм байдал руу битгий ороосой гэсэн асуудал хөндөн тавьж байгаа.

Тэгэхээр Байнгын хорооны зүгээс энэ дээр бол бид нар энэ анхны хэлэлцүүлгийн дараа эцсийн хэлэлцүүлэг орж ирэхэд Байнгын хорооноос Улсын Их Хурлын тогтоолын төслийг санаачлаад, эцсийн хэлэлцүүлэг дээр оруулж ирээд хамтад нь баталъя гэсэн саналтай байгаад байгаа юм.

Үүн дотроо юу вэ гэхээр ерөөсөө саяын тэр Хөдөө аж ахуйн корпорац төрийн энэ корпорац байгуулж байгаа энэ компанийн засаглалыг нь ерөөсөө яг энэ мэргэжлийн холбоодууд тэр дундаа газар тариалан болоод мэргэжлийн энэ хоршоодуудынх нь хамтарсан байдлаар олон нийтэд нээлттэй компани болгох энэ асуудлыг бол Засгийн газарт үүрэг даалгавар чиглэл болгоё гэж байгаа юм.

Тэгэхээр цаашидаа бид нар ерөөсөө энэ олон нийтийн хяналттай байх, нээлттэй байх, ил тод байх, эрүүл зөв тогтолцоог бүрдүүлэх энэ асуудлыг бол энэ компанийнх нь хүрээнд нь бол бий болгож өгье. Тэрнээс биш шууд 100 хувийн төрийн өмчийн компани болох энэ асуудал бол цаашидаа олон олон компанийн алдааг давтах ийм асуудал үүсэх байх. Өнөөдрийн таны ч ярьж байгаа энэ өр, авлагын асуудлууд байна. Санхүүгийн нөхцөл байдал нь хүнд, үүнтэй уялдуулаад Засгийн газрын зүгээс 2021 онд 394 дүгээр тогтоолыг гаргаад энэ компанийг бол цаашид энэ хүрээнд нь үйл ажиллагааг нь явуулах боломжгүй болсон, Тусгай сангийн үйл ажиллагаа доголдсон, үр ашиггүй болох нь тогтоогдсон учраас татан буулгая гэдэг энэ шийдвэрийг гаргаж байгаа юм байна лээ.

Тэгэхээр үүнтэй нийцүүлээд бид нар энэ компани маань бол цаашид өөрөө эрүүл засаглал, тогтолцоо, хяналтын хүрээнд, тэр дундаа энэ мэргэжлийн холбоод болоод газар тариалан болоод мал аж ахуй эрхлэгчдийн энэ оролцоог хангасан ийм олон нийтэд нээлттэй компани болоод хяналтаа тогтоогоод явах нь зүйтэй гэж харж байгаа юм.

Өнөөдрийн байдлаар яг 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар аваад үзэхээр 10325 аж ахуйн нэгж иргэнээс 219 тэрбум төгрөгийн авлагатай байгаад байгаа юм. 219 тэрбум төгрөгийн авлагатай. Үүний 18 тэрбум төгрөг нь 10-аас дээш хугацаа хэтэрсэн авлага гэж харж байгаа юм. Тэгэхээр үүн дээрээс ерөөсөө л дүгнэлт хийгээд үзэхэд бол яг өнгөрсөн энэ 10,15 жилийн хугацаан дахь энэ сангийн үйл ажиллагаа бол яг зээл олголтод дээрээ ч тэр, магадгүй тэр сонгон шалгаруулалт дээрээ ч тэр ямар нэг хяналт хариуцлагын асуудлууд байхгүй байсан. Дандаа хариуцлагагүй аж ахуйн нэгж, иргэдэд өгч байсан. Эргээд энэ сан өөрөө ашигт үйл ажиллагааны байдлаар ажиллаад явах, үр өргөж өөрсдөө хүртээд явах энэ боломж бол байхгүй болчихож байна гэж харж байгаа юм.

Тэгэхээр энийг бол нэг талдаа өнөөдөр бид нар энэ олон жилийн алдааг нь цэг тавиад, татан буулгаад, эргээд олон нийтийн хяналттай компани болгох асуудлыг бол тавья гээд энэ тогтоолын төслийг Байнгын хорооноос санаачлаад оруулж ирье гэсэн ийм саналтай байгаа.

Өр, авлагын асуудлыг ер нь цаашидаа яах юм бэ, Үүссэн өр, авлагын асуудлыг. Тэгэхээр энийг одоогоор ингээд Сангийн яам болоод Хөдөө аж ахуйн яам өөрсдөө хамтарсан шалгалт ороод дүгнэлт нь гарсан. Үүгээрээ бол тайландаа бүртгэлтэй байгаа энэ хугацаа хэтэрсэн өр, авлагуудаа бол бүгдээрэнг нь ангилсан байгаад байгаа юм байна.



Тэгэхээр бид нарын хувьд энэ тогтоол дээр бас оруулж өгөх гэж байгаа зүйл, Улсын Их Хурлын тогтоол дээр оруулж өгөх гэж байгаа зүйл бол энэ улсын төсөвт төлөх, нэг талдаа энэ чинь улсын төсвийн өр төлбөр болчихож байгаа байхгүй юу. Энэ өр төлбөрийг энэ 23 онд гэдэг юм уу, 24 онд гэдэг юм уу багтааж өр төлж барагдуулах үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлж яаралтай шийдвэрлэ гэсэн энэ чиглэлийг бас Улсын Их Хурлаас Засгийн газарт өгөх нь зүйтэй гэж харж байгаа юм.

Дээрээс нь энэ сангаас корпорац болох хооронд ямар нэг хийдэл гарах ёсгүй. Бүх өр, авлагыг бүрэн шууд шилжүүлээд, дараа нь хугацаатай үүрэг, даалгавар өгөөд ингээд эцэслэн шийдвэрлэе гэсэн ийм тогтоолын төслийг оруулж ирье гэсэн шийдвэрлэх бодлоготой байгаа.

**Г.Занданшатар:** Эхлээд зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Чимэдийн Хүрэлбаатарын урилгаар Увс аймгийн Баруунтуруун сумын ЕБС-ийн 2003 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Төрөлх сургууль, ачит багшаа эргэн дурсаж, гэгээн дурсамжийн уулзалт хийж байгаа та бүхэнд сайн сайхныг хүсэн ерөөе.

Чимэдийн Хүрэлбаатар сайд маань хаачсан бэ? Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодруулж асууна. 1 минут. 2 гишүүний дараа санал хураалт.

**М.Оюунчимэг:** Төсвийн байнгын хороон дээр сая бас нэг чухал юм хэллээ. Энэ нэгэнт энэ асуудлыг Улсын Их Хурал дээр одоо яг хэлэлцэж байгаа юм чинь гаргах гэж байгаа тогтоолыг маш нарийн болгочих хэрэгтэй гэж би бас бодоод байгаа юм. Одоо бид нар энэ санг нээлттэй хувьцаат компани болгож байна. Энэ санг корпорац боллоо гээд дахиад л төсвөөс бас төсөв хэлэлцэх үед

хэдий хэмжээний хөрөнгө энд оруулах вэ гээд л асуудал яригдана.

Хоёрт нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилга Улсын Их Хурлын тогтоолоор нөгөө Хүнсний аюулгүй байдлыг дэмжих хүрээнд дотоодын хүнсний үйлдвэрийг дэмжих гээд нэлээд их хэмжээний зээл, тусламжийн асуудал бас яригдана. Тэгэхээр магадгүй энэ корпорацаар бас дамжина гэсэн үг шүү дээ. Тэгэхээр анхнаасаа энийг маш ил тод, тодорхой, шилэн болгох энэ зээлийг яг энэ өмнөх сан шиг халамжийн болгоод, өр зээл болоод эргээд хар дансанд орчих хэмжээнд болохгүйн тулд анхнаасаа нарийн явчих хэрэгтэй гэсэн байр суурьтай байна.

Тэгэхгүй бол Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан гээд л сан байдаг. Гадаадаас ажиллах хүч авсны хураамж тэнд ордог. Уг нь хүн хөдөлмөр эрхлэх нь маш чухал. Гэхдээ энэ сан бас өнөөдөр алдагдалтай. Одоо энэ Хөдөө аж ахуйг дэмжих сан гэнэ. Бас алдагдалтай, өр авлагадаа дийлдэхээ байчихсан байгаад энд л анх.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Санал хэллээ. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууна.

**Ц.Идэрбат:** Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Монгол Улсын хөгжлийн ялангуяа хүнс, хөдөө аж ахуйн хүнсний аюулгүй байдлын тал дээр энэ Хөдөө аж ахуйн яамнаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, энийг хөгжүүлэхийн тулд гаргасан сангууд өнөөдөр тэр сангууд маань үндсэн үүргээ биелүүлж чадаж байна уу, үгүй юү гэдэг дээр дүгнэлт гараад ингээд яригдаж байна л даа.

Ер нь ингээд Их Хурлын гишүүн болсноос хойш энэ нийгэмд яригдаад байгаа, энэ хяналт шалгалтаар илрээд байгаа энэ их сангууд, энэ их мөнгө цаасыг сонсоход тим пангүй л айхтар юм сонсогдох юм. Хөгжлийн банк гэхэд л 1.8

их наяд төгрөг гээд л ингээд л яригдаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зүгээс энэ хүнсний аюулгүй байдал, хүнсний хувьсгалыг хийнэ гээд 5 жилийн төлөвлөгөө гаргаж ирээд ингээд нэлээн хэрэгжих боломжтой ийм зүйл заалтыг, хөтөлбөрийг боловсруулаад ороод ирсэн. 5 жилийн хугацаанд Монголчууд 19 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнээ дотооддоо үйлдвэрлэдэг болоход шаардлагатай хөрөнгө маань 1.8 их наяд төгрөг. Тэгэхээр нөгөө Хөгжлийн банкны 1.8 их наяд төгрөг гэдэг чинь энэ Монгол Улсын 3 сая 300 мянган хүний хүнсний аюулгүй байдлыг тэр чигээр нь хангачих хэмжээний мөнгийг л бид нар үр дүнгүй зарцуулж явж л дээ. Тэгэхээр одоо ингээд сан энэ юмнууд ингээд цэгцрээд овоо аятайхан болох юм болов уу гэж ингэж бодож байгаа юм.

Тэгээд энэ дээр Хөдөө аж ахуйн санг корпорац болгосноор ер нь яг ямар үр дүн гарах юм бэ? Үр дүн гаргах уу гээд гишүүд асуугаад байна. Зүгээр л шилэн болгоно, ил тод болгоно л гэсэн зүйл яриад байна л даа. Тэгэхдээ энэ дээр бас эргэлзээтэй юмнууд байгаа юм. Би бол бараг корпорац болгохоосоо илүүтэйгээр эхлээд бараг өр барагдуулах алба нээмээр юм биш үү. Өр ширнийхээ асуудлыг бүгдийг цэгцэлчээж байгаад дараа нь корпорац болмоор юм биш үү. Тэгээд л ингээд л энэ сангийнхан, дараагийн шинэ сангийн дарга удирдлагууд гарч ирээд л ингээд л юм нь саармагжаад л ингээд л явах вий дээ л гэж би бодоод байгаа юм.

Жишээ нь ер нь бид нар энэ Хөгжлийн банкны сонсгол Энхбаяр гишүүн тэргүүтэй Улсын Их Хурлын гишүүд маш амжилттай зохион байгуулсан. Үнэхээр яг ингээд төр сан байгуулаад тэндээсээ шууд зээл олгохоор ямархуу заваан юм болдог вэ гэдгийг нөгөө хүрээний бузрыг ухвал далай гэдэг шиг ухах тусам л заваан юм гарч ирээд байна лээ шүү дээ. Одоо яг тэр шиг энэ Тариалан эрхлэх, Хөдөө аж ахуйг дэмжих сан төр

өөрөө шууд зээл өгөөд эхлэхээр л дахиад л нөгөө юм руугаа ороод л ингээд л явсан байдалтай байна шүү дээ.

Гэтэл Хөгжлийн банкны хөрөнгийг арилжааны банкаар дамжуулсан тэр зээлүүдийг ярихад адаглаад улс хохиролгүй болж байгаа ийм зүйл байгаад байгаа юм. Тэгэхээр ер нь ингэж төр ингээд баахан мөнгө хажуудаа эргэлдүүлж байх шаардлага байна уу, үгүй юү. Арилжааны банкнуудаараа дамжуулаад хүү багатай, хөнгөлөлттэй тэр зээлүүдээ өгөөд явбал эрсдэлгүй тийм ирээдүй байгаа юм биш үү гэж ингэж нэгдүгээрт харагдаад байгаа юм.

Хоёрдугаарт Монголбанкны хар жагсаалтад оруулж эхэлж байна л гэж байна. Би бол энэ хариулт их муу хариулт байна, дэндүү жул хариулт байна гэж бодож байна. Энэ их мөнгийг ингээд гарын салаагаар урсгаж хаячхаад Монголбанкны хар жагсаалт гэдэг чинь утасны төлбөрөө төлөөгүй хүнийг хар жагсаалтад оруулаад байна лээ шүү.

Гэтэл энэ зээлээс авсан хүмүүсийг зүгээр оруулж эхэлж байна гэж ярьж байгаа. Би бүүр тоо байтай нь хэлээч, хэчнээн хүний нэр яваад хэчнээн аж ахуйн нэгж өнөөдөр иргэн хүн энэ хар жагсаалтад орчхоод байгаа юм? Би үүнд сайн итгэхгүй байна.

1 асуулт байна. Энэ Хөдөө аж ахуйг дэмжих сангаар Хэнтий аймагт 3 жил яригдлаа. Нэг элеватор байгуулах ч юм шиг, байгуулахгүй ч юм шиг. Намайг сумын даргаар ажиллаж байхад газрын асуудлыг нь ишид гэсэн ишидээд өгсөн. Би 20 оны 9 сард Хэнтий аймгийн тариаланчидтай уулзахад Хэнтий аймагт элеватор бариад өгчихвөл бид нар ургацын хэмжээ аймгийн хэмжээнд 20 хэдэн мянган тонныг авч байна. Энийгээ өшөө өргөсөх бололцоотой. Гурилын үйлдвэрүүд хэрвээ 30000-аас гарчих юм бол гурилын үйлдвэр барих бололцоотой гээд ингээд бодитой юм яриад байгаа байхгүй юу. Тэгээд энэ талаар зөндөө л

асуудал тавьсан. Барих ч юм шиг, барихгүй ч юм шиг байсаар байгаад л өнөөдрийг хүргээд л. Өнөөдөр тариаланчидтай уулзахад нөгөө.../минут дуусав./

**Г.Занданишатар:** Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн.

**Г.Тэмүүлэн:** Идэрбат гишүүнтэй бас санал нэг байна. Тэгэхээр бид нарын хувьд Байнгын хороон дээр ч тэр өмнөх энэ хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлаар хэлэлцэх үед ч гэсэн ерөөсөө энэ асуудлыг өр ширтэй холбоотой, тусгай сангийн үйл ажиллагаа доголдсонтой холбоотой, үр ашиггүй ажиллаж байгаатай холбоотойгоор ер нь бол Их Хурлаас бас дорвитой арга хэмжээг авч, Засгийн газарт чиглэл өгч энэ асуудлуудыг шийдвэрлэх ёстой гэдэгт санал нэг байгаа.

Тэр дундаа саяын энэ өр ширтэй холбоотой асуудал, өрийг барагдуулахтай холбоотой асуудал. Энийг бол хугацаатай үүрэг даалгавар магадгүй өгөх ёстой Улсын Их Хурлаас. Ингээд тэрэнтэйгээ зэрэгцээд бүх энэ авлагатай байгаа, өр төлбөртэй байгаа буцаад энэ Хөдөө аж ахуйн сангаас гэрээ байгуулж, санхүү дэмжлэг авсан буцааж төлөх үүрэг хариуцлага хүлээсэн энэ аж ахуйн нэгж байгууллагууд, иргэдийн мэдээллийг бол бас нэг талдаа ил тод болгох ёстой гэж харж байгаа бүгдийг нь. Эргээд түүнтэйгээ уялдуулж, хугацаатай үүрэг даалгаврынхаа хүрээнд тодорхой энэ өрийг яаралтай нэн барагдуулах энэ асуудлыг бол бид нар бас шуурхайлж авч үзэх ёстой гэж харж байгаа.

Ер нь цаашидаа яах юм бэ? Ер нь цаашидаа гэхээр Засгийн газар өөрөө бол энэ сангаа бол өөрсдөө бид нар 2021 ондоо татан буулга гэдэг шийдвэрийг гаргасан. Эргээд Улсын Их Хурал нь тогтоолынхоо төслийг ингээд оруулж ирж байна, хуулийнхаа төслийг оруулж ирж байна. Ингээд аж ахуй нэгжийн хэлбэрт оруулья

гэж байна. Улсын Их Хурлаас бид нарын энийг чиглэл болгож байгаа асуудал бол цаашидаа ерөөсөө энэ хяналт хариуцлагагүй байгаа, үр ашиггүй ажиллуулж байгаа, үйл ажиллагааг нь доголдуулж байгаа үндсэндээ асуудал бол хяналт хариуцлагын л асуудал. Хамгийн сайн хяналт хариуцлага бол олон нийтийн хяналт, олон нийтийн хариуцлага, олон нийтийн оролцооны асуудал.

Тэгэхээр бол бид нар энийг цаашид энэ мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагууд тэр дундаа мал аж ахуй болоод газар тариалангийн асуудал эрхэлсэн энэ холбоодуудтай хамтарсан байдлаар ил тод, нээлттэй үйл ажиллагаа явуулах энэ хувьцаат компанийн хэлбэрт бол шилжүүлэх нь зүйтэй гэж бол харж байгаа. Ингэж байж энэ юу гэдэг юм, үйл ажиллагаа нь төрөөс үл хамаарах, шууд хамааралтай бус байдлаар явах, хөрөнгө, удирдлага, тэр менежмент, төсөв санхүүгийнхээ үйл ажиллагааг эрүүл, зөв засаглалынх нь тогтолцооны хүрээнд аваад явах. Магадгүй тэр ТУЗ болоод хувьцаа эзэмшигчид нь ч гэсэн тэр талаасаа бол хамтарч оролцоод энэ шийдвэрүүдээ гаргаад, ил тод нээлттэй байдлаар эрүүл, зөв засаглалын тогтолцоонд ороод яваад шийдвэрлэх л энэ нь зүйтэй гэж бол хараад байгаа юм.

Нөгөө талдаа хаврын тариалалт бол бас нэг талдаа эхлэх гэж байна. Энэ шилжилтийн цаг үе. Өмнөх энэ он жилүүдэд 10, 15 жилийн хугацаанд л ер нь тариаланчдад болоод газар тариалангийн салбарт үзүүлдэг байсан энэ дэмжлэг үйлчилгээний асуудлууд яах вэ гэдэг асуудал байгаа. Тэгэхээр энийг бол Засгийн газар болоод энэ шинээр байгуулагдаж байгаа компани бол үүн дээр онцгой анхаарал хандуулж, энэ агротехнологийн энэ асуудлуудыг хугацаанд нь цаг алдалгүй хэвийн явуулах энэ арга хэмжээнд бол авах ёстой гэж бол харж байгаа. Энэ талаар ч гэсэн бид нар Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр бол

нарийвчилж тусгаж, оруулж өгье гэж бодож байгаа.

Эцэст нь саяын тэр өрийн үүсгэсэн өмч хөрөнгөтэй холбоотой, авлагатай холбоотой энэ асуудлууд дээр бол бид нар ер нь хамтарч Улсын Их Хурал, Засгийн газар энэ дээр онцгой анхаарч, нэн яаралтай хугацаанд барагдуулах төсвийн мөнгөөр бүрдүүлсэн энэ өр ширийг бол буцааж нөхөн төлөх арга хэмжээг бол авах нь зүйтэй. Энэ асуудлуудаа бол бид нар тогтоол дээрээ нарийвчилж үг, үсгээр нь бол зааж өгөөд ингээд явъя гэж бодож байгаа.

Түрүүн Баттөмөр гишүүн бас энэ даатгалтай холбоотой газар тариалангийн салбар дээр тэр дундаа тариалангийн салбарт даатгалын баталгааг оруулж ирэх асуудлыг бол хөндөж ярьж байсан. Энэ асуудлыг ер нь хууль, эрх зүйн орчин талаас Улсын Их Хурал сая 2022 оны 12 сарын 27-нд даатгалын баталгаа буюу баталгааны даатгалын үйлчилгээг нэвтрүүлэх энэ хуулийг бол баталсан байгаад байгаа юм.

Тэгэхээр анх удаагаа өнөөдөр бол бид нар ямар нэгэн байдлаар бизнесийн үйл ажиллагаа, аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагааг даатгалаар хамгаалах тэр дундаа энэ хууль батлагдсанаар цаашид олон улсын буюу гаднын байгууллагуудын давхар даатгал үндсэндээ томоохон хөрөнгө оруулалт, бизнес орж ирэхэд тэр дундаа газар тариалангийн салбар гэдэг бол өөрөө их асар эрсдэлтэй салбар. Тоног төхөөрөмж нь өөрөө асар үнэтэй, өртөг өндөртэй ийм онцлог бүхий салбар байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ салбарт ч гэсэн энэ давхар даатгалын үйлчилгээ орж ирэх, олон улсын давхар даатгалаар илүү банкны баталгаанаас илүү хямд эх үүсвэрээр бол даатгагдах ийм боломж бололцоо бол бүрдсэн байгаад байгаа. Энэ ондоо багтаад энэ хавраас эхлээд энэ даатгалын компаниуд, даатгалын холбоо

бол энэ дээр тодорхой энэ банкны үйлчилгээнээс 20-40 дахин хэмжээний бага хямд эх үүсвэрийн үйлчилгээг бол санал болгохоороо бэлтгээд явж байгаа. Эхнийх нь бол тендерийн баталгаа болоод гүйцэтгэлийн баталгаа дээр орж ирнэ гэж байгаа. Үүнтэй зэрэгцээд ч гэсэн энэ газар тариалангийн салбар дээр энэ даатгалын баталгааны үйлчилгээг бол оруулж ирэх бас боломжтой гэж би бас харж байгаа юм.

**Г.Занданшатар:** Болорчулуун сайд нэмж харуулъя.

**Х.Болорчулуун:** Энэ өр, авлагыг Хөдөө аж ахуйг дэмжих сангийн өр, авлагыг сан корпорац, компани болсноороо бол шууд шилжиж очно. Тэглээ гээд энийг бол замхруулах асуудал ямар ч байхгүй энэ өр, авлага дээр. Харин улам хүчтэй энэ өр, авлагыг хөөцөлдөж, шинэ бүтэц, зохион байгуулалтаар энэ өр, авлагыг барагдуулах үйл ажиллагааг корпорац, компани зохион байгуулна.

Ер нь энэ 200-аад тэрбумын өр, авлага гэхэд 70, 80 тэрбум нь ер нь бас ингэж хуучин улс төрийн байдлаар хөнгөлөлт, чөлөөлөлт өгөөд олгочихсон тэр болгон нь энэ Хөдөө аж ахуйг дэмжих сан дээр бүртгэлтэй байгаад ирсэн. 70, 80 тэрбум гэхэд эхний ээлжид цайрагдах ийм боломж харагдаж байна лээ. Цайруулах, барагдах тийм.

Тэр Монголбанкны мэдээллийн санд зөвхөн энэ жил эхэлж байгаа юм биш. Өнгөрсөн жилээс өгөөд эхэлсэн. Харин энэний улмаас иргэд, хөдөө аж ахуйн бизнес эрхлэгч нар бол төлөх төлөөс, өглөг нь бол нэмэгдсэн. Төлж эхэлсэн гэдгээ хэлье. Түрүүнд бас шилэн болгоод эхэлсэн энэ 7 хоногоос.

Мөн Хэнтий аймагт элеватор шинээр барих уу гэж асууж байна. Хэнтий аймагт Хөдөө аж ахуйг дэмжих сангийн 2000 тонны элеватор байдаг. Мөн бусад хувийн компанийн элеваторууд болон гурилын үйлдвэрийн хуучин



элеватор нийлээд хангалттай. Хэнтий аймагт шинээр элеватор барих асуудал байхгүй гэдгийг бас нэмж хэлье.

**Г.Занданшатар:** Цагаанхүүгийн Идэрбат гишүүнд тодруулж асууя.

**Ц.Идэрбат:** Хэнтий аймагт элеватор барих шаардлагагүй гэж худлаа ярих хэрэггүй, шаардлага байгаа. Тариаланчид нь өөрсдөө яриад байна, үйлдвэрлэгчид нь өөрсдөө яриад байна. Тэр элеваторыг хааш нь яаж тавих гээд байгаа юм би гайхаад байгаа юм. Ингээд 2, 3 жилийн хугацаатай бүхэл бүтэн яамны бодлого өөрчлөгдөөд яваад байдаг юм уу нэгдүгээрт.

Хоёрдугаарт тэр хар жагсаалт гээд дахиад л их дутуу хариулж байна. Наад энэ Хөгжлийн банкны энэ асуудлуудыг харахад хар жагсаалтад байтугай орчихсон тийм нөхдүүд хэчнээн тэрбумын өртэй байж дахиад л хэчнээн тэрбум төгрөг зээл, хувь авчихсан л байна лээ шүү дээ. Тэгэхээр ганцхан юу гэдэг юм хар жагсаалт гэдэг юм руу энэ зээлийн асуудлыг барагдуулах тал дээр үйл ажиллагаа явуулж байна гэж ингэж хариулаад байх юм бол энэ зээл чинь төлөгдөхгүй. Хар жагсаалтын том зээлдэгч нарт ер нь нөлөөлдөггүй юм байна гэж ингэж би энэ Хөгжлийн банкны энэ сонсгол дээрээс нэлээн сайн ойлгож авсан. Тийм учраас энэ 200 гаруй тэрбум төгрөг гэдэг бол.../минут дуусав./

**Г.Занданшатар:**  
Тилеуханы Аубакир гишүүн.

**Т.Аубакир:** Баярлалаа. Энэ бид нар ингээд, би асуулт, хариултуудыг сонсоод л сууж байна л даа. Бид нар тэгээд бас ядарч зүдэрч явсан үеэ мартчихдаг цамаан зантай л даа. Монголын газар тариалан тэнтэр тунтар гээд хөл дээрээ босож чадаагүй байхад энэ Буудай сангаас эхлээд энэ энэ Хөдөө аж ахуйг дэмжих сангийн оруулсан хувь нэмэр бол өндөр шүү. Одоо ингээд л өр ширт авчихлаа, энэ юмыг ер нь цаазалж л

унагаахгүй бол болохоо байлаа гээд ингээд хандаад байх юм. Энэ чинь Америк, Канадын техник орж ирээгүй Оросын техник, Оросын агрегатуудтай шатахуун зарцуулалт их, бүтээмж багатай ийм үед байхад ганц энэ Монголын газар тариалан энэ идэж ууж байгаа будаа, ногоог чинь тарихад гол тус үзүүлсэн сан бол энэ сан байсан юм. Одоо мэдээж хэрэг ХХК болох нь зөв. “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд энэ ТӨК, сангуудын засаглалыг сайжруулъя гээд явж байгаа энэ хүрээнд ХХК болж байгаа нь зөв.

Үүнтэй холбоотой маш олон энэ хөдөө аж ахуйн бизнес эрхлэгчдээс албан тоот бичгүүд ирсэн. Гишүүдэд ихэнхэд нь очсон байх. Би бас тэдгээрийн бас дуу хоолойг энэ дээрээс хүргэе гэж бодож байгаа юм. Өчигдрийн дугаартай бичиг, энэ төрийн өмчид байсан энэ сангийн дата бол маш их. Энэ дээр бүртгэлгүй хөдөө аж ахуйн газар тариалан эрхэлдэггүй компани гэж байхгүй. Энэ дата дээр, дээрээс нь материаллаг баазаа ашиглаад одоо энэ төрийн өмчит ХХК чинь бид нартай хувийн бизнес хийж байгаа хүмүүстэй, ижил төрлийн бизнес хийдэг хүмүүстэй өрсөлдөх гээд байгаа юм биш үү.

Жишээлбэл тус төрийн өмчит ХХК нь дүрмийн 5.2.4 дээр хөдөө аж ахуйн зориулалттай трактор, комбайн, техник, тоног төхөөрөмж, хүлэмж, усалгааны багаж хэрэгсэл, таримлын үр суулгац, эрдэс болон органик бордоо, түли, шатах тослох материал, ургамал хамгааллын бодисыг дотоодын үйлдвэрээс хангах, дотоодод үйлдвэрлэдэггүй бараа материалыг импортоор нийлүүлэх гээд яг энэ хувийн хэвшлийн хийдэг бизнестэй л энэ төрийн өмчит компани маань өрсөлдөх нь л дээ. Давуу байдлаа ашиглаад нөгөө хувийн яг ижил төрлийн бизнес эрхэлж байгаа компани хувь хүмүүсийг боож унагаах юм болох юм биш биз дээ. Энэ дээрээ анхаарал хандуулаад энийгээ нэг эргээд хараад өгөөч гэсэн хувийн хэвслүүдийн

одоо бичгээр би дуу хоолойг нь хүргэж байгаа юм. Энэ дээр бас манай сайд энэ тэр манай Хөдөө аж ахуйн яамныхан бас анхаараарай.

Гэтэл бид нарын энэ манай Монголын төрийн үндсэн алтан зарчим бол хувийн төрийн боломжийг ашиглаад хувийн хэвшилүүдтэйгээ өрсөлдөхгүй байя л гэсэн алтан зарчим үйлчилж байгаа. Энэ дээр эргээд нэг харна биз. Түүнээс биш энэ Тариалан эрхлэлтийг дэмжих сан гэж энэ хадны мангаа болсон юм бүгдээрээ өр шир аваад луйвардаад алга болчихсон юм байна гэж дэлхийн аль ч улс орнууд хүнсний үйлдвэрлэлээ дэмждэг. Энэ ингээд төрийн өмчит ХХК болчихоор хэрэгтэй үед үзүүлдэг байсан төрийн дэмжлэг, туслалцаа яг хаагуур дамжиж явах вэ? Энэ төрийн өмчит ХХК-аар дамжиж явах юм уу? Энэ дээр нэг хариулаад өгөөч. Үргэлж л ийм хур бороо элбэгтэй төмс, байцай, улаан буудай сайн ургаад байсан юм шиг бас ингээд бялуураад суугаад байж болохгүй. Энийгээ хувьчилчихдаг яг төрийн үзүүлэх нөгөө туслалцаа, дэмжлэг чинь яг хаагуур дамжиж явах вэ гэсэн ганцхан асуулт байгаа юм.

**Г.Занданшатар:** Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн хариулна. Байнгын хорооны дарга хариулна.

**Г.Тэмүүлэн:** Аубакир гишүүнтэй бас санал нэг байна. Тэгэхээр яг энэ мэргэжлийн холбоодууд болоод аж ахуйн нэгж байгууллагуудын зүгээс ирүүлсэн саналыг бол би бас хүндэтгэж авч үзэж байна. Тэгэхээр Улсын Их Хурлаас бид нар энэ анхны хэлэлцүүлэг хэрэв дэмжигдсэн тохиолдолд Улсын Их Хурлаас эцсийн хэлэлцүүлэг дээр нь Их Хурлын тогтоолын төслийг бол санаачлаад оруулж ирье гэж байгаа. Тэгэхээр жишээ нь энэ асуудлыг бид нар бас тогтоолоор Засгийн газарт чиглэл өгөөд, анхаарч үзэх ёстой асуудал гэж харж байгаа. Бас саяын ямар нэг байдлаар энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулж байгаа хувийн

хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагууд болоод эд нартай бол нэг талдаа би өрсөлдөх ёсгүй гэж харж байгаа. Хувь хүнийхээ үүднээс.

Тэгэхээр мэдээж төрийн компани гэдэг бол давуу байдалтай байна. Тэгэхээр саяын тэр үйл ажиллагаа болоод компанийнх нь дүрмүүд дээр эдгээр асуудлуудыг бол магадгүй тодорхой хэмжээнд хязгаарлаж өгөх, ямар нэг өрсөлдөх хувийн хэвшлийн орон зайг булааж авах, түрэх энэ асуудлыг бол бид нар тодорхой хэмжээнд хязгаарлах ёстой гэж харж байгаа.

Дээрээс нь энэ компани бол хамгийн гол асуудал олон нийтэд нээлттэй яг таны ярьж байгаа энэ бичиг ирүүлсэн мэргэжлийн холбоодын оролцоог хангасан ийм компани болоосой гэсэн ийм бодол байгаа. Тэгэхээр энэ тогтоол дээр бол энийг оруулж өгье. Тэгэхээр та бас энэ тогтоолын төслийг Төсвийн байнгын хороогоор оруулж ирэх үед бол бас хамтарч бас ажиллаарай. Саналуудыг бас сая протоколд тусгаад манай ажлын албаныхан авсан гэж харж байгаа. Ингээд явъя гэсэн асуулт байвал.

Саяын үйл ажиллагаатай холбоотой яг өмнөх энэ сангийн явуулж байсан үйл ажиллагааг хааш нь шилжүүлэх, хаагуур дамжуулж хэрэгжүүлэх юм бэ гэдэг асуудлууд байгаа. Бид бүхний хувьд харж байгаагаар уул нь дүрэм дээр нь ч тэр Улсын Их Хурлын тогтоолоор ч гэсэн өгөх гэж байгаа чиглэл бол ер нь цаашидаа өмнө нь тэр тариаланчдад гэдэг юм уу, газар тариалангийн салбарт үзүүлж байсан энэ дэмжлэг, үйлчилгээг тэр дундаа энэ агротехнологийн хугацаанд нь цаг алдалгүй явуулахад шаардлагатай байдаг тэр үйл ажиллагаануудыг бол хэвийн байлгах нөхцөлийг бол хангаарай гэсэн чиглэлийг Засгийн газарт өгье гэж байгаа юм.

Тэгэхээр мэдээж яам анхаарах ёстой компани нь өөрөө бас үйл ажиллагаанд энэ асуудлыг чиглүүлээд

явах ёстой. Яг л энэ хөдөө аж ахуй эрхлэгчдийн тэр дундаа газар тариалан эрхлэгчдийн зах зээлийнх нь яг тэр бодит эрэлт хэрэгцээнд тулгуурласан л тэр бүтээгдэхүүн, үйлчилгээг л явуулна гэж харах гээд байгаа юм. Тэрнээс тэд нартай өрсөлддөг байдлаар уул нь явж болохгүй гэж хараад байгаа. Тэгэхээр тогтоолын төсөл дээр энэ асуудлыг бол тусгаад өгье. Таны саналыг бас анхаарч үзлээ гэдгийг бас хэлэх байна. Сайд болоод яамныхан бас нэмж хариултыг өгч болно гэдгийг хэлэх байна.

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дуусаж байна. Санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглаарай.

Энэ Аубакир гишүүний хэлж байгаа санаа их зөв байгаа. Ер нь Хөдөө аж ахуйн яамны бодлогын зүйл, одоо энэ Байнгын хороо л хариуцна. Нэг зүйл анхаарах юм нь байна шүү дээ. Сан байгуулаад л корпорац байгуулахтай гол биш. Дэлхийн бүх улс хөдөө аж ахуйн банкттай. Хүнс, хөдөө аж ахуйн салбарыг хөнгөлөлттэй зээл, тусгай зээлийн санхүүжилтээр дэмждэг. Хөдөө аж ахуйн банкгүй улс дэлхийд Монголоос өөр нэг ч байхгүй. Хөдөө аж ахуйн зээл яагаад тусдаа байдаг юм бэ гэхээр нэгдүгээрт улирлын шинж чанартай. Хавар тариалаад намар хураадаг. Мах намар бэлдээд өвөл зардаг. Энэ улирлын санхүүжилт, зээлийн шаардлагыг заавал ойлгож байгаа.

Хоёрдугаарт нь бүгд хөнгөлөлттэй зээлтэй. Яагаад гэвэл энэ энэ 3 сая хүний, дэлхийн 8 миллиард хүний хүнсний хангамжийн асуудал, аюулгүй байдлын асуудал байдаг учраас. Тийм учраас энийг засаг ингээд сан болгож тоглоод л, корпорац болгоод л ингээд л будилж байхын оронд зүгээр хөдөө аж ахуйн банкттай болох нь л хамгийн зөв шийдэл байгаа юм л даа. Хөдөө аж ахуйн банк, хөдөө аж ахуйн даатгал гэсэн энэ систем байх ёстой байхгүй юу бүүр.

Ингээд санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрөөтэй 3 санал байгаа. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал байна.

1.Төслийн 3 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн. Санал хураалт.

22 гишүүн дэмжиж, 51.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Дараагийн асуудал. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол, Төсвийн байнгын хороо дэмжсэн санал.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал. Санал хураалт.

61.9 хувийн саналаар Жигжидийн Батжаргал гишүүний гаргасан санал дэмжигдлээ.

2.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 44.5-д заасныг үндэслэн “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооноос санаачлан боловсруулж хэлэлцүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал. Санал хураалт. Энэ дээрээ л их чухал саналуудаа тусгаад энэ тогтоол сайн гарах. Саяын саналуудыг тусгах хэрэгтэй.

59.5 хувийн саналаар Жигжидийн Батжаргал гишүүний гаргасан санал



дэмжигдлээ. Тогтоолын төслөө сайн боловсруулаарай. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тус тусгай сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна.

Үдээс хойших хуралдаанаар Ерөнхий сайдын мэдээлэл сонсоно. Одоо Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл 12 цагаас хуралдана. Наана нь энэ ажлын хэсгүүд хуралтай. Ажлын хэсгүүд хуралдаарай. Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдааныг завсарлуулж байна.

11.17 цаг

Баасан гараг 07 Дөрөвдүгээр сар 2023  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
14 цаг 05 минут.

### **ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Г.Занданшатар:** Би 4 дүгээр сарын 7-ны өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

**Дөрөв. Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Монгол Улсыг гадаадад сурталчлах бодлого, стратеги, хамтын ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээний талаар Гадаад харилцааны сайд Батмөнхийн Батцэцэг мэдээлэл хийнэ.**

Сайд, ажлын хэсгийг оруул. Ажлын хэсгийг оруулъя. Мөнх-Оргил гишүүн яасан? Мөнх-Оргил гишүүн ирлээ эхэлье. Ажлын хэсгийг танилцуулъя, оруулъя.

Гадаад харилцааны сайд Батмөнхийн Батцэцэг, Соёлын сайд Чинбатын Номин, Соёлын дэд сайд Мөнхөөгийн Батбаяр, Гадаад харилцааны яамны Төрийн Нарийн бичгийн дарга Нямдоржийн Анхбаяр, Гадаад харилцааны яамны Консулын газрын захирал Бат-Очирын Болд, Гадаад харилцааны яамны Гадаад сурталчилгаа, соёлын харилцааны газрын дарга, Гадаад харилцааны яамны Бодлого төлөвлөлтийн газрын захирал Гүнтэвсүрэнгийн Бямбасүрэн, Гадаад харилцааны яамны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын дэд захирал Занабазарын Баттүшиг, Гадаад харилцааны яамны Хилийн хэлтсийн дарга Дорждэрэмийн Болд, Соёлын яамны Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн дарга Бандийн Гарьд, Гадаад харилцааны яамны Санхүү, эдийн засгийн хэлтсийн ахлах нягтлан бодогч Чулуунтогтохын Цэнд-Аюуш.

Монгол Улсыг гадаадад сурталчлах бодлого, стратеги хамтын ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээний талаар Гадаад харилцааны сайд Батмөнхийн Батцэцэг мэдээлэл хийнэ. Индэрт урьж байна.

**Б.Батцэцэг:** Эрхэм хүндэт Улсын Их Хурлын дарга, эрхэм Улсын Их Хурлын гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого болон Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасны дагуу Монгол үндэсний оршин тогтнох амин чухал дархлаа болох үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалах дэлхийн улс орнуудтай соёлын хамтын ажиллагааг өргөжүүлэх Монгол Улсын хөгжил дэвшил, ололт амжилтыг дэлхий дахинд сурталчлах, улс орныхоо

гадаад нэр хүнд, үнэлэмжийг дээшлүүлэхэд онцгой анхаарал хандуулан ажиллаж байна.

Монгол Улсын түүх, уламжлал, хэл соёл, урлаг, үнэт зүйл, гадаад бодлого, улс төр, эдийн засаг, боловсрол, нийгэм, эдийн засгийн хөгжил цэцэглэл, ололт амжилтыг олон улсаас урьдчилан таниулах зорилгоор Монгол Улсыг гадаадад сурталчлах хөтөлбөрийг 2016-2020 онд амжилттай хэрэгжүүлж, түүний үр дүнд бий болсон үндэс суурийг бэхжүүлж, төгөлдөржүүлэх зорилгоор Монгол үндэсний үнэлэмж, цогц арга хэмжээг батлан, гадаад харилцаа, эдийн засаг, соёл, аялал жуулчлалын салбарын харилцан уялдааг хангаж, гадаад сурталчилгааг нэгдсэн зохицуулалтаар зохион байгуулж, тодорхой ажлуудыг хэрэгжүүлж байна.

Засгийн газрын зүгээс Монгол Улсыг олон улсад сурталчлан таниулах чиглэлээр хэрэгжүүлж буй ажлыг тоймлон танилцуулъя.

1. Монгол Улсыг олон улсад сурталчлах стратеги, төлөвлөгөөг батлуулж олон улс дахь Сурталчилгаа мэдээллийн үндэсний хороог байгуулав. Дэлхий дахин улам бүр даяаршиж шинжлэх ухаан, мэдээллийн технологи хурдацтай хөгжиж, улс төр, эдийн засгийн интеграци тэлж улс орон дийн харилцан хамаарал гүнзгийрч буй чухал цаг үед Монгол Улсын эдийн засаг, нийгмийн салбарын ололт амжилтыг гадаадын улс орнуудад сурталчлан таниулах үйл ажиллагааг идэвхжүүлэх зайлиггүй шаардлагатай тулгарч.

Үүний тулд нэгдсэн стратеги төлөвлөгөө баталж, хэрэгжүүлснээр Монгол Улсын дотоод, гадаад бодлого, ардчилал, шинэчлэлийн үйл явц Засгийн газрын бодлого шийдвэрийг таниулан сурталчлах, эерэг зөв ойлголт төрүүлэх, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, гадаадын хөрөнгө оруулалт татах, эдийн

засгийг тэлэх зэрэг давуу талуудыг бий болгоно.

Монгол Улсыг олон улсад сурталчлан таниулах үйл ажиллагааг идэвхжүүлэх нэгдсэн стратеги төлөвлөгөөг нэгдүгээрт хөрөнгө оруулалт, хоёрдугаарт аялал жуулчлал, гуравт хүний эрх, дөрөвт ардчилал, сайн засаглал, цахим хөгжил гэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд боловсруулж, Засгийн газрын 2023 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн хуралдаанаас гарсан тэмдэглэлийн дагуу Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хороогоор батлуулан хэрэгжүүлж байна.

Стратеги төлөвлөгөөний хүрээнд Монгол Улсын талаар гадаадын жуулчдын болон хөрөнгө оруулагчдын анхаарлыг татахуйц эерэг мэдээлэл олон улсын нэр хүндтэй хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол гарч байна. Тухайлбал, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд хэрэгдсэн онцлох арга хэмжээнүүд, бодлогын шинэчлэл, үйл явдлуудыг олон улсад сурталчилж, 2023 оны эхний улирлын байдлаар олон улсын нэр хүндтэй хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр Монгол Улсын Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүдийн нийт 16 ярилцлага нийтлэгдсэн.

Монгол Улсыг олон улсад сурталчлан таниулах, түгээх мэдээллийн агуулга, төрөл, өнгө төрх, арга хэлбэрийг тодорхойлох, яамд, агентлагийн мэдээлэл боловсруулалт, түгээлтийн уялдааг зохицуулах, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах зорилгоор Монгол Улсын Олон улс дахь Сурталчилгаа мэдээллийн үндэсний хороог 2023 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар байгуулсан.

Ингэснээр Монгол Улсын талаарх мэдээ мэдээллийг, гадаад орчинд нэгдсэн журмаар түгээх нөхцөл бүрдсэн гэж үзэж байна.

2.Монгол Улсыг гадаадад сурталчлах нэгдсэн өнгө төрх, брэндийг тодорхойлов.

Улс орон бүр өөрийн онцлог өнгө, төрхийг илэрхийлсэн гадаад сурталчилгааны үг, уриа, логог ашигладаг. Монгол Улсыг олон улсын хэмжээнд сурталчлан таниулах үндэсний онцлог бүхий түлхүүр үг, логог тодорхойлох шаардлага бий болсон. Монгол Улсын нээлттэй байдал, зочлох заншлыг илэрхийлэн олон улсын жуулчдын анхаарлыг татах, тэдний төсөөллийг Монгол хүн, Монгол нутаг орны онцлогтой холбох аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааг эрчимжүүлэх хүрээнд “Welcome to Mongolia” үгийг сонгож, 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар түлхүүр үг, брэндийг нэгдсэн өнгө төрх, загварыг баталсан.

Монгол Улсын Засгийн газраас 2023-25 оныг Монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулан нэгдсэн түлхүүр үг, өнгө төрхийг баталж, 2023 онд Монгол Улсад зохион байгуулах олон улсын чанартай 22 арга хэмжээний хуанлийг гаргаж олон улсад зарласан.

2023 оны эхний улирлын байдлаар улирлын жуулчдыг Монгол Улсад ирсэн статистик мэдээ гарсан.

3.Гадаад сурталчилгааг эрчимжүүлэх чиглэлээр олон улсын Think Tank болон томоохон хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлж байна.

Монгол Улсыг олон улсад сурталчлахдаа *tire 1* буюу хамгийн нэр хүндтэй 1 дүгээр зэрэглэлийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах зорилтыг 50 ажиллаж байна.

Энэ хүрээнд CNN, Bloomberg, BBC, Financial times, The Economist National Geographic, The Vandiles зэрэг олон улсын мэдээллийн сувгуудтай хамтын

ажиллагааны талаар яриа хэлэлцээ хийж байна.

Одоогийн байдлаар CNN-тэй 18 сарын хугацаатай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, Монгол Улсын талаар видео реклам түгээх, нийтлэл бичих зэрэг ажлууд хийгдэж байна.

Олон улсад Монгол Улс түүний өсөн буй нэр хүнд, сурталчилгааны оновчлолоор 2021 оны байдлаар 4 сая хандалттай байсан бол 2022 оны эцэс гэхэд 7.2 мянга болон нэмэгдэж, 4000 хандалттай байсан бол 7.2 мянга болон нэмэгдэж манай улсын талаарх эерэг сэтгэгдэл 2021 онд 12% байсан бол 2022 оны эцсээр 28% болж нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Энэ оны эхний улиралд олон улсын хэвлэлд Монгол Улсын эдийн засгийн эерэг үзүүлэлт өндөр дээд хэмжээний айлчлал, Оюутолгойн гүний уурхайн олборлолт, уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр борлуулах зэрэг 4 гол сэдвийн хүрээнд мэдээлэл нийтлэл гарсан.

Түүнчлэн Cambridge Kings судалгааны байгууллага Монгол Улс дахь хүний эрх, ардчиллын ололт, амжилтын талаар *Oppertunity to challenges in Mongolia 2023* тайлан, гадаадын хөрөнгө оруулалт татах чиглэлд *Overseas Development Institude* олон улсын Think Tank байгууллага Монгол Улсын дунд хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын талаар томоохон судалгаа тус тус гаргасан.

Мөн олон улсын байгууллага болон гадаадын нэр хүндтэй хэвлэлээр дамжуулан Монгол Улсын талаарх дараах нийтлэлийг гаргав.

ЮНЕСКО-гийн Дэлхийн өвийн сэтгүүлийн тусгай дугаарт Монгол Улсаас Дэлхийн өвд бүртгэгдсэн газрууд Монгол Улсын өвийн чиглэлээр баримталж буй бодлого, стратеги, хамгаалалтын менежментийн талаар,

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Берлин хотын “Миний дүүрэг сэтгүүл”, Нидерландын хаант улсын *Diplomatic world*, Бүгд найрамдах Франц Улсын аялал жуулчлалын *Инпетив сэтгүүлд* Монгол Улсын талаар тусгай нийтлэлийг Англи, Герман, Франц зэрэг Европын улс орнуудын түгээмэл хэлээр хэвлүүлж, олон улсын томоохон үзэсгэлэн, яармаг, соёлын өдөр зэрэг арга хэмжээний үеэр сурталчлан түгээж байна.

4. Үндэсний болон орчин үеийн урлаг, соёл, спортын ололт амжилтыг таниулан сурталчлах чиглэлээр идэвхтэй ажиллав. Бид түүх, соёл, урлагийн арвин их баялагтай бөгөөд үндэсний болон орчин үеийн соёл, түүхийн дахин давтагдашгүй өвөрмөц онцлогийг гадаадын улс орнуудад таниулан сурталчилж, Монгол соёлыг ойлгож, хүндлэх, суралцах хандлагыг бий болгох замаар гадаад орчинд манай улсын талаарх эерэг таатай ойлголтыг нэмэгдүүлэн соёл хүмүүнлэгийн салбарын хамтын ажиллагааг идэвхжүүлэх, 2 болон олон талт харилцааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна.

Засгийн газрын 2022 оны 73 дугаар тогтоолоор олон улсын тэргүүлэх зэрэглэлийн дүрслэх урлаг болон кино урлагийн наадамд Монголын уран бүтээлчдийг тогтмол оролцуулахаар шийдвэрлэсний дагуу Венецийн дүрслэх урлагийн 59 дэх удаагийн Биенналийн, Канны 75 дахь удаагийн кино наадамд Монголын уран бүтээлчид амжилттай оролцсон.

Дээрх арга хэмжээний үеэр Монголын талаарх олон улсын хэвлэлд 30 гаруй мэдээ, ярилцлага нийтлэгдэж, зарим улс оронтой соёлын харилцааг хөгжүүлэх Засгийн газар хоорондын хөтөлбөрийг байгуулсан. Каннын олон улсын кино наадмын үеэр Монгол Улсын кино урлагийн салбарын шинэ эрх зүйн орчин, татварын буцаан олголтын таатай нөхцөлийг сурталчилж танилцуулсны зэрэгцээ олон улсын кино

урлагийн зөвлөл, кино сан, продакшн уран бүтээлчдийн төлөөлөлтэй 2 талт болон олон талт уулзалтыг зохион байгуулсны үр дүнд 200 орчим кино уран бүтээлийг сурталчлах, худалдаалах боломжийг бүрдүүлээд байна.

Түүнчлэн Морин хуурын чуулга Японы алдарт NHK Hall-д Үндэсний урлагийн Их театрын уран бүтээлчид Монголын соёлын өдрүүд цогц арга хэмжээг ЮНЕСКО-гийн төв тайзнаа бүрэн бүрэлдэхүүнээрээ тоглож, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад Монголын морин хуурын анхны наадам, Нүүдэлчин Монгол, Дэлхийн соёлын фестивалийг Монгол Улсад тус тус зохион байгуулж, Монгол, Швейцарын хөгжлийн агентлагтай хамтран Монгол хувцасны нууц товчоон баримтат киног Англи хэлээр бүтээж, үндэсний дээл хувцасны түүхийг Европын улс орнуудад толилуулав.

Монгол Улсын Соёлын “The Nu” хамтлаг 2022 онд ЮНЕСКО-гийн энхтайваны төлөөх уран бүтээлч цолыг гардан авсан. ЮНЕСКО-гийн соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн Монгол үндэсний баяр наадмыг олон улсад сурталчлах зорилгоор Миний Монгол наадмыг дэлхийн 11 улсын 15 хотод Монгол иргэд болон Монголчуудын холбоодтой хамтран амжилттай зохион байгууллаа.

Монголд зочлох жилийн хүрээнд Монгол Улс бүгд найрамдах Болгар улсын Софи хотноо олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Штуттгарт хотноо Си Эм Ти Штуттгарт, Хамбург хотноо Райзен Караванинг, Бүгд Найрамдах Унгар улсын Будапешт хотноо олон улсын аялал жуулчлалын 45 дахь удаагийн үзэсгэлэнд тус тус оролцож, Монгол Улсын аялал жуулчлалын бодлого хөрөнгө оруулалтын нөөц боломжийн талаар танилцуулж, үндэсний бараа бүтээгдэхүүнийг



сурталчлах арга хэмжээг зохион байгуулсан.

Мөн Монгол Хятадын Засгийн газар хоорондын соёлын төв харилцан байгуулах тухай хэлэлцээрийг 2010 онд байгуулсны дагуу 2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Бээжин хотноо Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард улсад суугаа Элчин сайдын яамны дэргэд Монгол Соёл мэдээллийн төвийг байгуулж, Монголын Соёлын 7 хоног зэрэг улс орныг сурталчилсан өргөн хүрээний арга хэмжээг зохион байгуулж байна.

Соёлын төвөөрөө дамжуулан 2 орны соёлын солилцоог хөгжүүлэхийн зэрэгцээ бусад салбарын харилцаа, хамтын ажиллагааг дэмжиж, хөрш оронд Монголын талаарх эерэг зөв ойлголтыг нэмэгдүүлж, манай улсын хэл, соёл урлагийг Хятадын ард түмэнд танилцуулж түгээн дэлгэрүүлэх өргөн боломж бүрдэж байна.

5. Монгол судлалыг хөгжүүлэх гадаад дахь Монгол судлалын төвүүд эрдэмтэн судлаачдын үйл ажиллагааг идэвхжүүлэхэд анхаарч ажиллалаа. Монгол судлалыг хөгжүүлэх Монгол судлалын хүрээг тэлж, дэлхийд тархсан Монгол өв, дурсгалыг хамгаалах зорилгын хүрээнд тэдгээрийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, гадаадад Монгол судлалын төв байгуулахад бодлогын дэмжлэг үзүүлж байна.

2022 оны байдлаар дэлхийн 20 оронд монгол судлалын 22 төв, 600 гаруй судлаач ажиллаж байгаагаас 200 орчим нь залуу судлаачид байна.

Олон улсын Монгол судлалын холбоо Монгол судлалын үндэсний зөвлөлтэй хамтран Монгол судлалын олон улсын эрдэм шинжилгээний хурлыг Монгол Улсад болон хилийн чанад дахь Монгол судлалын төвүүдийг түшиглэн зохион байгуулж байна. Энэ хүрээнд Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Франц

Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс, Бүгд Найрамдах Итали Улс, Бүгд Найрамдах Чех Улс, Бүгд Найрамдах Польш Улс, Унгар, Япон зэрэг дахь Монгол судлалын төвүүдтэй хамтын ажиллагааг тогтмолжуулж эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж, Монгол судлалын ном, бүтээлийг хэвлэн гаргасан.

Энэ онд Бүгд Найрамдах Эстони Улсын Тартугийн Их сургуулийн Соёл судлалыг хүрээлэнгийн дорно дахины төвийн дэргэд Монгол судлалын тусгай тасгийг байгуулахаар ажиллаж байна. Залуу Монгол судлаачдыг дэмжих, бэлтгэх зорилгоор зуны сургуулийг зохион байгуулж, гадаадын 10 улсын 17 их, дээд сургууль, судалгааны төвийн эрдэмтдийг хамруулаад байна.

Эрхэм хүндэт Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын гишүүд ээ,

Та бүхэнд Монгол Улсыг гадаадад сурталчлах бодлого, стратеги, хамтын ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр хийж буй ажил, арга хэмжээний талаар товч танилцууллаа.

Дэлхийн олон улсын харилцааны ээдрээтэй нөхцөл байдал, цар тахал зэргээс үүдэлтэй хүнд хэцүү цаг үеийг бид даван туулж богино хугацаанд улс орны нийгэм эдийн засгийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхийн зэрэгцээ хөрөнгө оруулалтыг татах, гадаад таатай орчныг бүрдүүлэх, олон улсад Монгол Улсын талаарх эерэг, зөв ойлголтыг нэмэгдүүлж, дэлхийн улс орнуудтай харилцан хамтын ажиллагааг идэвхжүүлэх чиглэлээр хүчин чармайлт гарган ажиллаж байна.

Цаашид гадаад сурталчилгааны үр өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд бусад улс, олон улсын байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагатай нягт хамтран ажиллаж тэдний нөөц боломжийг бүрэн ашиглах, Монгол үндэсний түүх, уламжлал, хэл,

соёл, үнэт зүйлийг дэлхий дахинаа сурталчлах ажлыг эрчимжүүлж, тодорхой ахиц дэвшил гаргах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

2023 онд Монгол Улсыг олон улсад сурталчлан таниулах үйл ажиллагааг идэвхжүүлэх нэгдсэн стратеги төлөвлөгөөг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, дээр дурдсан олон улсын тэргүүлэх зэргийн арга хэмжээнүүдэд оролцохын зэрэгцээ морин хуурын чуулгыг Австралийн Сидней хотын дуурийн театрт, Тамгагүй төр жүжгийг Английн Лондон хотод толилуулах, “Баян Монгол чуулга”-ыг Герман улсад болох дэлхийн жааз фестивалд оролцуулах зэрэг томоохон ажлуудын бэлтгэл ажил хангагдаж байна.

Түүнчлэн Бүгд Найрамдах Франц Улсын Нант хотын түүхийн музейд Чингис хаан Монголчууд дэлхийг хэрхэн өөрчилсөн бэ сэдэвт үзэсгэлэн Монгол зочлох чиглэлийн хүрээнд Монголын байгалийн үзэсгэлэнт газруудын гэрэл зургийн хөдөлгөөнт үзэсгэлэн, Чойжин ламын сүм музейн үзмэрүүдээр Хот мандал хөдөлгөөнт үзэсгэлэнг гадаадын улс орнуудад аялуулан тоглуулах бэлтгэлийг хангаад байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Мэдээлэлтэй холбогдуулж цөөнхийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл үг хэлнэ.

**О.Цогтгэрэл:** Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Та бидний ахуй амьдрал, ажил төрлийн бүхий л зүйлс улам бүүр технологижиж буй билээ. Мөн хэмжиж чадвал удирдаж чадна. Энэ нөхцөлд хэрэгжүүлж, хөгжүүлж чадна гэдэг удирдлагын онолын тулгуур зарчим. Онилсон зорилготой, төвлөрсөн бодлоготой, түүнийгээ хэмжсэн суурь

зорилтот, үр дүнгүүдтэйгээр бодлого стратегиуд хэрэгждэг.

Гэтэл Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулсан Монгол Улсыг гадаадад сурталчлах бодлого, стратеги хамтын ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээний талаар гэсэн мэдээлэлд тавьсан зорилтгүй, өнгөрсөнд байсан үнэлгээ, өнөөдөр хүрсэн үр дүнгээ хэмжсэн хэмжүүргүй, хүлээн авалт хийсэн, тэтгэлэг олгосон, нийтлэл хэвлүүлсэн, төлөөлөгчдийн газрууд руу тайлан илгээсэн гэх мэт төрийн анхан шатын мэргэжилтний ажлын тайлан шиг аар саархан зүйлүүдийг нь түүж уншиж байгаа нь тун харамсалтай.

Стратеги, бодлогын баримт бичгийн тайлан биш өдөр өнгөрөөж, төсөв урсгасан үр дүнгүй үрэлэн ажлын жагсаалт шиг сонсогдож байгаад харамсаж байгаагаа Ардчилсан намын бүлгийн зүгээс илэрхийлж байна.

Даян дэлхийн улс орнууд энх тайвнаар зэрэгцэн орших замыг сонгоод эхний 100-ны хагастаа оржээ. Энэ нөхцөл байдал улс орнуудын глобалчлалын замд хөтөлж, түүний давуу болон сул талуудыг хүлээн авч, өөрсдийн өвөрмөц онцлог өрсөлдөөний ялгарлаа тодруулан хөгжих сорилт руу хөтөлсөөр байна. Туурга тусгаар 200 гаруй улс орнуудын гадаад нэр хүнд нь тухайн улсын өнгөрсөн түүх, өнөөгийн нөхцөл байдал, ирээдүйн тэмүүлээр илэрхийлэгдэж, төрийн бодлого, эдийн засгийн чадавч, үнэт зүйл, соёлын хүчин зүйл, гадаад харилцааны үйл ажиллагаагаар нөхцөлөн тодорхойлогддог.

Харин та бидний хувьд өнгөрсөн түүхээрээ л дэлхийтэй өрсөлдөж, 800 гаруй жилийн өмнөх бахархалт түүхийнхээ үлдэгдлээр өнөөг хүртэл хооллож, Монголын гадаад сурталчилгааг ганцхан Чингис хаан түүний угсааныхны бүтээсэн гавьяа, үлдээсэн өвөөр л хийсээр ирсэн.

Яамтай, яамгүй, төсөвтэй төсөвгүй яг л хийх ёстойгоо Чингис хаан хийсээр Монгол Улсыг сурталчилсаар байна. Харин та бид үүнд нь хэр зэрэг дэм болж байгаа вэ? Уйлдаггүйгээр нь улсын төсвийг урсгаж, усан тайланг нэг нэгэндээ ёс болгон илгээж, Элчин сайдын яам цөөн тооны хүрээнд хүлээн авалт хийж, энд тэндхийн үзэсгэлэн арга хэмжээг хэсэж, тодорхой хэмжигдэх үр дүн гарт баригдах ахиц харагдахгүй байна.

Энэ бүхний шалтгаан нь Монголын төр, Монгол Улсын Засгийн газар гадаад харилцааны бодлогоо ямар хэмжүүрээр, яаж хэмжих ямар зорилт тавихаа өнөөг хүртэл тодорхойлоогүйн уршиг.

Стратеги бодлого гэдэг бол зорилгоо тавьж, тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, түүгээр хэмжих үзүүлэлтүүдээ гаргаж, түүнийг хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг бүх шатандаа хэлбэрэлтгүй нэгэн утгаар ойлгохоос эхлэх ёстой. Улс орнуудын гадаад харилцааны чанар, хүртээмжүүдийг хэмждэг nation брэндсийн индекс буюу тийм үндэсний брэндчиллийн индексүүд байдаг юм байна. Бусад янз бүрийн паспортын индекс зэргээс эхлээд олон янзын тийм индекс харьцуулсан харьцуулалтууд байна байна. Эдгээрт анаа л тэргүүлдэг хэдэн улсууд байна. Харин манай үзүүлэлт индексүүдээрээ энэ индексүүдийн дандаа сүүл хавиар л эргэлдэж байна. Яг л авлигатай тэмцэж, хэвлэл PR-аа сайн хийгээд байхад бодит байдал дээр олон улсын авлигын индексүүд ухраад байдаг шиг хүний эрх, эрх чөлөөг дээшлүүлнэ гээд тунхаглаад байхад улам бүүр уруудаад байдаг Ардчиллын индекс шиг, Шинэ сэргэлт гэж зарлаад байхад эдийн засаг улам бүүр агшаад байдаг шиг үйл явц Монголын гадаад харилцааны бодлого гадаадад улсаа сурталчлах стратегид байна.

Тиймээс Монгол Улсын гадаад паспортынхаа гадна талын хавтасны бүдэг улаан өнгийг улам тод болгож доторх хавтас нь зураггүйг байгалийн зургаар чимэглэж, хойд хуудсанд нь шонхор залсан нь энэ нэг улаан паспортын хүч нэмэгдэхгүй байна.

Паспортын индексээр 100 орноос өнөөдөр 70 орчим байранд орж байна. Улам бүүр унасаар буй төгрөгийн хани шиг Монгол паспортын хүч улам бүүр уруудсаар. Энэ бол төгрөг шигээ, паспорт шигээ энэний цаана Монгол хүний үнэ цэн, үнэлэмж ийм байгааг л илэрхийлж байгаа. Монгол төрийн бодлогын эрхэмлэх тэргүүнд нь Монгол хүн, Монгол хүний үнэ цэн байх ёстой.

Ийм ч учраас гадаадад Монголын гадаад бодлогын эцсийн үр дүн нь энэ гадаад паспортын эцсийн үнэлэмжээр л хэмжигдэх ёстой гэсэн ийм санал, санаачилга болоод ийм бодол дүгнэлттэй байдаг вэ? Монголын энэ улаан гадаад паспорт хэдэн оронд визгүй зорчиж байна вэ? Хэдэн оронд хөнгөлөлттэй нөхцөлөөр, хэдэн оронд нэн хөнгөлөлттэй нөхцөлөөр сүүлийн жилүүдэд ахиц дэвшил гарсан бэ? Энэ яг жинхэнээсээ Монгол Улсын гадаадад биднийг үнэлж байгаа үнэлэмж энэний цаана явж байгаа.

Монгол Улсыг дэлхийд сурталчилж тухайн улстайгаа харилцах улс орны харилцааг сайжруулж Монгол хүний паспортын үнэ, цэнийг нэмэгдүүлэх зорилготой Элчин сайдын яамнууд нь сайжруулах, сурталчлах нь тухайн улсаа ажиллаж амьдарч байгаа иргэдийнхээ эрхийг хамгаалах төрийн наад захын үйлчилгээг үзүүлэх зэрэг жижүүрийн ажлаа ч бас хангалттай хийж чадахгүй мэдээ сэлт байнга л гардаг. Энэ бүхэн Монгол Улсын Засгийн газраас улс орнуудад Элчин сайдуудаа томилохдоо хажуу хавирганыхандаа албан тушаалын алим хуваарилах, намынхаа нэг нөхрийг дэвшүүлэх зарчмаар явж ирсний л хар гай.



Бид энэ бүдүүлэг тогтолцооноосоо хэзээ салах билээ. Цогц өөрчлөлт зоригтой шинэчлэлт хийхгүй бол бид хэдий болтол ингээж явах вэ? Хамгийн мэргэжлийн байх ёстой стандарт хэм хэмжээ нь нэгэнт тогтсон гадаад харилцааны салбарт бохир гар бас хэдийн орсныг нэн яаралтай өөрчлөхөөс уг салбарын цаашидын ирээдүй Монгол хүний олон улс дахь нэр хүнд шалтгаалах нь нэн тодорхой.

Дахин сануулахад хариуцсан сайдын ажлын үр дүн чинь улаан паспортын үнэ цэн хэрхэн өссөнөөр тодорхойлогдож, Засгийн газар Ерөнхий сайдын ажлын үр дүн ч энэ паспортыг хүчний үнэлгээгээр хэмжигдэх ёстой. Улс төрийн нам сонгуульд орохдоо мөрийн хөтөлбөртөө паспортынхаа үнэ цэнийг хэрхэн нэмэгдүүлэх вэ гэдгээ ч бид бүгд бараг тодорхойлдог, хэмждэг болмоор. Тэргүүлэх чиглэлээ гэж энэ бүгдийг бас харж дээд, дунд, анхан шатад аль аль нь үүн рүү чиглэн ажиллаж байж та бидний ажилд ахиц, дэвшил гарах ёстой юм байна гэдгийг Ардчилсан намын зүгээс ахин бас сануулан хэлье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Одоо мэдээлэлтэй холбогдуулж асуулт асууна. Тэрний өмнө ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Ажлын хэсгийн гишүүдийг орж ирэхэд нь танилцуулчихсан, дээр нь нэмэгдсэн хүн чинь. Одоо мэдээлэлтэй холбогдуулж Гадаад харилцааны сайд болон ажлын хэсгийн гишүүдээс асуулт асууж, үг хэлэх цөөнхийн гишүүдийг бүртгэе.

Ширнэнбандийн Адьшаа гишүүнээр тасаллаа. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхлээр урлаг соёлоор дэлхийд улс орноо таниулах, урлаг соёлоор гадаад бодлогоо эрчимтэй явуулах ийм бодлого бол аль ч оронд

байдаг. Тэгэхээр энэ жишээ нь Солонгосын “BTS” хамтлаг байна. Тэд нар 14 тэрбум долларын орлогыг Солонгосын эдийн засагт оруулсан. Нэгхэн тоглолтоор 1 их наяд буюу 757 сая долларын орлогыг олж байгаа. 757 нэгхэн тоглолт, 1 оройны тоглолт, 1 цаг 30 минутын тоглолт.

Тэгэхээр ямар их амжилтыг эдийн засагт авчирдгийн жишээ энэ л дээ. Тэрэнтэй адилхан Монголын урлаг соёлынхон гадаадад Монголыг сурталчлах тэр ажлыг өнөөдрийн төр засгаас илүү бас хэмжээнд хийж байна. Монголыг “The Nu”-гээр мэддэг болсон. Монголыг циркийн уран нугараачдаар болон уртын дуучдаар олон Монголыг сурталчилж яваа тэр бие даагаад ямарваа нэгэн төрийн дэмжлэггүйгээр улс орноо сурталчилж яваа сайхан Монгол хүмүүс байдаг.

Тэгэхээр энэ хүрээндээ бид нар энэ төрөөс энэ Монголыг гадаадад сурталчлах тэр ажил дээр ялангуяа хувийн хэвилийг дэмжих тал дээр, тэр хувь уран бүтээлчдийг дэмжих талаар илүү сайн ажиллах ёстой гэж боддог. Энийг би бас өнгөрсөн 22 оны 1 сард Англид айлчилж явж байхдаа Монголыг хариуцсан Ерөнхий сайдын Борис Жонсоны Монголыг хариуцсан төлөөл Инвой тэр хүнтэй уулзаж байхад би хэлсэн л дээ ер нь Монголд хөрөнгө оруулалт хийх хэрэгтэй. Монголын энэ ардчиллыг хамгаалахын тулд танай Их Британи ер нь Монгол Улсад тодорхой хэмжээний зээл тусламж, хөрөнгө оруулалтыг хийх ёстой гэж. Тэгээд 5 тэрбум доллар оруулаач гэдэг ийм хүсэлтийг тавьж байсан. Миний хажууд Булгантуяа, Дамдинням нарын гишүүд суугаад тэр хүн надаас тоогоо андуураагүй юу гэж асууж байсан. Тэгээд яг 1 сарын дараа Даниел Кавчински ирээд Монголд 3 тэрбум долларын зээлийг маш бага хүүтэйгээр гаргахад Англи улс бэлэн байна гэж Их Британи бэлэн байна гэж хэлсэн.

Тэгээд энэ уулзалтын хүрээнд би 1 зүйлийг хүссэн юм. Өөрөөр хэлбэл зөвхөн эдийн засгийн харилцаагаар биш бид нар урлаг соёлын харилцаагаар бид нар гүн гүнзгий хамтран ажиллах ёстой. Энэ тал дээр бас яг энэ Монголыг сурталчлах энэ ажил дээр та бүхэн бас яг энэ хүмүүст, хувь хүмүүсийн хоорондын харилцаа улс орны харилцааг өндөр хэмжээнд аваачдаг.

Тийм учраас энэ урлагаар дамжуулсан энэ харилцааг сайжруулах тал дээр ажиллаач гэж хүссэн. Түүний дагуу нэлээн ажлуудыг хийж байгаа. Тэрний нэг “Тамгагүй төр” гэдэг жүжгийг Англид тоглуулах. Өөрөөр хэлбэл та нар зардлаа л төлөөд хүрээд ир, үлдсэн бүх зардлыг нь бид нар эндээс гаргаж өгнө гэдэг ийм амлалтыг хэлсэн байхгүй юу даа. Тэгсэн чинь одоо болсон чинь яг тэр “Тамгагүй төр”-ийнхөн очоод тэнд тоглолт хийе гэх дээр яг тэр мэргэжлийн бүжигчдийг явуулж өгдөггүй. Тэр мэргэжлийн бүжигчид хаана явна гэхлээр Оюун-Эрдэнийн зарласан тэр нөгөө урлагийн сэргэлт гэдэг юманд тоглох юм гэнэ. Тэгээд тэр Их тэнгэрт очиж хэдэн дарга нарын өмнө бүжиглэдэг, тэд нар.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Пүрэвдорж гишүүнд нэмэлт 1 минут.

**Б.Пүрэвдорж:** Тэгээд энэ урлагаар дамжуулсан тэр гадаад сурталчилгааг хийхэд бүх хүн бүгдээрээ хамтдаа оролцох ёстой байхгүй юу. Тэнд бүх зардлыг нь даагаад өгье, бүх театрыг нь гаргаад өгье. Ингээд явж байхдаа ерөөсөө ингээд хөдөөгүүр явж тэр урлагийн сэргэлтийг дэмжинэ гээд ийм юм яриад явж байдаг ийм юу байдаг юм бэ. Энэ дээр Батцэцэг сайд та өнөөдрийн дотор тэр хариуг нь аваад тодорхой хариуг нь өгөөрэй. Хувийн хэвилийнхэн нь яваад ингээд Монголоо сурталчлаад байдаг. Гэтэл төр нь тэнд ингээд боломжийг олгож байхад хойш нь сууж байдаг. Ингэж байж болохгүй. Энэ таны ажлын сая илтгэлдээ хэллээ шүү дээ. Урлагаар

хамгийн их сурталчилгаа явж байгаа. Энэ зүйл дээрээ та ямар байр суурьтай байгаа юм? Энэ тал дээр Засгийн газрын гишүүний хувьд яаж ажиллах юм? Оюун-Эрдэнийн өмнө очиж бүжиглээд байдаг байж болохгүй шүү дээ. Энэ чинь гадаадад сурталчилж байх ёстой байхгүй юу. Тэр боломжийг, тэр өөрсдийнхөө тэр насан туршидаа болсон тэр.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Батцэцэг сайд 80, хариулъя. 81 Соёлын дэд сайд хариуъя. Соёлын дэд сайд Батбаяр хариулна.

**М.Батбаяр:** Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. “Тамгагүй төр” жүжиг Англи улсад тоглогдохоор болсон бэлтгэл ажилдаа орсон байгаа. “Тамгагүй төр” жүжиг Англи улсад тоглогдохоор болсон, бэлтгэл ажилдаа орсон байгаа. “Тамгагүй төр” жүжиг бол үндсэндээ үндэсний хэмжээнд тоглогдож, ер нь энэ сайн уран бүтээлээ хийхийн тулд төрийн болон хувийн өмчийн урлагийн байгууллагууд хэрхэн хамтарч ажиллах боломж байна. Мөн үзэгчидтэй чиглэсэн ийм бас чухал ажил өнгөрсөн жил болсон. Ингээд гадаадад аялан тоглох энэ Англи улсад болох тоглолтын бэлтгэл ажлыг хангах хүрээнд Соёлын яам тодорхой зохицуулалтуудыг хийж ажиллаж байгаа. Таны ойлгосончлон энэ урлагийн сэргэлт биш, Соёлын сэргэлт арга хэмжээ улсын хэмжээгээр энэ 4 сарын 21-ний өдрөөс эхлэх гэж байгаа. Үүнтэй холбоотойгоор энэ давхардал, хийдэл энэ дээр гарахгүй гэж та ойлгож болно. Би эргэж бас энэ мэдээллийг танд өгнө. Энэ зохицуулалтыг Соёлын яам хийж байгаа.

**Г.Занданшатар:** Салдангийн Одонтуяа гишүүн. Асуулт, үг хамт явж байгаа шүү.

**С.Одонтуяа:** Тэгэхээр бас гадаад харилцааны сайдын тайланг сонслоо. Ер нь өнгөрсөн хугацаанд ер нь олон улсын байдал маш эгзэгтэй байсан. Улс орнууд тал талд л янз бүрийн байр суурь

баримталж, өөрсдийнхөө бодлогыг дагахыг улс орнуудад уриалсан шахсан иймэрхүү бас их хүнд эгзэгтэй үе байсан.

Гэвч гадаад харилцааны сайд би Батцэцэг сайдыг энэ дээр бас эмэгтэй улс төрчийн хувьд, энэ эгзэгтэй үед асуудлыг бас их эвтэйхэн зохицуулаад Монгол Улс ямар ч байсан энэ Азийн цээжинд байгаа ардчилсан орон гэдгээ бас сайхан аваад үлдэж чадлаа л гэж бас би Батцэцэг сайдад бас талархаж явж байна. Ер нь тийм эвтэйхэн их олон олон айлчлалаас Монгол Улсын нэр хүндийг бас эвтэйхэн аваад гарчав уу даа л гэж баярлаж сууж байна.

Энэ өнөөдрийн асуудалтай холбоотой асуудал дээр нэг зүйлийг онцолж л хэлмээр байна. Бид бол энэ нээлттэй улс, нээлттэй бодлого явуулна гэгчихсэн. Хүмүүсийг уриад авчраад байж болж байна. Солонгосчууд визгүй болчихлоо. Тэгээд ирээд асуудлууд маш их байна. Одоо би сая хэд хэдэн бас гаднын хүмүүстэй уулзлаа. Үгүй ээ танайд очиж болж байна, танайх руу очиход чинь ойрын зайнд хэр нь билетүүд нь маш үнэтэй байна гэдэг асуудал ярьдаг. Энэ билетүүд чинь хэзээ хямдрах вэ гэсэн. Харьцангуй бас ч гэж олон онгоц нисээд, өрсөлдөөн гараад билетийн үнэ харьцангуй бас өмнөх жилүүдээс гайгүй болчихсон.

Тэгэхээр энэ агаарын замын либералчлал, тээврийн либералчлалыг бас би амжилттай сайн хийгээд эхэлж байна уу л гэж харж байгаа. Энийг улам сайн болгох ёстой улам нээлттэй болгох ёстой. Тэгээд ирчихээрээ дотоодод нислэгүүд олддоггүй. Миний таньдаг Солонгос хүн өчигдөр тэгж байна би найзуудад дагуулж оччихоод 3 цаг нисээд Монголд оччихоод би Хөвсгөл явъя гэхээр би 10 цаг явах болдог. Би тэр цөөхөн хоногийнхоо 2 өдрийг зөвхөн Хөвсгөлд явах замд зарцуулж байна. Тэгэхээр энэ дотоодын онгоцнууд нисэх барих үе чинь болоогүй үгүй юу? Энэ ажил чинь ямаршуу хэмжээнд байна вэ? Ер нь энэ

зунаас бид нар олон олон хүмүүс хүрээд ирдэг, тэр хөдөө орон нутаг руу жижиг онгоцнууд нисэх ийм боломжууд бол байна уу? Энэ талаар, хамгийн их гол асуудал, зангилаа энэ байгаа.

Дээрээс нь энэ хүмүүс ирээд танайд очоод үзэх юм их ховор байдаг л гэдэг юм. Үзэх юм их ховор байдаг. Ялангуяа хүүхэдтэй жуулчин ирээд бол хийх юм алга л гэдэг. Тэгэхээр энэ чиглэлээр ер нь бодож байгаа ажлууд юу байдаг юм бол? Жуулчны компаниуд сая энэ КОВИД-оос болоод маш олон компаниуд хаалгаа барьсан, дампуурсан, хүнд байдалд орсон. Тэгэхээр энийг төрөөс яг энэ аялал жуулчлалаа дэмжих хүрээнд хөнгөлөлттэй зээлийг нь олгож өгмөөр санагддаг юм. Бид нар төр эсвэл бизнесийг нь булаагаад байдаг, эсвэл ингээд бүүр хаячихдаг шүү дээ. Тэгэхээр энэ хүмүүсийг зүгээр хөнгөлөлттэй зээлээр л дэмжээд өгөх энэ чухал ажлыг хийх гэж байна уу гэсэн ийм зүйл байна.

Дээрээс нь энэ дотоодын аялал жуулчлалыг бол бас нэлээд дэмжих хэрэгтэй. Дотооддоо Монголчууд аялах гэхээр бараг гадаад явсан нь хямд байна шүү дээ гэж хүмүүс ярьж байна шүү дээ. Тайланд, Вьетнам руу явсан нь бараг хямд болж байна гэж ярьж байна. Тэгэхээр энэ бүхний учиг утгыг нь тайлаад энэ чиглэлээр яг юу хийх гэж байна вэ?

Суулийн асуулт Соёлын яамнаас асуумаар байна. Энэ манайд зураачдын бүтээлийг гадаадад нэлээд сурталчилж байгаа. Өчигдөр Солонгост бас хэсэг зураачдын бүтээл очсон гэж байна. Энд гэхдээ бид нарт л нэг ийм мэдрэгдэхгүй байгаа болохоор энэ цаагуураа хэр их явдаг юм бол, энэ чиглэлээр ер нь ямар ажлууд төлөвлөж байна вэ? Манай зураачдын бүтээл бол маш сайн зарагдаад байгаа шүү дээ. Тэгэхээр энийг нь дэмжсэн ийм экспонууд хэр хийж байна, төрөөс яг бодлогоор энэ зураачдаа яаж дэмжээд байна?

**Г.Занданишатар:** 80 Гадаад харилцааны сайд Батцэцэг хариулна.

**Б.Батцэцэг:** Одонтуяа гишүүнд баярлалаа. Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Аялал жуулчлалыг сурталчлах чиглэл болгон зарласантай холбогдуулан Засгийн газар дээр цогц арга хэмжээнүүдийг авсан. Төлөвлөснийхөө дагуу нэлээд ажлууд хийгдэж байгаа.

Агаарын харилцааны тухай хэлэлцээрийг бол бид нар их олон оронтой ярьж байсан. Энэ жилийн хувьд бас ч чамлахааргүй амжилттай бид нар сая Америкийн Нэгдсэн Улстай байгуулсан, Катартай зурахад бэлэн болсон байгаа. Катар улстай байгуулсан байгаа. Узбек болон бусад нэлээд олон орнуудтай олон жил ярьсан хэлэлцээрүүд бол ингээд түрүүчээсээ зурагдаад, зарим хэлэлцээрүүд өндөр дээд хэмжээний айлчлалын үеэр зурагдахаар бэлтгэгдэж байгаа. Цаашидаа илүү энэ чиглэлээр идэвхтэй ажиллах ийм бодлогыг барьж байгаа.

Дотоод нислэгийн хувьд би Зам, тээврийн сайдыг бас хариулах байх гэж бодож байна. Дотоодын нислэгүүдийн талаар бол яригдсан гол гол жуулчдын очдог аймгууд хуучин орон нутгийн нисэх онгоцны буудалтай аймгууд дээр дотоодын нислэг үйлдэх ажлыг шат дараалалтай зохион байгуулахаар ярьж байгаа.

Бид нар 23 онд бас анх удаагаа олон улсын Монгол Улсад зохион байгуулагдах арга хэмжээнүүдийн хөтөлбөр гэж гаргасан. Нийт 146 арга хэмжээг бид нар зохион байгуулж, зөвхөн зуны 3 улиралд аялал жуулчлалыг татах биш, жилийн туршид аялал жуулчлалыг татах мөн албан аялал жуулчлалыг хөгжүүлэх энэ чиглэлээр нэлээд олон арга хэмжээнүүдийг бүх яамнууд төлөвлөж гаргасан. Үүнээс бид нар онцгойлон 22 арга хэмжээг энэ олон улсын зарлаад арга хэмжээгээ зарласан байгаа. Үүнд наадмын өмнө жишээлбэл эдийн засгийн

форумыг зохион байгуулах, олон улсын бүсийн болон олон улсын хэмжээний томоохон тэмцээн уралдаануудыг соёлын арга хэмжээнүүдийг, олон улсын хурлуудыг зохион байгуулах ийм арга хэмжээнүүдийг авч байгаа. Олон улсын хурлууд зохион байгуулах олон улсын байгууллагуудтай бас хамтарч бүсийн хурлуудыг авах ийм арга хэмжээнүүдийг энэ төлөвлөгөөнд оруулсан. Нийтдээ 22 арга хэмжээ байгаа. Бусдыг нь Соёлын дэд сайд хариулъя.

**Г.Занданишатар:** Соёлын дэд сайд Батбаяр хариулъя 81.

**М.Батбаяр:** Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Монгол улсын Соёлын яамнаас соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр бодлогын онцгой чиглэл болгон ажиллаж байгаа. Нийтдээ соёлын бүтээлч үйлдвэрлэлийн 12 салбарын дотор дүрслэх урлагийн салбар тэргүүлэх чиглэл эхний 6 салбар дотор явдаг. Мөн энэ шийдвэрийг 2022 онд Засгийн газрын хуралдаанаар тэргүүлэх чиглэлийг батлуулан ойрын 15 жилийн төлөвлөгөө боловсруулаад ажиллаж байгаа.

Түүнтэй холбоотойгоор 2022 оны Засгийн газрын 73 дугаар тогтоолоор дэлхийн хамгийн том дүрслэх урлагийн наадам болох Венецийн Биенналь болон киноны наадамд Монголын уран бүтээлчдийг оролцоход албан ёсоос Засгийн газраас дэмжлэг үзүүлж оролцдог байх ийм шийдвэрийг гаргасан.

Үүнтэй холбоо одоогоор өнгөрсөн жилийн тухайд 59 дүгээр Биенналийн наадамд манай Мөнхцэцэг уран бүтээлчийн Гүнээс гүнд үзэсгэлэн оролцож, нийт 6 сарын туршид олон улсын хэвлэл мэдээлэл, урлаг судлаач, шүүмжлэгч кураторын анхаарлыг татсан ийм өндөр үнэлгээ авсан ийм байдалтай байгаа.

Дараагийн нэг жишээ болгож хоёрыг хэлье.



*Хоёр дахь нь өнгөрсөн жил болсон Катар улсын Доха хотод хөл бөмбөгийн дэлхийн аваргын үеэр мөн энд Монголын Үндэсний музей, мөн дүрслэх урлагийн бүтээлүүдийг танилцуулж, энэ үзлэгээр нийтдээ 580 гаруй мянган хүн үзсэн гэсэн ийм судалгааг авсан. Баярлалаа.*

**Г.Занданшатар:** *Наянтайн Ганибал гишүүн.*

**Н.Ганибал:** *Олон асуулт байхгүй. Ер нь зүгээр хэд хэдэн санал хэлье гэж бодоод байна. Ер нь Монгол улсыг гадаадад сурталчлах гол хүчин зүйл мэдээж урлаг соёл, дээрээс нь спорт байгаа. Монголчууд бас дэлхийд зөвхөн чөлөөт бөх, жүдо, бокс гээд хувь хүний спортоор олонд танигдсан, дэлхийд танигдсан байсан бол сүүлийн үед бас энэ багийн спортууд бас Монгол Улсыг олонд сурталчилдаг болж байна. Манай сагсан бөмбөгийн залуучууд, энэ хөл бөмбөгийн залуучууд, одоо хоккей. Ингээд энэ өөрөө юу хэлээд байна вэ гэхээрээ Монгол Улс энэ чөлөөт эдийн засаг ардчиллыг сонгосноос хойш энэ залуучуудыг хөгжүүлэх энэ дээрээ бас санхүү мөнгөний боломжууд улам их бүрдээд ингээд бид өөрсдийнхөө хүчин чадлын хэмжээнд дэлхийд бас хүчээ үздэг ийм боломжууд улам их нээгдэж байна гэсэн үг.*

*Мэдээж урлаг дээр “The Nu” хамтлагийг хэлж болно. Манай дуурийн дуучин Амартүвшин дуучин байна. Дэлхийн хэмжээний ийм яг тэр тухайн асуудлыг судалдаг, мэддэг, сонирхдог урлаг судлаачид, үзэгчдийг байлдан дагуулж чадаж байна л даа. Тэгээд энэ болгон мэдээж эргээд л нөгөө ардчиллын буян. Энэ дээр бүгдээрээ сайн бодож байх ёстой юм гэж би бас хэлэх гээд байгаа юм. Тэгээд өнөөдөр бид нар бас та бүхэн маань дэлхийн улс орнуудад явахад өөдөөс нь ч гараад инээгээд угтдаг олон улс орон байдаг байх. Энэ бол ардчилсан улс орнууд. Мэдээж энэ дээр яах вэ. манай мэдээж мөнхийн 2 хөри. Энэ хоёртойгоо*

*хамгийн дипломат, хамгийн зөв харьцааг бид нар бас мөнхөд авч явах ёстой. Энэ бол бидний хүсэл зорилго мөн.*

*Тэгэхдээ бидэнд нөгөө инээж угтдаг улс орнуудтайгаа харьцахад бас хүндрэлүүд үүсээд эхэлж байх шиг байна. Энэ дээрээ бид нар та бүхэн нэн ялангуяа Батцэцэг сайд Засгийн газрын хуралдаан болгон дээрээ анхааруулж явмаар байгаа юм. Яагаад гэхээрээ энэ индексүүд бүгд өөрчлөгдөөд байна шүү дээ тийм үү? Ардчиллын индекс 17 байраар ухарлаа л гэж байна. Чөлөөт эдийн засгийн тэр индекс бас Монгол Улсад буураад эхэллээ. Арагшаа олон улсад. Нэн ялангуяа энэ хүний эрхийн асуудал. Энэ дээр та бүхэн маань бас өдөр болгон сануулж байх ёстой.*

*Яагаад гэхээрээ та бүхэн дэлхийг Монголыг төлөөлөөд очдог. Тэнд энэ өнөөдрийн энэ Монгол Улсад хийгдээд байгаа Засгийн газрын болон бидний хүртэл аваад байгаа арга хэмжээнүүд буруу бол тэр дээр зайлшгүй энийг магадгүй жилдээ 1 ч юм уу, улиралд 1 удаа оруулж ирж, танилцуулж энийг нь анхааруулж явах ёстой юм уу даа л гэж бодоод байгаа юм.*

*Тэгээд та бүхэн гадаа ингээд бас залуучууд үзэл бодлоо илэрхийлж байна л даа. Ингэснийхээ төлөө өнөөдөр баривчлагддаг. Монголхүү гээд залуу тэр Мөнх-Эрдэнэ байна, тэр Батзандан. Энэ хүмүүс үг хэлээд л 2 хоногийн дараа, 3 хоногийн дараа ингээд баривчлагддаг. Тэгээд шүүхийн ямар нэгэн тогтоолгүйгээр 30 хоног баривчлаад дараа нь сунгаад сунгаад сунгаад сүүлд нь эргээд ял өгөөд ингээд явж байгаа юм. Энэ бол бид нарт ингээд эргээд та бүхний очоод, уулзаад, инээгээд угтдаг тэр хүмүүс чинь багасах вий дээ гэдэг ийм л болгоомжийг та бүхэн маань бас байнга сануулж байх ёстой юм уу даа л гэсэн бодолтой байна. Баярлалаа.*

**Г.Занданшатар:** *Үг хэлчихлээ тээ. Ширнэнбандийн Адьшаа гишүүн.*



**Ш.Адьяа:** Би 20 минут асуух ёстой шүү дээ тэрийгээ л асуучихъя. Нийлээд харилцан ярилцах.

**Г.Занданишатар:** Тэр болоогүй.

**Ш.Адьяа:** Тэр болоогүй байгаа юу? Тэгвэл би тэр дээрээ л асууя.

**Г.Занданишатар:** Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны шинэ дэгийн дагуу Дэгийн тухай хуулийн 109.11-т заасны дагуу D-Parliament цахим хэлэлцүүлгийн платформ дээр байршуулсан Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулж иргэдээс ирүүлсэн асуултуудыг Засгийн газрын гишүүнээс намын бүлгүүдэд төлөөлж асууна. Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны дарга Цэндийн Мөнх-Оргил Засгийн газрын гишүүнээс асуулт асууна. Цаг 20 минутаар тасралтгүй үргэлжилнэ. Асууж хариулаад л явчхаарай. Шууд микрофоныг асаалттай үлдээчихнэ.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа 1 дүгээр асуулт Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хорооны иргэн Дорждулам гэж хүнээс ирсэн байна. Гадаад сурталчилгаанд санхүүжилт хэрэгтэй, улсын төсөвт гадаад сурталчилгаанд хэдэн төгрөг зарцуулж байна, хэр үр ашигтай зарцуулж байна гэж асуусан байна. 1 дэх асуулт.

Хоёрт, Хан-Уул дүүргийн 12 дугаар хорооны иргэн Мөнхжаргалын Ганзориг гэж хүнээс асуулт ирсэн байна. Гадаадад сурталчилгаа хийх ажилд иргэдийн хүчийг ашигламаар байна. Энэ талаар юу хийж байна гэсэн байна. Сошиал медиа дээр татаж болох боломжтой хэлбэрээр сурталчилгааны материалыг оруулмаар байна. Энэ хүн саяхан QR кодтой постерыг олон улсын

хуралд орохдоо илтгэлдээ ашиглах гээд татсан чинь болохгүй байсан шүү гэж санал хэлсэн байна.

Пүрэвээгийн Болортоль гэж хүн Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг 3 дугаар хорооноос энэ агаарын тээврийн салбарын либералчлалыг асуусан байна. Хэр үр дүнтэй явж байна гэж.

Очирын Очиржав Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо, Гадаад бодлогын үзэл баримтлалын 25.5-д бусад улс дахь Монгол туургатнуудтай харилцан хамтын ажиллагааг өргөжүүлж, хэл соёл уламжлалаа хадгалан хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх гэж заасныг хэрхэн хэрэгжүүлж байна? Дэмжлэг үзүүлж чадаж байна уу? Энэ талаар стратеги байна уу гэж асуусан байна.

Дараагийн асуулт Бямбасүрэнгийн Бямба-Очир гэж хүн Баянзүрх дүүрэг, 21 дүгээр хорооны иргэн байна. V дугаар цахилгаан станцыг яагаад барихгүй байгаа юм бэ? 15 жил яригдлаа, одоо барих болсон юм биш үү гэж асуусан байна.

Чулуундоржийн Цогт-Очир Сэлэнгэ аймаг, Сайхан сум, 3 дугаар баг. Гадаад харилцааны үйл ажиллагаанд гуравдагч хөршийн бодлогыг эрчимжүүлэх шаардлагатай байна гэсэн асуулт, санал хэлсэн байна.

Энэ асуултууд асуусны дараа өшөө нэмэлт 2 асуулт байгаа. Тэрэнд нь нэмээд хариултынх нь дараа асуучихъя.

**Г.Занданишатар:** Тийм хариултынхаа дараа ингээд мэтгэлцээн байдлаар харилцан ярилцаад явж болно. Тэгж л асууна. Нэг талдаа 20 минут яриулж болно. Хэн хариулах вэ? Батцэцэг сайд 80.

**Б.Батцэцэг:** Мөнх-Оргил гишүүний асуултад хариулъя. Гадаад сурталчилгааны төсөв өмнөх жилүүдэд

байгаагүй. Өнгөрсөн 22 онд 900 сая төгрөг төсөвлөсөн. Тэр төсөвтөө тохируулаад нэлээд олон арга хэмжээг хилийн чанадад зохион байгуулсан. Голдуу хилийн чанадад байгаа төрийн бус байгууллагууд, Элчин сайдын яамнууд иргэдийн оролцоотойгоор бол иргэдийн хилийн чанадад байгаа иргэдийн санал санаачилгыг үндэслээд арга хэмжээний төлөвлөгөөнүүдийг нь, саналуудыг нь авч байгаад төлөвлөгөө гаргасны дагуу ажилласан. 900 сая төгрөг бол энэ бидний 40 гаруй дипломат төлөөлөгчийн газруудаар дамжуулж арга хэмжээ хийхэд хүрэлцдэггүй.

Энэ жил бол 3 тэрбум төгрөгийн төсөв тавигдсан. Бид нар арга хэмжээнүүд илүү сурталчилсан, илүү өгөөжтэй, олон хүнийг хамарсан, Монгол Улсыг сайн сурталчлах ийм материал, контент бэлдэж байж тэгээд илүү өгөөжтэй байх талаас нь илүү анхаарч захиран зарцуулахаар шийдвэрлэсэн. Ингээд бид нар бас нэгдүгээрт бол олон улсын томоохон 1 дүгээр ангиллын гэх юм уу хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй эхэлж ажиллаж байгаа.

Мөн гадаадад зохион байгуулагдах томоохон арга хэмжээнүүдэд бас өмнөхөөсөө арай илүү нямбай хандаж байгаа гэж хэлэхэд болно. Тэгэхээр энэ арга хэмжээг Соёлын яам, Гадаад харилцааны яам болон Байгаль орчин, аялал жуулчлалын яам 3 энэ гуравласан яриа, хэлэлцээний үндсэн дээр бас тодорхой төлөвлөгөө гаргаж ажиллаж байгаа.

Иргэдийг гадаад сурталчилгаанд оролцуулах ийм бүрэн боломжтой. Манай мэдээллүүд энэ Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Соёлын яам, Гадаад харилцааны яамны веб сайт дээр бол цахим байршсан байгаа. Цахим хөгжлийн яамны үйл ажиллагаа шинээр байгуулагдсантай холбоотой яамнуудын үйл ажиллагааг хоорондын уялдааг нь хангах чиглэлээр Засгийн газар дээр нэлээд арга хэмжээнүүдийг авч байгаа.

Тэгэхээр энэ 6 сар гэхэд бидний үйл ажиллагаа энэ иргэдэд хүртээмж буюу техникийн хувьд ямар ч доголдолгүй ингээд ажиллах ийм бололцоотой байгаа.

Гуравдагч хөршийн харилцааг бас эрчимжүүлэх шаардлагатай гэдэг дээр санал нэг байгаа. Гуравдагч хөршийн, бид нар 2 хөршийн бодлого дээр гуравдагч хөршийн бодлогыг тэнцвэртэй хангах, энэ цаг үеийн нөхцөл байдал КОВИД болон Украин болон Оросын хоорондын асуудлаас шалтгаалаад нэлээд ийм эрчимтэй үйл ажиллагаанууд явуулах ийм цаг үеийн шаардлага гарсан. Гадаад харилцааны яам энэ дээр бас нэлээн идэвхтэй ажиллаж байгаа. Гуравдагч хөршийн бодлогыг илүү хэрэгжүүлэх чиглэлээр бол үр дүн гарсан гэж үзэж байгаа. Өнгөрсөн онд бид нар Антониу Гутерришийг Монгол Улсад айлчлуулах үеэр бас энхтайваны бэлгэ тэмдэг хэмээн энэ хүний онцолсон эшлэл олон улсад бас нэлээн анхаарал татсан.

Бид нар гуравдагч хөршийнхөө өндөр дээд хэмжээний айлчлалуудыг өнгөрсөн онд бол 10 гаруй айлчлалыг хэрэгжүүлсэн. Дунджаар бид нар жилд өмнөх 30 жилийн статистикийг үзэх юм бол 2-3 өндөр дээд хэмжээний айлчлалыг хэрэгжүүлдэг байсан. 10 гаруй айлчлал хэрэгжиж, үүн дотроо 6 гадаад харилцааны сайд бас айлчилсан нь чухал үзүүлэлт болно гэж үзэж байгаа. Мөн бид нар НҮБ дээр өгч байгаа энэ олон санал хураалтууд дээр барьж байгаа байр суурь, барьж байгаа байр сууриа 2 хөршидөө болон гуравдагч хөршүүддээ тайлбарлах, өөрийнхөө орны онцлогийг тайлбарлах ажил бол тасралтгүй хийгдэж байгаа.

Бид нар энэ саналуудтай холбоотой үүсэх эрсдэл, давуу, сул талууд ямар улстай ямар тайлбарыг хийх вэ гэдгийг нарийн гаргадаг болж хэвшсэн байгаа. Бид нар бас энэ олон улсын хамтын нийгэмлэгт өндрөөр энэ манай гуравдагч хөршийн бодлогыг өндрөөр үнэлж, анхаарлын төвд орж байгаа нь олон

зүйлээр илэрч байгаа. Энэ жилийн хувьд ч бас нэлээд олон өндөр дээд хэмжээний айлчлалууд гуравдагч хөршөөсөө авах ийм төлөвлөгөөтэй түрүүчээсээ хэрэгжээд явж байгаа гэдгийг хэлье.

**Г.Занданишатар:** Мөнх-Оргил гишүүн.

**Ц.Мөнх-Оргил:** Очиржав гэж хүний асуулт дутуу үлдчихлээ Батцэцэг сайдаа. Бусад улс орон дахь Монгол туургатнуудтайгаа харилцах асуудал дэмжих дэмжлэг хэр хийгдэж байна? Гадаад бодлого үзэл баримтлалын хорийн 20.5-д заасан байгаа. Агаарын тээврийн либералчлалыг та ярьчихлаа. Дэлгэрүүлж яривал Болортоль гуайн асуултад дэлгэрэнгүй хариулж болж байна.

Гуравдагч хөршийг хариулчихлаа. V дугаар цахилгаан станцыг энэ Бямба-Очир гэж Баянзүрх дүүргийн 21 дүгээр хорооны иргэний асуултад нэмж хариулж болж байна.

Дээр нь Сонгинохайрхан дүүргийн I дүгээр хорооны иргэн Амаржаргал ийм асуулт ирүүлсэн байна. Монголын түүх соёлын өв, эд өлгийг хилийн чанадад гарсныг тогтоож, эх оронд нь авчрах чиглэлээр ямар ажил хийгдэж байна гэж асуусан байна.

Мөн Бүрэнжаргалын Эрдэнэсанаа Хануул дүүрэг, I дүгээр хороо. Гадаад улс оронд амьдарч байгаад хулгай гэх мэт гэмт хэрэг хийж Монголчуудынхаа болон улсынхаа нэр төрийг гутааж байгаа гэмт хэрэгтнүүдтэй ямар тэмцэл хийх ёстой юм бэ? Та нарын хийгээд байгаа сурталчилгааны ажлыг чинь энэ хэдэн хүн бузарлаад байна шүү дээ гэж асуусан байна. Энэ 4 асуултад тодруулаад хариулчаач.

**Б.Батцэцэг:** Соёлын дэд сайд эхлээд хариулъя.

**Г.Занданишатар:** Шууд асуугаад явна 81.

**М.Батбаяр:** Мөнх-Оргил гишүүний асуултад хариулъя. Тэгэхлээр Соёлын тухай хууль тогтоомж болон олон улсын соёлын хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээр ЮНЕСКО-гийн хамтын ажиллагааны хүрээнд Монгол хэл, соёл уламжлалыг өвлүүлэх ажлыг тасралтгүй үргэлжлүүлж байгаа. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого 2050-д тусгагдсан Нүүдлийн соёл иргэншил Монгол.../үг тасрав./

**Ц.Мөнх-Оргил:** Биш ээ асуулт буруу ойлгоод байна. Даргаа микрофоноо авъя. Харилцан яриад явъя.

**Г.Занданишатар:** Мөнх-Оргил гишүүний микрофоныг байнга нээлттэй байлгаж бай.

**Ц.Мөнх-Оргил:** Энэ тасалчхаад байх юм. Дэд сайдаа Гадаадад байгаа хууль бусаар юм уу ямар нэгэн байдлаар хилийн чанадад гарсан соёлын өвийг тогтоох, эргүүлж авчрах талаар юу хийж байна гэж асуугаад байна шүү дээ.

**Г.Занданишатар:** Шууд асаад байгаа. Микрофон асаачих. 82 Анхбаяр дарга.

**Н.Анхбаяр:** Мөнх-Оргил гишүүнээр дамжиж иргэдээс асуусан асуултад тодруулга өгье. Чингис хаан музей байгуулах цаг үеэс эхлээд гадаадад байгаа Монгол Улсын түүх соёлын дурсгалт өвүүдийг олж тогтоох, Монгол Улсад эх оронд нь авчрах ажлыг бид нар хэрэгжүүлж байгаа. Өнөөдрийн байдлаар маш тодорхой тоо хэлэхэд дэлхийн 11 улсаас 30 үзмэрийн А болон дижитал хуулбарыг авч музейд хүлээлгэн өгсөн байгаа. Гүег хааны үед Ромын паптай харилцаж байсан захидал гээд ер нь энэ дээр бид бол аль болох эх хувиар нь хүлээж авахыг боддог.

Гэхдээ бусад улс орнууддаа энэ эх хувийг нь авах чиглэлээр илүү нарийн сайн ажиллахгүй бол ихэвчлэн хуулбараа өгөөд

байгаа ийм бодитой байдал байгаа. Хуулбарлаж авахдаа ч гэсэн тодорхой хэмжээний мөнгө төгрөг бид нар төсвөөс гаргаж, бараг худалдаж авч байгаа ийм байгаа. Цаашидаа яг энэ олж тогтоосон үзмэрүүдээ илүү олноор олж тогтоох, буцааж авах ажлуудыг үргэлжлүүлэн хийнэ.

Хилийн чанадад байгаа энэ та бүхний хийгээд байгаа гадаад сурталчилгааны Монгол Улсын нэр хүндийг өсгөх ажлыг чинь хилийн чанадад байгаа иргэд унагаад байгаа юм биш үү гэдэг асуудал их хөндөж байна. Харамсалтай нь үнэн. Би энд статистик аваад үзэхэд энэ он гарснаас хойш 71 иргэн гэмт хэрэг, зөрчилд холбогдсон байна. Зөрчилд холбогдсон байна. Хариуцлагатай аялъя, хариуцлагатай аялъя, хилийн чанадад байхдаа суугаа орныхоо хууль тогтоомжийг хүндэлье. Бас нөгөө талаасаа иргэддээ зориулж энэ гэмт хэрэг ийн болон залилангийн шинжтэй буруу зөрүү үйлдэлд оролдохгүй, хамрагдахгүй, татагдан орогдохгүй байх чиглэлээр бид нар зөвлөмжийг байнга өгч байгаа. Энэ бол манай иргэд бол илүү өөрсдөө ухамсартай байж улс орныхоо нэр хүнд, өөрсдийнхөө нэр хүндийг хилийн чанадад зөв зүйтэй авч явах талаас нь бид нар илүү ийм гээгээрүүлэх, ойлгуулах ийм ажлыг үргэлжлүүлэн хийж ажиллана.

Агаарын харилцааг либералчлахын хувьд бол түрүүн ерөнхийдөө бол хариуцтууд хэлсэн. Гэхдээ Засгийн газрын хувьд бол энэ аялал жуулчлалыг хөгжүүлэх, дотоод болон гадаадаас дотогшоо дотооддоо аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр маш дорвитой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа.

Нэгдүгээрт цахим визийг нэвтрүүлсэн. Цахим виз нэвтэрснээр өнөөдөр 99 гадаад улсын иргэд цахимаар визийг 72 цагийн дотор авах боломжтой байгаа. Дээрээс нь Засгийн газрын бодлогын хүрээнд бид нар хуучин 25 улсын иргэд визгүй зорчдог байсныг сая нэмж

36-г нэмээд үндсэндээ ингээд 61 улсын иргэд Монгол Улсад “Welcome to Mongolia” Засгийн газрын бодлогын хүрээнд 2025 оны 12 сарыг дуустал Монгол Улсад визгүй зорчихоор ийм байгаа. Эдгээр шийдвэрүүдийн үр дүн буюу Монголд жуулчилж байгаа гадаадын иргэдийн тоо аажмаар өсөн нэмэгдэж байна.

Агаарын харилцааны хэлэлцээрийг ялангуяа энэ КОВИД-ын дараагаар бол бид нар бүх л улс орнууддаа ашигласан ч, амьдралд хэрэглэсэн ч, хэрэглээгүй ч байгуулах нь зүйтэй юм байна гэдэг өнцгөөс нь ялангуяа Төв Азийн орнууд тэгээд түрүүн бас сайд дурдсан Америк гэх мэтчилэн тодорхой орнуудтай ингээд хэлэлцээ үргэлжлүүлээд явж байгаа. Ийм байна.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Энэ Баянзүрх дүүргийн Очирын Очиржавын асуултад хариулаад өгөөч. Очиржав гуай аягүй бол энийг чинь үзээд сууж байгаа шүү дээ. Тэгээд маш тодорхой асуугаад байна шүү дээ. Бусад улс орон дахь Монгол туургатнуудтайгаа харилцан хамтын ажиллагааг өргөжүүлэх, хэл, соёл, уламжлалаа хадгалан хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлнэ гэж Гадаад бодлогын үзэл баримтлал дээр тодорхой заасан байгаа. Яг юу хийж байгаа вэ? Дэмжиж чадаж байна уу гэж асуугаад байна.

**Б.Батцэцэг:** Энд хариулъя. Монгол үндэсний үнэлэмж гэж ийм хөтөлбөр боловсруулагдсан байгаа. Тэгээд үүнийхээ дагуу бид нар хилийн чанадад ажиллаж байгаа, амьдарч байгаа, сурч байгаа хүмүүсийнхээ хүчийг ашиглах ажлыг бол тодорхой төлөвлөгөөтэй Элчин сайдын яамнууд, дипломат төлөөлөгчийн газруудаараа дамжуулаад хэрэгжүүлж байгаа. Энд хилийн чанадад нийт бүртгэгдсэн 140 гаруй Төрийн бус байгууллага байдаг. Монгол иргэдийн санаачилгаар үүсгэн байгуулагдсан. Энэ иргэдтэйгээ холбоотой ажиллаж маш олон ийм судалгаануудыг хийсэн байгаа.



Жишээлбэл хилийн чанадад сурч байгаа, нарийн мэргэжлээр сурч байгаа, докторын зэрэг хамгаалсан болон тухайн оронд томоохон хувийн хэвшил компаниудад ажиллаж байгаа, олон улсын байгууллагуудад ажиллаж байгаа Монгол иргэдийг судалж, олж тогтоох, уулзах тэдгээрийг бас бид нар зохион байгуулагдаж байгаа арга хэмжээнүүддээ урьж оролцуулах, эх оронд нь буцаад ирэхэд нь бас тодорхой дэмжлэг үзүүлэх, бас бусдад илүү үлгэр дуурайл болох залуучуудад илүү үлгэрлэл болох чиглэлээр нь дэмжиж ажиллах, олон улсын байгууллагуудад бас бид нар Монгол иргэдээ аль болохоор олноор нь сонгуулах, дэмжлэг үзүүлэх. иргэдээ тодорхой хугацаанд ажиллаад туршлага хуримтлуулсан ховор мэргэжилтэй улсуудаа Монгол Улсдаа эргэж ирэх нөхцөлийг нь бүрдүүлэх, татвар нийгмийн даатгал болон ирээд амьдрахад нь илүү нийгэмших, илүү тэр, Тийм тэрийг Соёлын дэд сайд хариулах гэж байсан чинь зогсоочихсон гээд тэгээд байна. Та үргэлжлүүлээд ярьчих.

**Г.Занданишатар:** Зогсоогүй л дээ. Энэ гадаад бодлогын үзэл баримтлалын 25.5-ыг яриад байгаа юм л даа Очиржав чинь. Бусад улс дахь Монгол туургатнуудын харилцаа хамтын ажиллагаагаа хөгжүүлж, хэл, соёл, уламжлалаа хадгалан хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх гэж заасныг яаж эдэлж байна?

**М.Батбаяр:** Би түрүүн хариулж байгаад тасарчихсан юм. Уучлаарай. Алсын хараа-2050, нүүдлийн соёл иргэнишлт Монгол болно гэдэг энэ нүүдлийн соёлын өвөө хадгалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрэх ажилд их манлайлагчийн байр суурьтай байхаар тусгагдсан. Түүнтэй холбоотойгоор өнгөрсөн жил тухайлбал бид нар Нүүдэлчин Монгол наадмыг соёлын биет бус өв, нүүдэлчдийн хадгалж байгаа энэ 362 төрөл зүйлээр Монгол Улсын хэмжээнд зохион байгуулсан. Үүгээрээ Монгол туургатнууд руугаа бүх

сүвгуудаар дамжуулж хүргэсэн. Үүнтэй холбоотойгоор тэр Тэрэлжид болсон 3 өдрийн арга хэмжээнд нийтдээ 24000 хүн цуглаж, мөн тухайн үед 2000-аад гадаад хүмүүс хүрэлцэн ирсэн байдаг. Түүнтэй холбоотойгоор мэдээллийн хэрэгслүүдээр Монгол туургатнууддаа давхардсан тоогоор 16 сая хүнд хүргэсэн ийм тоон мэдээ байдаг юм.

Энийгээ цаашид үргэлж улам үргэлжлүүлж Нүүдэлчин Монгол, Нүүдэлчин олон улсын фестивалийг энэ оноос эхэлж зохион байгуулахаар бэлтгэл ажилдаа орсон байгаа. Энэ хүрээнд Монгол туургатнуудаа илүү их оролцуулах ийм ажлыг одоогоор зохион байгуулаад явж байна. Энэ бүх ажлыг Монгол Улсын гадаадад сурталчлах энэ бодлогын хүрээнд Гадаад харилцааны яамтайгаа хамтраад хэрэгжүүлж байгаа. Одоогийн байдлаар Орос, Хятад, Казак, Киргиз, мөн Тува, Урианхай гээд энэ нийт 14 улсаас оролцохоо мэдэгдээд байгаа.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Энэ гадаад сурталчилгаанд хөрөнгө мөнгөнөөс гадна гол нь бодлого стратеги хэрэгтэй л дээ тийм ээ. Тэгээд л Монгол гэхлээрээ л нүүдлийн мал аж ахуйгаа ч юм уу, онгон байгалиа сурталчлаад байх өрөөсгөл л дөө. Орчин үеийн улс болсноо, Улаанбаатар хотоо, залуучуудаа юу гэдэг юм техник, технологийнхоо ололт амжилтыг ч гэдэг юм уу ингэж хослуулж сурталчилмаар байгаа юм. Тэгээд энэ гадаад сурталчилгааны стратегийн баримт бичиг хамгийн сүүлд хэзээ батлагдсан байна? Хэрэгжилт нь ямар байна, тэр гол санаанууд нь юу байна? Тэрийг юуг нь өөрчилмөөр байна?

**Б.Батцэцэг:** Стратегийг бол бид нар энэ оны 2 сард батлуулсан байгаа. Монгол Улсыг олон улсад сурталчлах стратеги төлөвлөгөө гэж. Тэгээд аялал жуулчлалыг хөгжүүлэх Үндэсний хорооны саналыг тусгаад Монгол Улсыг олон улсад сурталчлан таниулах үйл ажиллагаа идэвхжүүлэх нэгдсэн стратеги



төлөвлөгөө гэж нэрлэсэн. Энэ нь нэгдүгээрт нь хөрөнгө оруулалт, хоёрт нь аялал жуулчлал, гуравт нь хүний эрх, ардчилал, сайн засаглал, цахим хөгжил гэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд боловсруулсан. Тэгээд Засгийн газрын хуралдаанаар танилцуулсан байгаа.

Аялал жуулчлалын Үндэсний хороо гэдэг энэ бүтэц, механизмаар бид нар 7 хоног болгон хуралдаж явц байдлыг нь танилцуулж байгаа. Шаардлагын хувьд мэдээж дэлхий дахин даяаршиж шинжлэх ухаан мэдээллийн технологи асар хурдтай хөгжиж байгаа улс төр, эдийн засгийн интеграцид хэлж улс хоорондын харилцан хамаарал гүнзгийрч байгаа ийм үед Монгол Улсын эдийн засаг, нийгмийн салбарын ололт амжилтыг гаднын улс орнуудад бас тэр хурдаас нь дутахгүй богино хугацаанд сурталчлах, таниулах үйл ажиллагааг идэвхжүүлэх ийм шаардлага үүсэж байгаа.

Тэгээд энэ стратегийг бид нар баталж хэрэгжүүлснээр сурталчлахаас гадна эерэг ойлголт сэтгэгдлийг төрүүлэх өнгөрсөн хугацаан дахь алдаагаа засах, иргэд хоорондын харилцан зуучлах хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг татах, экспортыг дэмжих, эдийн засгийг тэлэх ийм давуу талуудыг бий болгоно гэж үзэж байгаа. Хүлээгдэж байгаа үр дүнгийн хувьд бол стратеги төлөвлөгөөний энэ хэрэгжилт хангагдсанаас гаднын жуулчид болон хөрөнгө оруулагчдын.../минут дуусав./

**Г.Занданшатар:** 20 нь дууссан юм уу? Энэ хариултууд тодорхойгүй гэж. Мөнх-Оргил гишүүн тодруулж асууя. 5 минут.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа энэ ингэмээр юм байна. Манай ажлын хэсгийнхэн энэ иргэдийн асуулт, и-мэйл хаяг эд нар нь байж байгаа байхгүй юу. Тэгээд дэлгэрүүлж хариулах юмнууд байна. Ингээд 20 минутад багтахгүй тийм ээ. Жишээ нь Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын 2 дугаар багийн иргэн

Надмидын Баярт гуай энэ шинжлэх ухаан технологийн салбарын хамтын ажиллагааны асуудлаар асууж байгаа байхгүй юу. Тэгтэл яг энэ нөгөө Монголын сурталчилгаа дотроо орохгүй байгаа учраас энэ эд нарыг нь асууж амжихгүй байна. Тэгээд би ас асуултуудыг нь ингээд и-мэйлтэй нь өгчихье. Та нар дэлгэрүүлээд хариулчхаарай.

Эцэст нь нэг ийм санаа хэлэх гэсэн юм. Энэ сурталчилгааны ажлыг хариуцдаг төрийн нэгж байх хэрэгтэй байгаа юм. Тэгэхгүй Соёлын яам нь болохлоор ингээд соёлоо яриад яваад байдаг, аялал жуулчлал нь болохлоор байгаль орчин, аялал жуулчлалаа яриад яваад байдаг. Уул нь болдог бол энэ бид нар чинь гадаадын хөрөнгө оруулалтын агентлаг байгуулж байгаа шүү дээ Эдийн засгийн хөгжлийн яаман дээрээ. Тэгэхлээр тэр гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, Монголыг гадаадад сурталчлах ажлыг хоёуланг нь зэрэг хийж баймаар байгаа юм. Монголоо ч сурталчилж л байдаг агентлаг, тэгээд хөрөнгө оруулалтыг урамшуулж байдаг. Яг 2-уулаа хоорондоо их уялдаатай асуудал байгаа байхгүй юу.

Тэгэхгүй ингээд олон байгууллагын дунд эзэнгүй явагдаад Монголыг сурталчилна гэдэг чинь ганцхан аялал жуулчлал биш шүү дээ. Ганцхан соёлын ч асуудал биш. Олон бүрэлдэхүүн хэсэгтэй цогц асуудал учраас Батцэцэг сайд энийг Засгийн газрынхаа түвшинд ярьж, бас хариуцсан нэгжтэй. Ажлаа хийлгэхдээ мэдээж төрийн бус байгууллагуудаар, бизнесүүдээр, иргэдээр түрүүн тэр Хан-Уул дүүргийн 12 дугаар хорооны иргэн Ганзориг хэлээд байна шүү дээ. Иргэдийг төрийн бус байгууллагуудыг дайчлаач гээд.

Сүүлд нь нэг санаа хэлчихье. Энэ улс орныг сурталчлах нэг том зэвсэг бол энэ тэнд зохион байгуулагддаг экспонууд байгаа юм. Тэгээд би одоо хэд хэдэн экспонд очиж үзсэн. Тэгээд манай экспонууд ерөөсөө Монголын павильонууд

ерөөсөө яг жилийн жилд л яг адилхан. Тэр нь хаана ч болж байна хамаа байхгүй. Европт ч байна уу, Ази ч байна уу, ойрх Дорнод ч болж байна уу нөгөө л дотоодынхоо үйлдвэрийнхээ хэдэн бүтээгдэхүүнээ аваачаад тавьчихдаг. Тэгтэл жишээ нь юу гэдэг юм, лалын оронд нээх баахан олон архи авчраад тавьчихдаг ч юм уу, эсвэл тэр нөгөө хивсний соёл урлаг их хөгжчихсөн газар ингээд Эрдэнэт хивсээ аваачаад ч юм уу өөр үйлдвэрийнхээ хивсийг Алтанбулаг гээд хивс аваачаад тавьчихдаг. Тэгэхлээр тэр нь ерөөсөө зохицохгүй байгаа байхгүй юу.

Тэгэхлээр дараагийн экспо дээр ийм санал байгаа юм. Ерөөсөө энэ ажлыг Худалдаа аж үйлдвэрийн танхимд хариуцуулаад нэмэргүй. Тэндээс илүү юм гарахгүй. Яг л аж ахуй нэгжүүдээсээ гуйгаад л очоод экспо дээр юмаа тавиад өгөөч л гэж гуйх байхгүй юу. Өөр зохион байгуулж чадахгүй. Тэгэхлээр энийг энэ *public relation* хийдэг ч юм уу нөгөө сурталчилгаа хийдэг манайх чинь олон ингээд дагначихсан янз бүрийн хувийн компаниудтай болчихлоо шүү дээ. Эд нарт гэрээгээр өгмөөр байна. Тэгээд тэр нөгөө интерактив, виртуал орчин цагийн юм хиймээр байна. Үгүй ээ заавал ингээд л нэг бүтээгдэхүүн архи ч байдаг юм уу, ул боов ч байдаг юм уу, эсвэл хивс гээд л ингээд байхгүйгээр ерөөсөө ингээд хараад л виртуал ертөнцөд орлоо. Монголыг 4D-гээр нь, 3D-гээр нь барьж үзэж байгаа юм шиг л ёстой хардаг бол хараад л, тэмтэрдэг бол тэмтрээд үздэг иймэрхүү л орчин цагийн шаардлагад нийцсэн навильон хиймээр байна. Том байх хэрэггүй шүү дээ. Том байх хэрэггүй. Баярлалаа.

**Г.Занданишатар:** Энэ хүмүүс дандаа нөгөө бодитой регистрийн дугаараар бүртгэгдсэн хүмүүсийн асуудал ирж байгаа. Тэр Очирын Очиржав гуайн хариултыг гадаад бодлогын үзэл баримтлалд байгаа учраас их нюанстай асуулт байдаг. Бусад улс дахь Монгол туургатнуудын харилцаа, хамтын

ажиллагаагаа хөгжүүлэх гэдэг чинь нэг ийм бодлого. Тэгээд хэл, соёл, уламжлалаа хадгалан хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлнэ гэж заасан. Тэгээд ямар дэмжлэг үзүүлж байна, ямар стратеги байна гэж асуусан. Тэгээд энийг дангааршиж байж даяаршина гэсэн тэр үзэл баримтлал, бодлого ч дэвшүүлээд байсан учирч байгаа байх. Тэгэхээр тэр талаас нь бас мэйл хаягийг нь аваад хариуг нь өгнө биз.

Одоо ингээд дараа бас энийгээ тодруулж асуух байх гэж бодоод би тодруулж байгаа юм. Соёлын яам талаасаа ч хариулах гэхээсээ Гадаад яам бас анхаарах ёстой асуудал гэж тавьсан байна.

Ингээд Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбандийн Адьшаа Засгийн газрын гишүүнээс асуулт асууна. 20 минут байна. Асуулт, хариулт нийлээд 20 минут гэсэн байна.

**Ш.Адьшаа:** Энэ иргэдээс асуух гээд энэ 7 хүний нэр ирсэн байх юм. Бид дахиад асуух юм уу? Ямар учиртай юм Өлзийсайхан даргаа? Энийг дахиж асуух юм уу? Мэдэхгүй таны асуусан юмыг дахиад асуух юм уу, яах юм? Ойлгохгүй байна л даа. Тэгээд энэ Тамгын газраас л тодруулж байгаа юм. Нэг бол хуваагаад өгчихмөөр байх юм. Ингээд энэ зохион байгуулалт ер нь ямар байна?

Өнөөдрийн энэ Улсын Их Хурлын чуулган дээр Монгол Улсын Ерөнхий сайдаас Монгол Улсыг гадаадад сурталчлах бодлого, стратеги, хамтын ажиллагааг эрчимжүүлэх талаар мэдээлэл өглөө. Мэдээлэлд Улсын Их Хурлын гишүүний хувьд бас нэлээн тийм дундуур сэтгэлтэй байна. Өнөөдөр Монгол Улсын гадаад бодлого гэдэг асуудал бол тэр гадаадад хурал зөвлөгөөн зохион байгуулсан, 1 үзэсгэлэн зохион байгуулсан гэх мэтийн ийм мэдээлэл бол энд ирэх ёсгүй байсан гэж ойлгож байгаа.

Тэгээд бүүр энд Оюутолгойн уул уурхайн олборлолтын тухай мэдээлэл энд өгч байх юм. Энэ Гадаад харилцааны яам чинь энэ Оюутолгойн өмнөөс Оюутолгойг сурталчилдаг ийм үүрэгтэй байгаа юм уу? Ямар учиртай юм? Энэ бол бас их ойлгомжгүй байдал байна шүү. Оюутолгой бол тэртээ тэргүй өөрийнхөө үйл ажиллагааг, өөрийнхөө бизнесийн төлөвлөгөөг олон улсад сурталчилдаг гэж бодож байгаа. Гэтэл энд яахаараа энэ Оюутолгойн асуудлыг өнөөдөр Гадаад харилцааны яам ингэж онцгой анхаарч, ингэж өнөөдөр Улсын Их Хурал дээр ийм хариуцлагатай ийм мэдэгдэл хийж байна. Эндээ сайн дүгнэлт хийгээрэй. Би тэгж сонссон. Буруу сонсоогүй бол.

Ингээд Монгол Улсыг сурталчлах энэ асуудал бол өнөөдөр Монгол Улсын эдийн засгийг, гадаад харилцааг хөгжүүлэхэд хамгийн чухал бодлого байх ёстой гэдэг дээр санал нэг байгаа. Ингээд би 2, 3 асуулт тавья. Энэ өдөр энэ Монгол Улсыг аялал жуулчлалыг хөгжүүлэх жил болгож Монгол Улсын Засгийн газраас зарласан. Олон асуудлуудыг шийдэх Монгол Улсад жуулчдын тоог нэмэгдүүлэх жуулчдаар дамжуулж Монгол Улсад хөрөнгө оруулалт хийх, Монгол Улсын соёл урлагийг сурталчлах, Монгол хүний өв соёл, Монголчуудын амьдрал ахуй, Монголын энэ онгон дагшин байгалийн үзэсгэлэнт газруудаар дамжуулж Монголыг аялал жуулчлалын бизнесийг дэмжих ийм бодлогыг хэрэгжүүлэх талаар Засгийн газар зарласан. Энэ дээр тодорхой асуудал энэ визийн асуудал байгаа юм. Визийн асуудал өнөөдөр энэ авсан мэдээллээр бол манай Монгол Улсын виз бол дэлхийд байхгүй өндөр үнэтэй байдаг гэдэг ийм мэдээлэл байдаг. Хамгийн өндөр үнэтэй визтэй, визийн хураамж авдаг ийм улс гэсэн ийм мэдээлэл байдаг. Энэ ер нь хэр үндэстэй вэ?

Зарим орнууд чинь 10, 20 доллар авч байхад манайх чинь 60, 70 доллар ч авдаг юм уу ийм мэдээлэл байна. Дээр нь энэ жуулчдын визийн асуудлыг хөнгөвчилж

байж бид нар өнөөдөр Монгол Улсад жуулчдыг ирэх боломжийг бүрдүүлнэ. Виз олголт дээр өнөөдөр цахим системд шилжсэн сайн хэрэг. Энэ Засгийн газрын бас энэ цахим засаглалыг хэрэгжүүлж байгаагийн сайн жишээ бол энэ цахим хэлбэрээр виз олгодог.

Урьд нь энэ Хятад энэ тэр чинь визний хулгай луйвар, авлигал гэдэг юм чинь газар авсан ийм байсан шүү дээ. Тэгээд энд энэ визний хураамжийг цаашид энэ олон улсад мөрдөж байгаа түвшинд хүргэх талаар Гадаад харилцааны яам ямар бодлого барьж байна? Энэ визний хураамжийн тухай харьцуулсан судалгаа байдаг юм уу? Тэр дээр үнэлэлт, дүгнэлт өгч байж өнөөдөр энэ визний хураамжийн асуудлаа шийдвэл ямар вэ гэсэн ийм асуудал байна.

Ингээд Монголчууд ч байдаг. Гаднын энэ хойд, урд 2 хөршийн жуулчны визээр орж ирсэн хүмүүс өнөөдөр Монголд олон тоогоор орж ирдэг. Энэ хүмүүс Монголд орж ирээд тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт хийж байгаа. Хоол унд, унаа машин, зочид буудал. Тэгээд энэ 30 хоногийн хугацаанд энд Монголд байрлалчхаад тэгээд гараад энд шон тойрно гээд юм байдаг, яригддаг юм шүү дээ орж ирээд. Энэ бол гадаадад байгаа Монголчуудад байдаг асуудал. Тэгээд ингээд 2 удаа ороод 3 дахиа орж ирэхээр энэ хил, хяналтын байгууллагууд тэр хүмүүсийг хавчин боох, шан харамж авах элдэв байдлаар дарамтлах ийм асуудал гардаг юм байна. Энэ дээр ер нь ямар бодолтой байна? Тэгээд энэ хариултын дараа үргэлжлүүлээд хариулт авъя.

**Б.Батицэцэг:** Адъяаа гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын гадаад сурталчилгаа өмнө нь бол энэ гадаад сурталчилгаанд зориулсан төсөв мөнгө бараг байгаагүй гэж хэлж болох юм. Баахан төлөвлөгөөнүүд хийгддэг байсан нь үнэн. Тэгээд хэрэгцээ, ажил бага байсан. Өнгөрсөн 2 жилийн хугацаанд Засгийн газраас нэлээд олон арга хэмжээ

авсан тухайгаа би дэлгэрэнгүй танилцуулсан. Тэгээд эндээс хамгийн том дэвшилттэй зүйл нь бид нар урт хугацаанд хэрэгжүүлэх төлөвлөлтийнхөө хүрээнд гадаад сурталчилгааг ямар шат дараалалтай, ямар зардал мөнгө гаргаж, яаж, хэрхэн ямар хэлбэрээр зохион байгуулах вэ гэдгээ тодорхойлсон. Тэгээд бид нар энэ энэ жилийн хувьд анх удаагаа гадаад сурталчилгаа дээр тодорхой төсөв тавигдсан.

Үүнийхээ хүрээнд бид нар хамгийн эхлээд томоохон дэлхийн 1 дүгээр зэрэглэлийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй ажиллах, үүнийгээ дагаад бид нар бүх Монгол Улсыг сурталчилсан, таниулсан арга хэмжээнүүдийг Англи буюу олон улсын түгээмэл хэлүүд дээр материал боловсруулах, контент бэлдэх, сурталчлах, энэ материалтай болох ёстой юм гэдэг ажлууд хийгдэж байгаа. Ингэснээрээ бид нар гадагшийгаа энэ дипломатууд төлөөлөгчийн газрууд болон олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр дамжиж гадаад ертөнцөд улсаас урьдчилж ажлыг эхний шатанд хийж байж амжилтад хүрнэ гэж тооцож байгаа юм.

Хоёр дугаар асуудлын хувьд визтэй холбоотой бид нар аялал жуулчлалын жил болгон зарласантай холбоотой 1 дүгээр сард бид нар Монголд ихэвчлэн ирдэг улс орнуудыг бүгдийг нь оруулаад 31 орныг визээс чөлөөлсөн. Визээс чөлөөлөхөөр визийн хураамж гэж огт авагдахаа больсон гэсэн үг. Нийтдээ өнөөдөр Монгол Улсад гаднын улс орнуудаас 61 улс визгүй болсон байгаа. Хуучин 30 улстай визгүй байсан бол 31-ийг нэмж чөлөөлөд өнөөдрийн байдлаар 61 улсын иргэд манайд визгүй явж байгаа. Өөрөөр хэлбэл ямар ч визийн хураамж төлөхгүй болсон гэсэн үг.

Өмнө нь яах вэ бид нар Европын холбооны улсууд жишээлбэл дунджаар 50 долларын визийн хураамж авдаг байсан. Өнөөдөр тэр хураам огт байхгүй. Европын Холбооны Улсуудаас бүгд визгүй

болсон. Европ эргээд манай иргэдэд виз өгөхдөө дунджаар бас 60 евро төлж, визээ Монгол иргэд авч байгаа.

99 оронтой бид нар цахим виз олгодог болсон. Өөрөөр хэлбэл НҮБ-ын гишүүн 193 улсаас бид нар 61 нь огт визгүй болоод, 99 орон цахим виз авч байгаа. Тэгэхээр Монголд ирэх жуулчид, иргэдэд бол асар их ийм хөнгөлөлтүүд үзүүлэх ийм шийдвэр гарсан. Энийгээ ч бид нар бас олон улсад нэлээн сайн сурталчилж байгаа гэж болно. Тэгээд цаашидаа бид нар бүх улсыг визгүй болгох чиглэлдээ ажиллах даалгаврыг Ерөнхий сайдаас авсан ажиллаж байгаа. Зарим тусгай шалгах шаардлагатай орнуудыг үлдээснээс бусдад нь бол визийн хөнгөлөлт олгосон гэсэн үг.

**Ш.Адъяа:** За яах вэ тэр гаднын барууны орнууд өндөр хөгжилтэй орнуудад бол визгүй болсон. Бид нарын чинь бүх харилцаа, гадаад худалдаа, аялал жуулчлал чинь энэ 2 хөршөөс л бүх юм чинь ингээд л уялдаатай явагддаг. Энэ 2 хөршийнхөө иргэдэд энэ визийн талаар ямар хөнгөлөлт үзүүлсэн бэ, ямар бодлого барьж байгаа вэ? Энэ талаар хариултаа авъя.

**Б.Батцэцэг:** Оросын Холбооны Улсын иргэд бол визгүй. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын иргэд визтэй. Гэхдээ хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд бүлэг жуулчид визгүй зорчиж болж байгаа тодорхой хугацаанд. Хятад Улсыг бид нар цахим визэнд хамруулдаг болсон байгаа. Хуучин бол манай дипломат төлөөлөгчийн газрууд дээрээ очиж биеэрээ очиж виз мэдүүлдэг байсан. Тэр өөрчлөгдөөд цахимаар визээ авч ирдэг болсон байгаа.

**Ш.Адъяа:** Тэр түрүүн би хариулт авсангүй л дээ. Энэ манай гадаадад байгаа иргэд ч байдаг тэр багана тойроод орж ирдэг гээд. Тэр 2, 3 удаа орж ирэхээр л ийм асуудал үүсгээд байгаа тухай асуудал яригдаад байдаг. Би ярилаа шүү дээ түрүүн. 1 ороод, 2 ороод, 3



орохоор яахаараа та нар орж ирдэг юм бэ гэж ийм хүнд суртал гаргадаг. Энэ хил хяналтын байгууллага дээр ийм асуудал байна. Тэгээд янз бүрийн айлгаж сүрдүүлдэг, шан харамж авахыг оролддог энэ байдал дээр Гадаад харилцааны яам цаашидаа энэ хил, хяналтын байгууллагуудад уламжилж энэ асуудал дээр бас анхаарах ёстой шүү л гэж хэлж байгаа юм.

Ер нь өнөөдөр Монгол улс жуулчин орж ирж л байвал Монгол Улсад л үр ашигтай л байна гэж ойлгож байгаа. Буудал, хоол, унаа машин гээд л. Өнөөдөр чинь эдийн засаг ямар байгаа билээ, хүмүүсийн амьдрал ямар байгаа билээ. Энэ дээр ингээж анхаарах ёстой гэсэн ийм байр суурь үүртэй байна.

Тэр Монгол Улсад дэлхийг сурталчлахад олон чухал асуудал байгаа гэж ойлгож байгаа. Түүний дотор дэлхийд нэр хүндтэй энэ урлаг соёлын одуудтай хамтарч Монгол Улсад кино, кино контент, бусад соёл урлагийн арга хэмжээ байгуулах ийм гэрээ хэлэлцээр хийсэн үү? Ийм гэрээ хэлэлцээрүүдийг хийх талаар ямар санаачилга гаргаж ажиллаж байна? Энэ бол хамгийн чухал асуудал. Өнөөдөр бол ингээд Монголчууд чинь зөвхөн Солонгосын сериал кино үзээд л тэрүүгээр ингээд байж байдаг.

Гэтэл бол бид нар энэ олон улсын нэр хүндтэй кино хийдэг тэр байгууллагууд, одууд, спортын одууд, түүнчлэн Монгол Улсын төлөө сэтгэл зүрхтэй. Энийг бид нарыг бас дэмждэг ийм хүмүүст хандивлагч бүүр цаашидад зөвлөгөө авах чиглэлээр энэ дээр ямар ийм тодорхой гэрээ, хэлэлцээрүүдийг хийж энэ дээр ямар бодлого барьж байна? Энэ бол хамгийн чухал ажлын нэг л гэж бодож байгаа. Энэ хүмүүсээр дамжуулж Монгол Улсыг сурталчлах асуудал бол нэг Монгол тийм цахим дээр тавьсан бид нарын урлаг соёлын тухай биш, тэр хүмүүс олон нийт рүү, тэр өөрсдийгөө дэмжих рүү хандаж энэ талаар бол асуудал шийдвэл Монгол Улсыг үзэж сонирхох, хангагдах асуудал

бол хамгийн чухал байгаа л гэж ойлгож байгаа.

### **Г.Занданшатар: 81.**

**М.Батбаяр:** Адьшаа гишүүний асуултад хариулъя. Үнэхээр кино урлаг гэдэг бол тухайн улс үндэстнийг гадаад улс оронд сурталчилдаг том хэрэгсэл байдаг. Тийм учраас Монгол Улсын Засгийн газраас энэ соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлд кино урлагийг албан ёсоор оруулж, тодорхой стратегийг батлан гаргасан. Энэ хүрээнд кино урлагийг дэмжих тухай хуулийг Улсын Их Хуралд өргөн барьж, анхдагч хуулийг мөн 22 онд баталсан байгаа.

Үүний хүрээнд Кино урлагийн зөвлөлийг бас байгуулсан үйл ажиллагаа явагдаж байна. Олон улсын нэр хүндтэй кино наадмуудад Монголын киночдыг оролцуулах, түүгээр Монгол уран бүтээлийг гадаад зах зээлд таниулах, мөн гадаадын нэртэй уран бүтээлчдийг хооронд нь холбож өгөх энэ ажлыг төрийн өмнөөс зохион байгуулж байна.

Мөн саяхан өнгөрсөн 22 онд дэлхийн нэр хүндтэй 10 гаруй кино компанийн төлөөлөл продюсеруудад тухайлбал Wagner Brous, HBO, Discovery, Netflix гэх зэрэг энэ 10 гаруй продюсеруудыг Монгол улсад авчирч, Монгол Улсын кино урлаг, киноны хуулиар гадаадын киночдод нээлттэй бодлогыг танилцуулах, Монголын байгаль, цаг уур бас түүх соёлыг таниулсан ийм арга хэмжээг зохион байгуулсан. Кино урлагийн зөвлөлөөр олон улсын кино наадмуудад Монголын киног оруулж байгаагийн дотроос мөн “Трио” кино бол өнөөдрийн байдлаар 4 тивийн 8 кино наадмаас нэр хүндтэй шагналыг хүртээд байна.

**Ш.Адьяа:** Батбаяр сайдын хариулт нэг л худлаа л юм шиг юм хариулчихлаа даа. Энэ дээр бас онцгой анхаарах ёстой шүү. Дээр нь энэ хилийн чанадад Монгол хил дээр үйл ажиллагаа явуулдаг тийм сургууль, цэцэрлэг ер нь



байдаг юм уу? Энэ хэрвээ байдаг бол энэ сургуулиудын хөтөлбөр ямар хил дээр явагддаг юм? Монгол Улсын ер нь стандарттай нийцдэг юм уу? Цаашилаад энэ гадаадын их, дээд сургуулиудад том нэр хүнд бүхий сургуулиудад Монгол хэлийг, Монгол бичгийг оруулах талаар гадаад харилцааны бодлогын хэмжээнд ер нь ямар бодлого баримталж байна вэ? Хэчнээн энэ их, дээд сургуулиуд, олон улсын нэр хүндтэй сургуулиудад энэ асуудлын талаар тавьсан хүсэлт, гарсан үр дүн гэж байна уу? Энэ талаар бас хариулт авъя.

**Б.Батцэцэг:** Адьшаа гишүүний асуултад хариулъя. Бид хилийн чанадад үйл ажиллагаа явуулж байгаа Монгол сургууль, цэцэрлэг, хэл соёлын төвүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг. Сүүлийн 2 жилд Монгол сургууль, цэцэрлэгийн тоо 34%-аар өссөн. Ер нь хилийн чанадад байгаа Монгол иргэдийн тоо өсөж байгаа учраас сургууль цэцэрлэгийн тоо дагаад бас хэрэгцээ шаардлага нь маш хурдтай өсөж байгаа. 2023 оны байдлаар 16 улсын 39 хотын 59 сургуульд нийтдээ 5000 гаруй хүүхэд суралцаж байгаа. Бид 13 байгууллагын төлөөллийг оролцуулаад хилийн чанадад үйл ажиллагаа явуулж байгаа Монгол сургуулийн удирдлага багш нартаа цахим сургалт хийдэг. Тэдэнд тулгамдаж байгаа асуудлыг ишийдвэрлэх, салбар дундын уялдааг хангах чиглэлээр ажлын төлөвлөгөө боловсруулж ажиллаж байгаа. Энэ хүрээнд хилийн чанадад үйл ажиллагаа явуулж байгаа багш нарт тавигдах мэргэжлийн стандарттай болох, багшлах эрхийг баталгаажуулсан баримт бичиг, хууль, эрх зүйн орчныг тодорхой идэвхжүүлэх, хүүхдүүдэд зориулсан хүүхдийн нэвтрүүлэг, контент, хөтөлбөрүүдийг бэлтгэх, түгээх зэрэг ажлуудыг төлөвлөж холбогдох байгууллагуудтай нь шат дараатай хэрэгжүүлж байна.

Эхний ээлжид Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний бодлогын үндэсний зөвлөлтэй хамтраад

хилийн чанадад Монгол сургууль хэл соёлын төвүүдийг багшийн мэргэжил, заах арга зүйг дээшлүүлэх ийм цахим сургалтыг тогтмолжуулсан байгаа. Заах арга зүйд 20 гаруй цахим сургалтыг цувралаар 1 жилийн хугацаанд тасралтгүй зохион байгуулсан 2022 онд. 100 гаруй багшийг хамруулсан. Сургалтад хамрагдсан багш нарын боловсролын нэгдсэн системд бүртгэж сертификат олгохоор ажиллаж байгаа. Хилийн чанадад Солонгос улсад хамгийн олон Монгол иргэд байгаа. Тэнд Монгол томоохон сургууль байдаг. 400 гаруй хүүхэдтэй. Бусад газруудад бол ихэвчлэн хэлний сургалтын төвүүд байдаг Монгол хэлний. Өөрсдөө тухайн суугаа орныхоо сургуульд суралцаад тодорхой цагуудаар Монгол хэлний хичээл авах ийм төвүүд байгуулдаг. Тэр төвүүдийг нь бид дэмжиж сурах бичиг, материалаар хангах.

Багш нарын хувьд бас хэцүү асуудлууд нэлээн байдаг юм байна лээ. Тогтмол оршин суудаггүй, олон жил ажилладаггүй, хөдөлгөөнтэй голдуу байдаг учраас богино хугацаанд мэргэжил дээшлүүлэх, зарим газар мэргэжлийн бус улсууд бас заах, багш нарын хомсдолтой байх ийм асуудлуудыг бид нар байнгын заавар, чиглэл өгөх, хамтарч ажиллах хэлбэрээр дэмжлэг үзүүлээд явж байгаа.

**Ш.Адьяа:** Энэ боловсрол, сургуультай холбогдуулаад ер нь цаашилаад асуухад энэ Монгол Улсын энэ боловсролын өнөөдрийн энэ тогтолцоо нэн ялангуяа өнөөдөр Монгол Улсад сургууль төгссөн энэ дипломын асуудлыг ерөөсөө хаана ч ингээд хүлээн зөвшөөрөхгүй байгаа. Энэ асуудлыг цаашилаад өнөөдөр дэлхий нийт даяарчлагдсан Монгол Улсад бас сайн ийм боловсрол олгох энэ тогтолцоо бол бас тодорхой хэмжээнд нэлээн дээшилсэн ийм үр дүнтэй байгаа гэж ойлгодог.

Гэтэл энэ асуудлуудыг олон улсын тэр ЮНЕСКО олон улсын байгууллага энэ тэр зэрэг энэ боловсрол ялангуяа өв соёл,

уламжлал, уламжлалт анагаах ухаан, уламжлалт урлаг, соёлын энэ асуудлаар энэ Монгол улсын их, дээд сургуулийг дүүр.../минут дуусав./

**Г.Занданишатар:** 20 минут дуусчихсан уу? 5 минут сунгачих. Асуулт, хариултыг.

**Ш.Адьяа:** Тийм тэр боловсролын энэ дипломыг цаашидаа хүлээн зөвшөөрүүлэх асуудлыг өнөөдөр энд Монгол Улсын гадаад бодлогын хамгийн чухал асуудал байх ёстой. Бид өнөөдөр олон их, дээд сургууль боловсрол эзэмшиж байна. Олон ууган сургуулиуд, Монгол улсын их сургууль ч гэсэн төгссөн энэ боловсролын тогтолцооныхоо асуудлыг бид өнөөдөр хуулиараа шийдэх гэж байгаа.

Гэхдээ энэ асуудлыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрүүлж байж Монгол хүний үнэлэмж, Монголыг сурталчлах, Монголын их, дээд сургуулийг хүлээн зөвшөөрүүлэх ийм түвшний асуудлыг өнөөдөр Монгол Улсын гадаад бодлого байх ёстой шүү. Бодлогын хамгийн чухал бичиг баримт. Энэ талаар ер нь хийж хэрэгжүүлсэн, санаачилсан, дэвшүүлсэн ийм зорилт байна уу гэдэг талаар хариулт авъя.

**Г.Занданишатар:** Микрофоноороо шууд хэлчихдэг юм. 81, 82 юм уу?

**Н.Анхбаяр:** Адьяа гишүүний саналыг ойлголоо. Бид Монгол улсын боловсролын ялангуяа бакалаврын түвшний сургалтын гэрчилгээг олон улсад хүлээн зөвшөөрөх ажлыг тогтмол хийж ирсэн. 2, 3 үндсэн арга байна.

Нэгдүгээрт, ялангуяа манай улсын иргэд олноор зорчдог дийлэнх орнуудтай боловсролын гэрчилгээг харилцан хүлээн зөвшөөрөх гэрээ хэлэлцээрүүдийг байгуулчихсан байгаа. Жишээлбэл, Бүгд Найрамдах Хятад Улс Улс, Европын орнууд гээд.

Хоёрдугаарт яг ийм тодорхой тохиолдлууд байх юм бол та бүхэн бас та манай яаманд өгөх юм бол бид тэр асуудлыг судлаад шийдвэрлэж болно. Хамгийн гол олон улсын I конвенц байгаа юм. Тэрэнд Монгол Улс нэгдээд орчихсон. Тэр нь юу вэ гэхээр Монгол Улсад үйлдсэн баримт бичгийг гадаад улсад хүлээн зөвшөөрүүлэх буюу бид нар амьдралд апстил гэж нэрлэдэг. Тэгээд тэр гэрчилгээг аваад гадагшаа ахисан түвшний болон анхан түвшний бакалаврын түвшинд болон магистр, докторын түвшинд сурч байгаа хүмүүсийн боловсролын гэрчилгээг бид нар баталгаажуулснаар тухайн гэрчилгээ буюу Монгол Улсын энэ боловсролын эрдмийн зэргийн гэрчилгээнүүд дэлхийн бараг үндсэндээ 100 энэ конвенцын гишүүн бараг 100 гаруй орнуудад бүх улсад нь хүлээн зөвшөөрөгдөөд явж байгаа. Яг одоо бид нарын, бид нарт миний боловсролын гэрчилгээг хүлээн зөвшөөрөхгүй байна гэдэг ийм тодорхой өргөдлүүд бол бараг үндсэндээ байхгүй. Байвал ер нь тийм өргөдөл манай яаман дээр ирдэггүй юм даа.

Тэгэхээр ийм тохиолдол байх юм бол бид нарт өгөөд Боловсролын яамтайгаа бас тэр сурах гэж байгаа орнуудтай нь харилцан хамтраад ажиллаад шийдэл олж болно гэж бодож байна. Товчхондоо хэлэхэд бол манай улсын боловсролын эрдмийн зэргийн гэрчилгээ дэлхийн бүх оронд үндсэндээ хүлээн зөвшөөрөгдөж байгаа гэж хэлье. Баярлалаа.

**Г.Занданишатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан. Бүлгээс төлөөлсөн асуулт иргэдээс ирүүлсэн асуултуудыг асууж дууслаа. Цахим хуудсанд иргэдээс ирүүлсэн асуултыг Тамгын газар нэгтгэж, нам эвслийн бүлгүүд, намын бүлгүүдэд хүргүүлсэн. Тэгээд намын бүлгүүд дээрээ энийгээ бас нарийвчилж ярьсан байх. Энэ асуултуудад Гадаад харилцааны яам, сайд, холбогдох албан тушаалтнууд мэйл хаягаар нь болон шуудангийн хаягаар нь жич хаяг хүргүүлээрэй. D-Parliament

цахим системд хаяг адресаараа, регистрийн дугаараа тодорхой бүртгэж орж ирж байгаа асуултууд байгаа учраас буцах хаяг нь байгаа байх. Лхагвасүрэн дарга хаягийг нь өгөөд. Нууцлалд, хувь хүний нууцлалд халдахгүйгээр мэйл хаягийг нь л өгч болно.

Ингээд үдээс хойших нэгдсэн хуралдаанаар мэдээлэл сонслоо. Монгол Улсыг гадаадад сурталчлах бодлого, стратеги, хамтын ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Гадаад харилцааны сайд Батмөнхийн Батцэцэг мэдээлэл хийлээ, сонслоо.

**Мэдээлэл танилцуулъя. Өргөн баригдсан хуулиудыг чуулганы нэгдсэн хуралдаанд уншиж танилцуулах ёстой.**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19.1-д заасны дагуу Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрвээ уг асуудал хэд хэдэн Байнгын хороонд хамаарах бол холбогдох Байнгын хороодын хамт бусад Байнгын хороог Даргын дэргэдэх зөвлөлтэй хамтран тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг танилцуулъя. Энэ 7 хоногт. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд нарын 4 гишүүн өргөн мэдүүлсэн байна. Төрийн байгуулалтын байнгын хороонд хуваарилсан.

Мөн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл, Дашидондогийн

Ганбат нар 4 дүгээр сарын 5-ны өдөр өргөн мэдүүлсэн. Мөн Төрийн байгуулалтын байнгын хороонд хуваарилсан байна.

“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдөр Улсын Их Хурал Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг буцаах нь зүйтэй гэсэн Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хууль санаачлагчид буцаасугай.

Эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Энэ хуулийг ингээд буцаасанд тооцлоо.

Өөр ямар асуудал байна? Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Нэгдсэн хуралдаанаар Засгийн газрын гишүүнийг нөхөн томилох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэхээр өнөөдөр Улсын Их Хурлын Даргын дэргэдэх зөвлөлөөр шийдвэрлэж, хэлэлцэх асуудлын тов дараалалд нэмж оруулсан байна. Нэмж оруулсан. Ингээд хэлэлцэх асуудлыг 5 цаг 30 минутаас хэлэлцэх учраас 5 цаг 30 минутад Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан үргэлжилнэ. Тэр хүртэл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан завсарласныг мэдэгдье. 5.30-аас чуулганы нэгдсэн.

15.40 цаг

**ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН  
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ /ҮРГЭЛЖЛЭЛ/**

Баасан гараг 07 Дөрөвдүгээр сар  
2023 Төрийн ордон “Их  
хуралдай” танхим 17 цаг 46  
минут.

**Г.Занданшатар:** Их Хурлын эрхэм гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. 2023 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сарын 7-ны өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Түрүүн түр завсарлуулсан. Өнөөдөр Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцээд Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонсож, Засгийн газрын гишүүний тангараг өргөх ёслолын ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөж, Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлөөс шийдвэрлэж хуралдааны тов дараалалд өөрчлөлт оруулсан.

**Тав. Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонсоно.**

Дараа нь шинээр томилогдсон Засгийн газрын гишүүний тангараг өргөх ёслолын ажиллагаа болно.

Ер нь бол Үндсэн хуулийн тайлбарт Чимэд гуай, Үндсэн хуулийг зохиогч Чимэд гуай, Лүндэндорж академич Үндсэн хуулийн тайлбар номдоо ч тангараг өргөх ёслолын ажиллагаа гэдэг зөвхөн ёслолын ажиллагаа биш юм. Энэ бас Монгол төрийн нэг чухал арга хэмжээ, хууль тогтоох ажлын нэг хэсэг юм гэж бас дүгнэсэн байдаг.

Тийм учраас тангараг өргөх ёслолын ажиллагаа гэдэг бас төрт ёсны

чухал Үндсэн хуулийн арга хэмжээ гэж бас ойлгох ёстой юм байна лээ.

Улсын Их Хурлын гишүүд чуулганы танхимд цусалсан. Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн гишүүддээ Ардчилсан нам байгуулагдсаны 33 жилийн ойн мэндчилгээг дахин дэвшүүлье.

Монголын Ардчиллыг хөгжүүлэх, төлөвшүүлэх, хүний эрхийг хамгаалсан хүмүүнлэг ардчилсан нийгэм байгуулахад бас Ардчилсан намын үүрэг роль их чухал. Тийм учраас парламентад цөөнхийн өмөг түшиг нь бол Улсын Их Хурлын дарга байх ёстой гэж байгаа юм. Тийм учраас Ардчилсан намын бүлэг, бас энэ цөөнх, аливаа хэлбэрийн цөөнх санал хураалт дээр ч гэсэн ингэж цөөнх, олонх болж мэтгэлцэж байж тэндээс үр дүнтэй зөв хууль гарна.

Тийм учраас энэ цөөнхийн үйл ажиллагааг би аль болох дэмжих тийм чиглэл барьж байгаа.

18.11 цаг

**Зургаа.Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонсоно.**

Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай асуудлыг Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ танилцуулна. Индэрт урьж байна.

**Л.Оюун-Эрдэнэ:** Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар Хүрэлбаатарын Булгантуяаг сэлгэн ажиллуулах нь зүйтэй гэж үзлээ.

Нийгмийн даатгалын багц хууль, Хуримтлалын нэгдсэн сан, Баялгийн



сангийн багц хууль Улсын Их Хурлаар хэлэлцэгдэж, Засгийн газар, Үйлдвэрчний эвлэл, Ажил олгогч эздийн холбооны 3 талт хэлэлцээрийг олон улсын жишигт нийцүүлэн шинэ түвшинд гаргах, төрийн албан хаагчдын цалин, тэтгэврийн зөрүүг арилгах, цогц шинэчлэл хийх зэрэг тухайн салбарт тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд Сангийн дэд сайд болон Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнээр ажиллаж буй туршилага нь нийцнэ гэж үзлээ.

Мөн хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг эмэгтэй улс төрч удирдах нь илүү дэвшилттэй гэж шийдсэн болно.

Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлсэн “Шинэ сэргэлтийн бодлого” амжилттай хэрэгжиж, манай улсын экспортын орлого 2022 оны байдлаар 12.5 тэрбум ам долларт хүрсэн түүхэн дээд амжилт үзүүлж, улсын төсвийн орлого мөн анх удаа 1.5 их наяд төгрөгөөр давж, цар тахлын оргил үед -4.6 хувиар агшсан эдийн засаг 4 хувийн өсөлттэй гарлаа.

Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны даргын албан тушаалд Буяа овогтой Тулгыг томилж нь зүйтэй гэж үзэв.

Байгаль орчин, ногоон хөгжлийн дэд сайд, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайдаараа төрд ажилласан. Монгол Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын эдийн засгийн коридорын яриа хэлцлийг ахиулахад Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын даргын ажлын албанд ажилласан улс төрийн туршилагыг нь харгалзаж үзлээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Шинээр томилогдож буй сайд нарын намтрыг тараасан болно.

**Г.Занданшатар:** Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Монгол Улсын

сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Дашизэвэгийн Амарбаясгалан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Бямбажавын Ганбат, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Чулуунбаатарын Дондогмаа.

Ерөнхий сайд болон томилогдох этгээдээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу? Идэрбат гишүүнээр тасаллаа. Цагаанхүүгийн Идэрбат гишүүнээр тасаллаа. Одоо Ширнэнбаньдын Адьяаа гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Ш.Адьяаа:** Өнөөдөр Монгол Улсын Ерөнхий сайд Монгол Улсын Үндсэн хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Засгийн газрын гишүүдийг томилох асуудлыг өнөөдөр Улсын Их Хурал хэлэлцэж байна. Би Монгол Улсын Ерөнхий сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд хоёроос асуулт асууя.

Өнөөдөр Монгол Улсын Боомтын сайдаар Тулгыг оруулж ирсэн байна. Энэ томилгоо улс төрийн шийдлийн хувьд ямар томилгоо вэ? Энэ бол Монгол Ардын Хувьсгалт нам, Монгол Ардын намын хоорондын улс төрийн тохиролцооны үндсэн дээр тавигдсан томилгоо гэж ойлгох уу? Аль эсвэл Монгол Улсын Ерөнхий сайд бүрэн эрхийнхээ хүрээнд Тулгад бас ачаа үүрүүлэх ийм бодлогын хүрээнд тавигдаж байгаа томилгоо юу гэдэг талаар нэг асуулт асууя.

Булгантуяа сайд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдаар томилогдож байгаа юм байна. Тэгэхлээр Монгол Улсын нийгмийн хамгааллын бодлого түүний дотор энд хуримтлагдсан олон асуудлууд байгаа. Түүний дотор ард иргэдийн амьдралын түвшинд доошилсон, ялангуяа төрийн үйлчилгээний албан хаагчид, соёл урлагийн байгууллагын ажилчдын цалин хөлс өнөөдөр Монгол Улсын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд хүрэх тав,

зургаан зуун төгрөгийн цалинтай байгаа. Энэ асуудал үнэхээр маш хүнд нөхцөлд урлаг соёлынхон, төрийн үйлчилгээний албан хаагчид ийм хэмжээний мөнгөөр өнөөдөр амьдралаа залгуулах асуудал үнэхээр хүнд байна.

Өнөөдөр юмны үнэ өссөн, бензин шатахууны үнэ өссөн, үүнтэй холбогдуулж өнөөдөр энэ хүмүүс өлөн зөлмөн амьдарч байна. Нуух юм байхгүй. Энд энэ асуудлыг хэдий хугацаанд, нэн ялангуяа энэ урлаг соёлын байгууллагын хүмүүсийн цалин, төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх ямар боломж байна? Энийг ойрын хугацаанд шийдэх асуудлыг Улсын Их Хурал оруулж ирэх ийм бодлогын талаар 2 асуулт асууя.

**Г.Занданшатар:** Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ хариулна.

**Л.Оюун-Эрдэнэ:** Адьшаа гишүүний асуултад хариулъя. Юуны өмнө өнөөдөр Ардчилсан намын бас түүхт 33 жилийн ой тохиож байгаа юм байна. Ардчилсан Монгол Улсыг нэг айл гэж үзвэл хоёр том тулгуур баганын нэг. Ардчилсан намын өнгөрсөн 30 жилийн түүх бас Монгол Улсын түүх юм.

Тэгээд та бүхэндээ, бас нийт гишүүд, дэмжигчдэдээ Ерөнхий сайдын хувьд бас Монгол Ардын намын даргын хувьд баяр хүргэе гэж бодож байна.

Адьшаа гишүүний асуултад хариулъя. Бид нар бүгдээрээ л мэднэ. Цар тахал дэлхийн геополитикийн нэн амаргүй нөхцөл байдал зөвхөн Монголд биш дэлхий даяар л өрнөж байна. Жил гаруйхны хугацааны өмнө манай эдийн засаг - 4.7 хувь, төсөв 23 хувийн тасалдалтай дараалсан ийм өрийн дарамтад орчихсон. Ер нь Монгол Улс дефолт буюу дампуурал зарлах уу үгүй юу гэдэг ийм 2 сонголтын өмнө л та бид байлаа. Чуулган танхимаар хуралдаж чадахгүй түвшинд хүртэл бид нар

хамтдаа орж байсан ийм хүнд өдрүүд байлаа. Хамтдаа даван туулж байна.

Энэ -4.7 хувь байсан эдийн засаг сая төсөв хэлэлцэж байх үед үндсэндээ хасах баланстэй биш түвшин рүү л орж байсан. Одоо бол эдийн засаг 4 хувийн өсөлттэй явж байна.

Цаашилаад экспорт энэ хэвээр үргэлжилж чадвал 5-6 хувийн өсөлттэй гарах ийм урьдчилсан прогноз байна. Энэ тоо улсын төсөвт хэрхэн нөлөөлөх вэ гэвэл 6 сарын 1 гэхэд 500 орчим тэрбум төгрөгийн ийм эх үүсвэр бидний төсөвлөсөн төсвөөс илүү гарах ийм магадлалтай гэж үзэж болно. Энэ амжилтаа хадгалаад явж чадвал бид нар энэ төсвийн жилийн төгсгөл гэхэд 1 орчим их наяд төгрөгийн ийм давуу төсөвтэй гарах ийм боломжит нөхцөл байдал руу явж байна гэж ойлгож болно.

Мэдээж энэ хуримтлагдсан санхүүжилтийг хэрхэн шийдвэрлэх вэ гэдэг бол энэ парламентын онцгой бүрэн эрхийн асуудал. Төсвөө сайжруулаад явах нэг хувилбар бий. Эсвэл давсан орлогыг юунд зарцуулах вэ гэдэг тодотгол хийх 2 дахь хувилбар бий. Мэдээж экспорт болон бусад асуудлууд дээр бид нар тогтворжуулах хэд хэдэн ийм асуудлуудыг олон улсын банк санхүүгийн байгууллагуудтай нягталж үзэж байгаа ийм асуудлууд байна. Энэ эцсийн дүгнэлт 5 сарын сүүл гэхэд гарна гэсэн ийм урьдчилсан хүлээлттэй байж байгаа.

Энэ үед боломжит санхүүгийн энэ асуудлуудыг бид нар цалин, тэтгэвэр тэтгэмжид зарцуулах уу эсвэл зарим бүтээн байгуулалтын асуудалд зарцуулах уу, эсвэл төсвөө сайжруулаад явах уу гэдгийг Монгол Улсын Засгийн газраас нээлттэй Улсын Их Хуралд оруулж ирнэ гэсэн ийм бодолтой байж байгаа юм.

Юутай ч бид нар цар тахлын болон геополитикийн хүнд сорилттой дампуурлын өмнө байсан цаг хугацаа харьцангуй наашилж эхний эерэг

үзүүлэлтүүд гарч байгаа ийм цаг хугацаа гэж үзэж болно.

Булгантуяа сайдын хувьд энэ салбарыг эмэгтэй улс төрч авч явах нь зүйтэй гэж үзсэн. Яагаад гэхлээр энэ нийгмийн тулгамдсан бас олон асуудлууд байдаг ийм салбар. Эдийн засгийн 3 коридортой холбоотой асуудал дээр Тулга залуу нэр дэвшигчийг энэ тал дээр томоохон ийм дэвшлийг гаргах ийм боломжтой гэж үзэж байгаа. Яагаад гэхлээр энэ дээр хийн хоолой болон бусад асуудалтай холбоотой мөн сая хэд хэдэн улсууд эдийн засгийнхаа бодлогыг шинэчилж зарлаж байгаатай холбогдуулсан ийм мэдээллүүд гарсан. Та бүхэн үзсэн байх.

Тэгэхээр яг энэ хүрээнд Тулгын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын даргын Ажлын албанд ажиллаж байсан тухайн гэрээ контракт дээр тухайн үед ажиллаж байсан энэ туршлага нь энэ асуудлыг илүү хурдтай урагшлуулахад дөхөм болно гэсэн ийм үндэслэлийг гаргаж энэ албан тушаалын томилгоог хийж байгаа гэдгээ хэлье.

**Г.Занданшатар:** Одоо Булгантуяа дарга, Хүрэлбаатарын Булгантуяа.

**Х.Булгантуяа:** Адьшаа гишүүний асуултад хариулъя. Засгийн газар дээр энэ төрийн албаны цалингийн тогтолцоог шинэчлэн сайжруулах ажлын хэсэг гараад бас ажиллаж явж байгаа. Ер нь яг таны хэлж байгаа үнэн. Салбар салбарын ТҮ-3 гээд л тэгэхэд нэг салбарынх нөгөө салбарын ТҮ-3-аасаа цалингийн хувьд ялгаатай.

Тэгээд аймаг орон нутагт бас сая Улсын Их Хурлын гишүүдийн хувьд ч гэсэн тойрогтоо ажиллаж байхад хамгийн их гаргасан санал асуулт бол яг энэ төрийн албаны ажилчдын цалингийн асуудал байсан. Түүн дотроо соёл гээд зарим салбарууд үнэхээр доогуур байна. Үүний тогтолцоог сайжруулах асуудлаар

Засгийн газар дээр ажлын хэсэг гараад бас ажиллаж байгаа. Үүнтэй холбоотойгоор Улсын Их Хурлаар удахгүй ер нь энэ төрийн албаны шинэчлэлийн асуудлыг бас оруулж ирж батлуулах байх.

Ер нь төрийн албаны тогтолцоог сайжруулах нэгдүгээрт үүний дараа дараагаар энэ төрийн албаны цалинг нэмэгдүүлэх, цаашид заавал улс төрийн шийдвэр гаргахгүйгээр төрийн албаны цалинг инфляцтай уялдуулж нэмэгдүүлдэг болох ийм шийдвэрийг Улсын Их Хурал гаргаж байж манай төрийн албаны албанд ажиллах боловсон хүчин илүү сайжирч, дээрээс нь нэмээд илүү тогтвортой ажиллах боломж бололцоо бас бий болох юм байна лээ.

**Г.Занданшатар:** Салдангийн Одонтуяа гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**С.Одонтуяа:** Булгантуяа гишүүнээс асууя. Тэгэхээр та бол энэ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд. Тэгэхээр та бол хамгааллын сайд гээд л өөрийгөө ойлгочих. Эмэгтэйчүүдийг яаж хамгаалах юм, Монголын гэр бүлийг яаж хамгаалах юм, Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг яаж хамгаалах юм, Монголын хүүхдийг яаж хамгаалах юм гэдэг таны 1 дүгээр зорилго бол энэ Хамгааллын сайд шүү.

Тийм учраас энэ үүргээ маш сайн ухамсарлаж ажиллах ёстой. Бид гадаадаас бүх зүйлийг авч болдог юм байна. Мөнгө байхгүй бол зээлдэг юм байна, тоног төхөөрөмж, яг энэ Монгол хүүхдийг төрүүлдэг Монгол ээжүүд энэ бид нарын гол үнэт зүйл энэ л байгаа. Тэгэхээр энэ хүмүүсийн чинь ачаа бол дааж давшгүй хүнд байна шүү. Залуучууд өнөөдөр гадаадад гарна, ажил хий хийнэ гээд яваад өгч байна. Ээжүүд эмэгтэйчүүд бид чинь ерөөсөө л яг энэ зовлонтойгоо тулаад л амьдралыгаа ингээд л авч явах гээд л нуруундаа үүрээд л зүтгэж байгаа. Тэгэхээр энэ чиглэлээр би эмэгтэй сайд томилогдсонд баяртай

байгаа. Өнөөдөр Монголчууд бид нар дэндүү цөөхөн байна 3.3 сая. Тэгэхээр энийг явал Монголчууд олуулаа болох юм гэдэг дээр та бол бас тусгайлан ажиллах хэрэгтэй.

Миний бас онцгойлон хүсэх зүйл 7 жилийн дунджаар тооцдог байсныг 5 жилийн дунджаар олгоё гээд манай Пүрэвдорж тэргүүтэй гишүүд их олон л жил яриад байгаа. Тэгээд энэ хуульд орчихсон байгаа. Багц хуульд. Тэгэхээр энийг та шийдээрэй. Эндээс хамгийн их хохирдог нь эмэгтэйчүүд байгаа. Эмэгтэйчүүд 7 жилийн дундаж гэж бараг байдаггүй юм. Тэгэхээр энэ бараг эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхсан эмэгтэйчүүдийн эсрэг бараг гэмт хэрэг шүү. Тэд нар чинь хүүхэд гаргана, өвчтэй хүмүүсээ асарна, 7 жилийн дундаж байгаад байдаг эмэгтэй ер нь их цөөхөн байгаа.

Хоёрдугаарт энэ би бас өмнө нь таныг бас сайд болоход хэлж байсан. Та Сангийн яаманд олон жил ажиллачихсан бол дандаа яаж мөнгө хэмнэх вэ л гэж боддог. Тэгэхээр энэ хүүхдүүдээсээ битгий харамла, энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдээсээ битгий харамла, ээжүүдээсээ битгий харамла. Эрэгтэй улс төрчид чинь хэмнэх биш яаж хулгай хийх вэ гэдгийг олноор нь тооцоолчихсон байдаг байхгүй юу. Тийм учраас мөнгө байгаа, нүүрсний хулгай хэдэн тэрбум, төмөр замын хулгай чинь. Тэгэхээр та зоригтой энэ тусламж хэрэгтэй байгаа хүмүүсээ хамгаалсан шиг хамгаалаад зоригтой дуугараад ажиллаарай гэж би таныг хүсэж байна.

Тэгээд Гэр бүлийн тухай хууль бол төрөөс дэмжинэ л гэсэн общий үг байдаг юм. Тэгэхээр яг яаж дэмжих юм? 2 хүүхэдтэй бол яаж дэмжих юм? 3 хүүхэдтэй яаж дэмжих юм? Энийг тодорхой заасан ийм хууль хэрэгтэй байна.

Тулгат даргынхыг тусад нь асуух билүү даргаа? Сайдынхыг?

**Г.Занданшатар:** Хамт. Та ялгаварлан гадуурхахгүй шүү.

**С.Одонтуяа:** Хамт уу тээ? Тэгэхээр Тулгат сайдаас нэг зүйлийг л хүсье. Энэ бид нар чинь дандаа л хулгай ярьсаар байгаад эдийн засгийн хөгжлөө л ярьдаг болмоор байна бид нар. Тэгэхээр энэ боомтоо хурдхан шиг тэр хаалттай байгаа боомтуудаа хурдан нээ, холбохыг нь хурдан холбо, ерөөсөө энэ иргэний агаарын тээвэр либералчлал би сайн хийгээд байгаа гэж хэлээд байгаа шүү дээ. Сайныг бол сайнаар. Энэ боомтуудынхаа асуудлыг хурдан шийдээч ээ. Тэр хил орчмын худалдаагаа хөгжүүлж цахимжуулалтаа яаралтай хий. Ер нь энэ боомтууд л хурдан сайн ажиллаж чадах юм бол манай гол экспортын нүүрс чинь мөнгө болж орж ирнэ.

Тийм учраас энэ дээр таныг бүүр яг энэ боомтын сэргэлт гээд бодлогынхоо хүрээнд энэ боомтууд дээрээ сайн ажиллаач. Ер нь бид нар яг нэг сайхан эдийн засгийн ийм таатай үе байхад л тэгээд хэдэн боомтоо хаачаад л ингээд суугаад байдаг ийм зүйлүүдийг л хэлэх гэсэн юм. Тэгээд залуу хүн бас зоригтой ажиллаж чадах байх. Сая бид нар тэр Хилийн боомтын түр хорооны шинжээчдийн дүгнэлтийг сонслоо л доо. Үгүй ээ нөгөө цахимжсан Монгол чинь ч хаачсан юм, хэчнээн машинаар нь хулгай нь явж л байдаг тэр. Тэр үед тэр юмнуудыг нь яагаад гаргаж чадаагүй юм, тодорхойлж чадаагүй юм? Энэ тусдаа сонсгол дээр бид нар ярина.

Тэгэхээр энэ одоо цахимжуулалт.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ хариулж, үг хэлнэ.

**Л.Оюун-Эрдэнэ:** Би зүгээр нэг зүйл дээр хулгай, эдийн засгийн өсөлт 2 чинь нэг зүйл болчихоод байна л даа Одонтуяа



даргаа. Энэ Бадамжунай гэж хүн ирснээс хойш л ийм зүйл сүүлийн 2 хоног л их явлаа. Ер нь хулгайтай тэмцэх чинь буруу юм байна. Ер нь өрөвдөж хайрлах ёстой юм байна Монголчууд бид. Ер нь Засгийн газар бол эдийн засгийнхаа л ажлыг хийгээд ер нь чимээгүй явж бай. Тэр ажнай Бат-Эрдэнэ рүү дайраад байдаг бол маш буруу. Нүүрсчдийнхээ хулгайтай тэмцэх нь ер нь буруу юм байна. Яах нь вэ тэр хөөрхий Бадамжунайг барьж авчраад гээд. Нэг ийм зохион байгуулалттай зүйл их явлаа.

Тэгэхлээр бид ингэж ухрамгүй л байгаа юм. Бид ингэж ухрамгүй байгаа юм. Энэ дээр улс төржиж болно. Энэ дээр өнөөдрийг хүртэл ямар нэгэн байдлаар би улс төрийн тийм мэдэгдэл огт хийхгүй л ирсэн. Гэхдээ, гэхдээ, гэхдээ улс төрийн ямар ямар шийдвэрүүд гарч, хөшигний ард юу болж байгааг би битгий хэл Монголын ард түмэн бүгдээрээ л мэдэж байгаа. Энэ дээр би ухрахгүй ээ Одонтуяа даргаа. Монгол улсын Засгийн газар авлигатай, хулгайтай тэмцэх нь Үндсэн хуулиар олгогдсон гэмт хэрэгтэй тэмцэх ийм ажил нь. Одоо энэ эдийн засгийн үр дүнгүүд энэ Тавантолгойд гарсан 100 долларын нүүрсийг 180 доллар болгосонтой дийлэнх нь хамааралтай байгаа.

Тэгэхээр энэ дээр Ардын Нам байна уу, Ардчилсан нам байна уу, Хүн нам байна уу, нам бусчууд байна уу бид энэ авлигаасаа салах ёстой. Хачигтай ингээд нэг ийм мал хүндэрчихдэг шиг салбар бүхэн дээр шимж байгаа. Тэр дундаа уул уурхай энэ том асуудал дээр шимэгчилж амьдарсан, хязгааргүй баяжсан, улс төрийг худалдаж авсан шүүхийг худалдаж авсан ийм нөхдүүдтэй бид нар нам харгалзахгүйгээр, эвлэрч болохгүйгээр тэмцэх ёстой. Ингэж байж бид нар шинэ 30 жилийн энэ асуудлыг ярих боломжтой болно.

Тэгэхээр би бас иргэддээ ч гэсэн уриалмаар байна. Ийм ятгалгад, ийм Пи Арт, ийм асуудалд битгий автаарай.

Авлигачид биднийг өрөвдөөгүй шүү. Бидний ирээдүйг хулгайлсан. Бид өрөвдөж болохгүй, ухарч болохгүй, уучилж болохгүй. Ингэж байж бид хамтдаа энэ тогтолцоог энэ системийн авлигын ард гарна. Тэгэхээр хамтдаа ингээд энэ асуудлаа цэгцэлье, тэгэнгүүт болье ялгаатай хандъя.

Сүүлийн үед бас жагсаал цуглаан их идэвхжилээ. Яасан ч айхтар бярттай хүн юм тэр Бадамжунай гэж хүн. Яасан ч их олон хүнээр нөлөөлүүлдэг тийм нөлөөтэй хүн юм. Би дахин хэлье. Ийм асуудлаас бид хамтдаа ухарч болохгүй. Тэгвэл бид Монголын ирээдүйн боломжийг хулгайлсантай адилхан зүйл болно. Улс төржиж болно. Гэхдээ ийм зүйл дээр улс төржимгүй байна.

Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Г.Занданшатар:** Би асуулт асуухгүй ээ, үг хэлнэ. Шинээр томилогдож байгаа сайдууддаа бас амжилт хүсье. Миний хувьд бас өөрийн харьяалагдаж байгаа Нийгмийн бодлогын байнгын хороон дээр Монгол Улсын Засгийн газраас өргөн бариад Их Хурлаар хэлэлцэх эсэх нь дэмжигдээд явж байгаа энэ нийгмийн даатгалын багц хуулийн асуудал дээр бас онцгой анхаарч ажиллах нь зүйтэй юм байна гэж ингэж бас бодож байгаа юм.

Яагаад гэвэл өнгөрсөн амралтын өдрүүд, ажлын өдрүүдэд Хэнтий, Дорнод, Сүхбаатарын аймгийн 1000 шахам иргэдтэй уулзаж, Улсын Их Хурдын гишүүн Анужин гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг, Нийгмийн бодлогын байнгын хорооноос өгсөн үүрэг чиглэлийн дагуу энэ иргэд олон нийтэд энэ нийгмийн даатгалын багц хуулийг танилцуулах ажлыг холбогдох яам, агентлагуудтай хамтарч зохион байгуулсан.

Энэ үнэхээр бас 30 жилийн өмнө батлагдсан энэ хууль 30 удаа өөрчлөлт орсон энэ асуудал, дээрээс нь энэ

нийгмийн даатгалын энэ систем дээр үүссэн олон хүндрэлүүдийг шийдэх ийм л хууль өргөн баригджээ гэдгийг энэ уулзалтад оролцсон хүн болгон хэлж байгаа юм.

Тэгэхээр энэ хууль цаашидаа явах ёстой хууль гэж ингэж бодож байгаа юм. Явуулахын тулд Монгол Улсын эдийн засгийн өнөөдрийн энэ өсөлт энэ эерэг үр дүн гарч байгаа энэ цаг үед явуулах ийм бас торгон хугацаа бас давхцаж байгаа юм болов уу даа гэж ингэж бас бодож байгаа юм.

Тэгэхээр Нийгмийн хамгааллын хөдөлмөрийн сайдаар Сангийн сайд дэд сайдаар ажиллаж байсан энэ Монгол Улсын эдийн засгийн төсөв хөрөнгө, энэ өсөлт бүх зүйлийг л бас алган дээрээ тавьсан юм шиг харж чадах ийм хүн томилогдож байгаа дээр энэ нийгмийн даатгалын багц хуулийг бас судалгаа юмыг нь хурдан оруулаад, эдийн засаг талаас нь сайн судлаад, Сангийн яамтайгаа сайн бас ойлголцоод энэ асуудлыг хурдан явуулбал энэ нийгмийн даатгалын энэ систем цаашаа сайхан хөгжөөд явах, эрүүл болох ийм бололцоо бүрдэж байгаа гэж ингэж бас харж байгаа.

Тийм учраас энэ томилогдож байгаа Булгантуяа сайдыг бас дэмжиж байгаа юм. Нөгөө талдаа Монгол Улсын Засгийн газраас энэ эдийн засгийн өсөлт энэ явуулж байгаа бодлогын хүрээнд энэ эдийн засаг эрүүлжиж байгаа энэ цаг үед төрийн албан хаагчдын энэ цалин цагааны асуудлыг бас эргэж харах, энэ ангиллуудыг цэгцлэх ийм чухал асуудлууд удахгүй бас хэлэлцэгдэнэ гэж ингэж бас ойлгож байгаа.

Тэгээд энэ цаг үед бид нар энэ төрийн албан хаагчдын цалингийн сүлжээ мөн тэр төрийн албан хаагчдын цалингийн сүлжээ дотроо төрийн үйлчилгээ гээд энэ зүйлүүдээ бас нэлээн сайн бодож, харж, үзэж, олон талаас нь бас судалж энэ асуудал руу хандахад мөн

дахиад л энэ улс орны эдийн засаг, энэ Сангийн яам, энэ төсөв хөрөнгийн нөхцөл байдалтай уялдах учраас таныг энэ дээр би нэлээн амжилт гаргана гэж ингэж бас итгэж байгаа. Энэ хууль, энэ төрийн албаны энэ цалин цагааны шинэчлэл дээр бас би нэлээн идэвх санаачилгатай ажиллаарай л гэж ингэж захих гэж байгаа юм.

Тулга сайдын хувьд Монгол Улсын “Шинэ сэргэлтийн бодлого”-ын нэг томоохон хүчин зүйл. Магадгүй бид нар улс дотроо эдийн засгаа хөгжүүлэхэд хамгийн том нөлөө үзүүлэхүйц энэ боомтын сэргэлтийн асуудал дээр та шинээр томилогдож байна. Сая Ерөнхий сайдын хувьд таны урьд өмнө төрд ажиллаж байсан тэр туршилагыг бас үндэслэж өнөөдрийн энэ сайдын албан тушаалд томилохоор танилцуулж байна гэсэн ийм зүйлийг хэлж байгаа.

Тэгээд та бүхэнд бас амжилт хүсье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох асуудлыг Монгол Улсын Ерөнхий сайд Улсын Их Хуралд танилцууллаа.

Тангараг өргөх ёслолын ажиллагаа шууд явчих уу? Томилчихсон бол тээ. Ингээд Засгийн газрын гишүүний тангараг өргөх ёслолын ажиллагааг эхэлбэ.

Засгийн газрын гишүүнийг томилох захирамж ёсчлогдож, зурагдаж, албажаад дараа нь тангараг өргөх ёслолын ажиллагаа эхлэх юм байна. Ингээд 10 минут завсарлана.

**Завсарлага**

**Г.Занданшатар:** Засгийн газрын гишүүдийн тангараг өргөх ёслолын ажиллагааг эхлүүлбэ.

Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ Засгийн газрын гишүүнээр томилсон тухай захирамжийг уншиж танилцуулна. Индэрт урьж байна.

**Л.Оюун-Эрдэнэ:** Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

2023 оны 4 сарын 7-ны өдрийн 68 дугаар тоот захирамжаар Буяагийн Тулгыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны даргаар, 69 дүгээр захирамжаар Хүрэлбаатарын Булгантуяаг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар тус тус томиллоо.

**Г.Занданшатар:** Одоо Засгийн газрын гишүүд тангараг өргөнө.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Буяагийн Тулга таныг тангараг өргөхийг урьж байна.

**Б.Тулга:** Монгол Улсын Засгийн газрын гишүүн би улсынхаа ашиг сонирхлыг эрхэмлэн, төрт ёс, түүх соёл, уламжлалыг хүндэтгэж, Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, төрийн хуулийг биелүүлэх ажлыг төр, ард түмэн, Монгол Улсын Ерөнхий сайдын өмнө биечлэн хариуцаж, Засгийн газрын гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая.

Миний бие энэ тангаргаас няцвал хуулийн хариуцлага хүлээнэ.

**Г.Занданшатар:** Одоо Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр,

нийгмийн хамгааллын сайд Хүрэлбаатарын Булгантуяа таныг тангараг өргөхийг урьж байна.

**Х.Булгантуяа:** Монгол Улсын Засгийн газрын гишүүн би улсынхаа ашиг сонирхлыг эрхэмлэн, төрт ёс, түүх соёлынхоо уламжлалыг хүндэтгэж, Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, төрийн хууль биелүүлэх ажлыг төр, ард түмэн, Монгол Улсын Ерөнхий сайдын өмнө биечлэн хариуцаж, Засгийн газрын гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая.

Миний бие энэ тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ.

**Г.Занданшатар:** Битгий төрийн ёслолын үйл ажиллагаа үймүүлээд бай.

Засгийн газрын гишүүд Улсын Их Хуралд тангараг өргөлөө.

Та бүхэнд баяр хүргэж, ажлын амжилт хүсье.

Тангараг өргөх ёслолын ажиллагаа өндөрлөснийг мэдэгдье.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

18.27 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР

